# ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ

# 2007 – 2015




Хархираа, 2007



Нээлттэй Нийгэм Форум

Орон нутгийн удирдлага ба төрийн үйлчилгээг шинэчлэх санаачлага

Бодлого судлалын төв

Тариалан сум

Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн «Орон нутгийн удирдлага ба төрийн үйлчилгээг шинэчлэх санаачлага» хөтөлбөр, Нээлттэй Нийгэм Форум болон Бодлого Судлалын Төвийн дэмжлэгтэйгээр Увс аймгийн Тариалан сумын төр захиргаанаас сумынхаа иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүд, тэдгээрийн төлөөлөлтэй хамтран оролцооны зарчмаар энэхүү стратегийг боловсруулав. Нээлттэй Нийгэм Хүрээлэн, «Орон нутгийн удирдлага ба төрийн үйлчилгээг шинэчлэх санаачлага», Нээлттэй Нийгэм Форум энэхүү стратегийн агуулга, мэдээллийн баталгаажилт, чанарын талаар хариуцлага хүлээхгүй.

DDC
338.9'517
Э-17

ISBN 978-99929-0-376-7

Хянан тохиолдуулсан: Б.Мөнхсоёл, С.Амгаа, С.Цолмон, Ц.Гомбосүрэн, Б.Эрдэнэбаатар

Эхийг бэлтгэсэн: Ч.Эрдэнэбат
Хавтасны дизайнер: Ц.Одончимэг

Хэвлэсэн газар: «ADMON» ХХК, Монгол

© Зохиогчийн эрхийг Увс аймгийн Тариалан сумын ЗДТГ эзэмшинэ.

# Гарчиг


Өмнөтгөл . . . v

Товчилсон үг . . . vi

Өмнөх үг . . . vii

Оршил . . . ix

**Бүлэг 1. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн нийтлэг асуудлууд . . . 1**

1.1. Сумын эдийн засгийн хөгжилд стратегийн ач холбогдол . . . 1

1.2. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн үндэслэл . . . 3

1.3. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн агуулга, мөн чанар . . . 5

**Бүлэг 2. Стратеги боловсруулах үйл ажиллагаа . . . 7**

2.1. Үндсэн зарчим, арга зүй . . . 8

2.2. Стратеги боловсруулахад баримталсан зохион байгуулалтын ба зохицуулалтын арга хэмжээ . . . 9

2.3. Олон нийтийн оролцоо ба зөвшилцөл . . . 13

2.4. Бизнесийн орчны судалгаа . . . 14

2.5. СВОТ шинжилгээ . . . 15

2.6. Алсын хараа-зорилго-зорилт-хөтөлбөр-төсөл . . . 16

2.7. Хүлээгдэж буй үр дүн . . . 18

2.8. Стратегийн хэрэгжүүлэлт . . . 19

2.9. Стратеги хэрэгжүүлэх зохион байгуулалтын асуудлууд . . . 20

2.10. Стратегийн санхүүжилт . . . 20

**Бүлэг 3. Увс аймгийн Тариалан сумын танилцуулга . . . 21**

3.1. Газар зүй, цаг уурын нөхцөл, байгалийн нөөц баялаг . . . 22

3.2. Эдийн засгийн үндсэн ба туслах салбар . . . 23

3.3. Хүн ам зүй, хүний нөөц, чадавхи . . . 25

3.4. Орон нутгийн удирдлагын зохион байгуулалт . . . 27

3.5. Гадаад, дотоод харилцаа . . . 29

3.6. Ахуй, соёл, иргэншил, үндэсний онцлог . . . 29

**Бүлэг 4. Сумын эдийн засгийн хөгжлийн тойм, хэтийн төлөв. . . . 30**
4.1. Сумын эдийн засгийн хөгжлийн одоогийн байдал, хэтийн төлөв . . . 30
4.2. Дэд бүтэц, үйлчилгээ . . . 35
4.3. Зах зээл, маркетинг . . . 36
4.4. Суманд хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүд . . . 37

**Бүлэг 5. Сумын эдийн засгийн хөгжлийн стратеги . . . 39**
5.1. Бизнесийн орчны судалгааны дүн. . . . 39
5.2. СВОТ шинжилгээ. . . . 44
5.3. Сумын хөгжлийн стратегийн алсын хараа, зорилго . . . 47
5.4. Алсын хараа-зорилго-зорилт-хөтөлбөр-төслийн матриц . . . 48
5.5. Стратегийн хэрэгжилтийн матриц . . . 51
5.6. Төслийн эрэмбэлсэн матриц . . . 58
5.7. Бизнесийг дэмжих стратегийн чиглэлүүд . . . 61
5.8. Төслийн товч танилцуулга. . . . 65

# Өмнөтгөл

Монгол шиг шилжилтийн эдийн засагтай орнуудын хөгжлийн тэргүүлэх зорилгуудын тоонд шинээр төрөн гарч буй хувийн хэвшлийнхэнд зориулж бизнес эрхлэх тааламжтай орчин бүрдүүлэх, орон нутгийн эдийн засгийн хөгжилд (ОНЭЗХ) зориулсан нэгдмэл, олон талт төлөвлөгөөг өөрсдийн санаачилгаар боловсруулах явдал ордог.

Сүүлийн жил гаруй хугацаанд Нээлттэй Нийгэм Хүрээлэн болон Нээлттэй Нийгэм Форумаас Монгол улсын 4 суманд орон нутгийн ард иргэдийн цаашдын хөгжлийн хэрэгцээгээ илүү сайн төлөвлөж, удирдах чадавхийг бэхжүүлэх ажлыг санаачилан хэрэгжүүлж байна. Энэхүү «Оролцогчдын хамтын ажиллагаанд тулгуурлан орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх нь» (DELTA) хэмээх төслийг өмнө нь ННХ, Дэлхийн Банкнаас Зүүн Европт хэрэгжүүлсэн туршлагад үндэслэн хэрэгжүүлсэн юм. Үүний үндсэн санаа нь орон нутгийн хүн амын томоохон бүлгүүд, түүний дотор төр засаг, хувийн хэвшил, иргэний нийгмийнхэн хамтран хөгжлийн таатай нөхцөл, боломжуудыг шинжлэх, алсын хараа, зорилго, зорилтуудаа тодорхойлох, улмаар тэдгээрт хүрэхэд чиглэсэн тодорхой, ач холбогдол бүхий төсөл, алхмуудыг боловсруулж гаргахад оршиж байсан юм.

Таны өмнө байгаа стратегийн баримт бичиг болон түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа нь тус төслөөс гарч буй хамгийн анхны биет үр дүнгүүд юм. Харин сумын түвшинд бий болоод байгаа хөгжлийн шинэ түншлэлүүд, тухайн сумдын «бизнес эрхэлж» байгаа шинэ арга барил буюу илүү олныг хамарсан, оролцоот хэлбэр нь нүдэнд тэр бүр ил харагдахгүй үр дүнгүүд юм. Цаашид энэхүү төлөвлөлтийн арга зүйг бусад янз бүрийн шийдвэр гаргах үйл явцад хэрэглэх боломжтой, хэрэглэх ч ёстой юм.

Энэ завшааныг тохиолдуулан Увс аймгийн Тариалан сумын ард иргэд, Бодлого судлалын төвийнхөн болон энэхүү стратегийг амжилттай боловсруулахад хувь нэмрээ оруулсан бусад бүх мэргэжилтнүүдэд талархлаа илэрхийлэхийг хүсч байна.

П.Эрдэнэжаргал
Нээлттэй Нийгэм Форумын
Гүйцэтгэх захирал

Скотт Абрамс
Будапештийн ННХ-ийн Орон нутгийн
захиргаа, төрийн албаны шинэчлэлийн
санаачилгын Орлогч захирал

# Товчилсон үг

| | |
|---|---|
| ОХАТОНЭХ | Оролцогчдын хамтын ажиллагаанд тулгуурлан орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх |
| ОНЭЗХС | Орон нутгийн эдийн засгийн хөгжлийн стратеги |
| ЖДҮ | Жижиг дунд үйлдвэр |
| ДЕЛТА | «Оролцогчдын хамтын ажиллагаанд тулгуурлан орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх» төслийн англи нэрийн эхний үсгийн хураангуй |
| СЭЗХС | Сумын эдийн засгийн хөгжлийн стратеги |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ИТХ | Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ИТХТ | Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид |
| ААН | Аж ахуйн нэгж |
| ХХААГ | Хүнс, хөдөө аж ахуйн газар |
| ННФ | Нээлттэй Нийгэм Форум |
| ОНУТҮШС | Орон Нутгийн Удирдлага, Төрийн Үйлчилгээг Шинэчлэх Санаачлага |
| БСТ | Бодлого Судлалын Төв |



# Өмнөх үг

Тус сум 4900 гаруй хүн ам, 1100 орчим өрхтэй, 135.8 мянган толгой малтай. Засаг захиргааны 6 багтай, үүнээс 3 багт нь цэцэрлэг, сургууль, хүн эмнэлгийн салбар ажилладаг. Ард иргэд нь мал аж ахуй, газар тариалан хослон эрхэлдэг, сүүлийн үед уул уурхайн салбар нэлээд эрчимтэй хөгжиж, жимс жимсгэнэ, чацаргана тариалах, фермер, суурин аж ахуй бий болох хандлага давамгайлж байгаа сум юм.

Хүн амын 85.6 хувь нь үндэсний цөөнх хотон ястан. Бий хуур, ардын урлаг, соёл, ажилч хөдөлмөрч зан чанараараа улсдаа алдаршсан, шашны өвөрмөц зан үйлтэй, байгаль, цаг уурын эрс тэс байдал, Хархираа, Мянган, Хөхийн сүрлэг өндөр уул, нуурын хөвөөний нам дор газрын аль алинд дасан зохицсон амьдралтай ард түмэн билээ.

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилт дуусах тийш хандаж, улс орны эдийн засгийн хөгжлийн явц тэнцвэржих, эдийн засгийн өсөлт бий болж тогтворжих хандлага бодитой үйл явц болж өрнөж байгаа өнөөгийн нөхцөлд орон нутгийн эдийн засгийн хөгжлийн хэтийн чиглэлийг оновчтой зөв тодорхойлох шаардлага бидэнд тулгарсан юм. Монгол улсын хөгжлийн энэхүү зурвас үед Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн «Орон нутгийн удирдлага, төрийн үйлчилгээг шинэчлэх санаачлага» хөтөлбөр, Нээлттэй Нийгэм Форумоос сумын эдийн засгийн хөгжлийн стратеги боловсруулах «Оролцогчдын хамтын ажиллагаанд тулгуурлан орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх - ДЕЛТА» төслийг тусгай шалгуураар сонгосон зарим сумдад хэрэгжүүлсний дотор Увс аймгийн Тариалан сум багтсан билээ. 330 гаруй сумдаас ДЕЛТА төслийг хэрэгжүүлэхээр шалгаран сонгогдож, сумынхаа хүч бололцоог дайчлан ажилласныхаа хүчинд сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн иж бүрэн баримт бичгийг боловсруулан гаргалаа. Ингэснээр орон нутгийн эдийн засгийн хөгжлийг цэгцтэй бодлого, уялдуулан зохицуулсан стратеги, олон нийтийн чин хүсэл, идэвхтэй оролцоонд тулгуурлан хөгжүүлэх асуудлыг үлгэр жишээчээр шийдвэрлэх боломж бидний өмнө нээгдэж байна.

Энэхүү стратегид тус сумын ард иргэдийн хөдөлмөрч, авъяаслаг зан чанар, үзэсгэлэнт газар нутаг, уламжлагдан ирсэн ардын язгуур урлаг, бий хуурын өлгий нутаг болсон хотон зон олноо түшиглэн сумынхаа эдийн засгийн чадавхийг хөгжүүлэх, үүнд сум орноо гэсэн чин сэтгэлтэй нутгийн уугуул суугуул иргэд, эрдэмтэн судлаачид, аж ахуйн нэгж, албан байгууллагууд, оюутан сурагчдын идэвх

санаачлага оролцоог нэмэгдүүлэх, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, төрөлх нутагтаа бүтээлчээр зорилготой амьдран эдийн засгаа хамтран хөгжүүлэх орчинг бүрдүүлэх зорилго оршиж байна. Орон нутгаа хөгжүүлэхийг эрмэлзсэн олон нийтийн нийтлэг зорилго, хөгжлийн шинэ эринд алхан орох хүрэх хүсэл тэмүүллийг оновчтой томъёолсон эдийн засгийн хөгжлийн стратеги боловсруулах ажлын хүрээнд сумын төр, захиргаа ба хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх, хөгжлийн үйл явцад олон нийтийн оролцоо, хувь нэмрийг өргөжүүлэх замаар сум орны бизнесийн цаашдын хөгжилд нэн таатай орчныг бүрдүүлэхэд ДЕЛТА төсөл зүй зохих ёсоор нөлөөлснийг талархалтайгаар тэмдэглэж байна.

Хувийн хэвшлийг дэмжихэд төрийн зүгээс үзүүлэх үйлчилгээ, бизнесийн орчныг сайжруулах олон талт зорилго, зорилтуудыг нягт уялдуулан төлөвлөсөн учраас энэхүү стратегид тусгагдсан төслүүд, бизнес хөгжүүлэх чиглэлүүдийг амьдралд бодитой хэрэгжүүлэх нь жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах зэрэг үндэсний хөгжлийн зангилаа асуудлыг орон нутагт бодитой хэрэгжүүлэх боломж олгож буйн зэрэгцээ сумын төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмэр үзүүлнэ.

Манай сум ирээдүйд өвөрмөц хурдацтай хөгжих шинжийг агуулсан байдаг. Учир нь гэвэл аймгийн төвд ойр учир Улаангом хотыг төрөл бүрийн бүтээгдэхүүнээр хангах олон төрлийн үйлдвэр байгуулах, ер нь цаашид биеэ даан хөгжих бололцоотой гэж үздэг. Сумын төр, захиргаа эдийн засгийн хөгжлийн төлөө эрх үүргийнхээ дагуу хариуцлагаа хүлээн манлайлан оролцох боловч эрчимтэй хөгжиж буй энэ нийгэмд нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлагаар орон нутаг эдийн засгаа бие даан хөгжүүлэх боломж арга замыг судлан эрэлхийлж хэрэгжүүлэх ёстой.

Орон нутагт, түүний дотор сумдад үйлдвэрлэл, үйлчилгээ дорвитой хөгжихгүй байгаагийн нэг шалтгаан нь төсөв, санхүүжилтийн эх үүсвэр байнга дутагддаг явдал юм. Энэхүү стратегийг хэрэгжүүлэхэд өөрийн хүч хөдөлмөр, мэдлэг чадвар, туршлага, нөөц боломжоо дайчлах тус сумынхны чин сэтгэл, идэвх санаачлага, зүтгэл хамгаас чухал хэдий ч засгийн газар, хандивлагчид, олон улсын байгууллага, санхүүгийн түншүүд, хөрөнгө оруулагчдын санхүүгийн ба техникийн тусламж, дэмжлэггүйгээр үр дүнд хүрэх боломж нэн хомс юм.

Үүний учир энэхүү товхимлыг өргөн толилуулахын ялдамд манай сумын эдийн засгийн хөгжил, хүн ардын сайн сайхны төлөө бидэнтэй хамтран ажиллах талаар хандивлагчид, хөрөнгө оруулагчид, санхүүгийн ба иргэний нийгмийн байгууллагуудаас гаргасан аливаа санал санаачлагыг бүрнээ хүлээн авч дэмжин ажиллах болно гэдгээ илэрхийлж байна.

Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийг боловсруулахад гүн туслалцаа үзүүлсэн ННХ, ННФ, БСТ-ийн удирдлага, ажилтнууд, зөвлөхүүд болон бусад хүмүүст сумын төр захиргаа, нийт иргэдийг төлөөлөн гүн талархал дэвшүүлж байна. Мөн нэг баг болж хамтран ажилласан Ц.Гомбосүрэн, Ч.Сүрэнхорлоо, М.Лхагвасүрэн нарт болон сумынхаа аж ахуйн нэгж, төрийн ба иргэний нийгмийн байгууллагууд, иргэддээ талархлаа илэрхийлье.

Сумын маань нутгийн захиргаа бие даасан, иргэдийн оролцоо нь ил тод дэмжигдэн ажил үйлс өрнөн хэрэгжих болтугай гэж ерөөе.

Увс аймгийн Тариалан сумын Засаг дарга С.Цолмон

# Оршил

Монгол улсыг бүхэлд нь хамарсан эдийн засаг-нийгмийн шинэчлэлтийн хүрээнд тус сумын хөгжлийн хүрсэн түвшинг хадгалах, цаашид ахиулах, үр ашгийг нь олон нийтэд жигд хүртээхэд сумын төр, захиргааны байгууллага, бизнес эрхлэгчид түлхүү анхаарах явдал хойшлуулшгүй зорилт болж байна. Ирээдүйд хөгжил өргөжин тэлэх суурь болох шинэ зах зээлд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх асуудал хөгжлийн шинэ зорилготой холбогдон сумынхны өмнө чухлаар тавигдах боллоо.

Зах зээлд шилжих шилжилтийн явцад болон түүний дараах жилүүдэд сумын эдийн засгийн хөгжил, бизнесийн бүтэц, чадавхид олон чухал дэвшил, өөрчлөлтүүд бий болсон бөгөөд энэ үйл явц одоо ч үргэлжилсээр байна. Зах зээлд шилжихээс өмнө төрийн ба хоршооллын өмчийн том аж ахуйнууд үйлдвэрлэл, үйлчилгээнд давамгайлж байсан бол эдүгээ хувийн өмчид суурилсан жижиг, дунд үйлдвэрлэл энэхүү байр суурийг эзэлсэн явдал эдийн засаг, бизнесийн хөгжлийн асуудлыг шинэлэг арга барилаар авч үзэх бодит шаардлагыг бий болгож байгаа хүчин зүйл юм.

Эдийн засгийн тогтвортой хөгжлийг сумын түвшинд хангахад туслалцаа дэмжлэг авах, санхүүжилтийн эх үүсвэр олохын тулд хандивлагчид, хөрөнгө оруулагчдыг татах дорвитой арга хэмжээ хэрэгжүүлж, амьд ажил өрнүүлэх цаг үе ирээд байна. Төр-хувийн хэвшлийн түншлэлийг орон нутгийн бизнес орчныг сайжруулах чиглэлд улам гүнзгийрүүлэх хэрэгтэй байна.

Сумын төр, захиргаа, төрийн үйлчилгээний байгууллагуудаас дүрэм журам, зохицуулалт гаргахдаа сумынхаа эдийн засгийг цэцэглүүлэн хөгжүүлэхийн тулд бизнес эрхлэгчдээс идэвхтэй үйл ажиллагаа явуулах боломжийг хангах, тэдэнд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх явдлыг эн тэргүүнд тавьдаг байх зүй ёсны шаардлага төдийгүй шинэ хандлага, шинэ арга барилын үндсийн үндэс болох учиртай.

Сумынхаа бизнесийг идэвхжүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлт бий болгох, хүн амын амьдралын чанарыг тасралтгүй сайжруулахад орон нутгийн бизнесийн өрсөлдөх чадвар, бүтээмжийг дээшлүүлэх шинэ үзэл баримтлал, шинэлэг арга замаар хандах нэн төвөгтэй үүрэг хариуцлагыг орон нутгийн удирдлага, бизнес эрхлэгчид өөртөө хүлээх шаардлагатай боллоо.

Ийм нөхцөлд одоо үйл ажиллагаа явуулж буй бизнесийг тогтворжуулан чадавхижуулах, шинээр бизнес эрхлэх, хөрөнгө оруулалтыг татах харьцангуй таатай нөхцлийг бүрдүүлэх явдлыг сумын захиргаа стратегийн зорилтын хэмжээнд тавьж ажиллах ёстой юм. Цаад агуулгаараа, энэ нь нөөц боломжоо орон нутгийнхаа хөгжлийн төлөө зохистой ашиглах, хэрэглэгчдийн эрэлт таашаалд

нийцсэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг зах зээлд гаргах тэргүүлэх ач холбогдол бүхий чиглэлүүдээ оновчтой тодорхойлох, энэ дагуу дунд хугацаанд хэрэгжүүлэх стратегийг иж бүрнээр боловсруулахад сумынхан өөрсдөө ихээхэн хүчин чармайлт гаргах шаардлагатай гэсэн үг. Сумын эдийн засгаа амжилттай хөгжүүлж, тогтворжуулах асуудалд ийн хандваас бүх боломж, нөөцөө хамгийн ухаалгаар үр өгөөжтэй ашиглах арга замаа олж сая чадна.

Сумын эдийн засгийн хөгжлийн стратеги (ЭЗХ)-ийн зорилго, зорилт, төслүүдийнхээ харилцан уялдааг сайтар хангах асуудлыг олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааны үндсэн дээр гүйцэтгэх, түншүүд, оролцогчдын чадавхи, чин эрмэлзлийг тусгасан байх зарчмыг стратеги боловсруулах явцад барьж ажиллав. Ийнхүү нийтээр чармайн ажиллах замаар сумын эдийн засгийн хөгжлийн стратеги боловсруулах ажлаа амжилттай дуусгалаа. Эдийн засгийг хөгжүүлэх, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд сумынхны бүх бүлэг, давхарга өөрийн оролцоо, хувь нэмрээ оруулах боломжийг энэ стратеги бүрдүүлж өгснийг тэмдэглэх нь зүйтэй.



# БҮЛЭГ 1

# СУМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН НИЙТЛЭГ АСУУДЛУУД

## 1.1. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн ач холбогдол

Юуны өмнө, сумын эдийн засгийн хөгжлийн иж бүрэн стратегитэй болсон явдал ДЕЛТА төслөөс тус суманд үзүүлсэн бодитой дэмжлэгийн шууд үр дүн мөн гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Сумын удирдлага, бизнес эрхлэгчид, иргэд орон нутгийнхаа хөгжлийн тэргүүлэх ач холбогдол бүхий асуудлаар «ямар ч түвшинд хүнтэй нүүр улайхгүй тулж ярих, хэлцэх» нэн чухал боломжоор хангагдлаа хэмээн стратегийнхээ ач холбогдлыг зангидан томъёолж байна. Сумынхны хүсэл тэмүүлэл, чин эрмэлзлийг тусгасан «Эдийн засгийн хөгжлийн дунд хугацааны стратеги» нь хөгжлийн асуудлаар өргөн хүрээтэй түншлэл, хоршилт, хамтын ажиллагааг өрнүүлэх хэтийн удирдамж болохоос гадна сумын эдийн засаг-нийгмийн хөгжлийн явц, өрнөлийг үнэлэх, дэвшигдэн буй

шинэ зорилго, зорилтыг олон нийтийн оролцоотойгоор тодорхойлон шийдвэрлэж байх шаардлагад төгс нийцсэн баримт бичиг болж чадсан юм.

Сумын хөгжлийн ирээдүйн чиг баримжаатай холбоотой үзэл баримтлалын ба стратегийн чиглэлүүдийг тодорхойлох, шинэчлэн томъёолох хэрэгцээ шаардлага цоо шинээр гарч ирээгүй, ДЕЛТА төслөөс өмнө ч гэсэн яригддаг байсан билээ. Хамгийн гол нь сумын төр, захиргааны ба орон нутагт төрийн үйлчилгээ эрхлэх байгууллагуудын хувьд олон жилийн өмнөөс тулгамдсаар ирсэн энэ асуудлыг зохистой шийдвэрлэж хараахан чадаагүй явж ирсэнд хэргийн учир оршиж байгаа юм. Энэ талаас нь авч үзвэл, ДЕЛТА төслийг манай суманд хэрэгжүүлсэн нь цаг үеэ олсон чухал үйл явдал болсон билээ.

Иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, төрийн үйлчилгээний шуурхай байдал, хүртээмжийг сайжруулах, орон нутгийн бизнесийн хөгжил, эдийн засгийн өсөлтийг хангах орчинг бүрдүүлэх, орон нутгийн бизнесийг дэмжихэд сумын удирдлагын зүгээс тавьж буй хүчин чармайлтыг оновчтой чиглүүлэх асуудал бодитой тулгарахын цагт үр өгөөжтэй, хэрэгжих боломжтой стратегийг хэтийн баримжаатай боловсруулах арга зүйн ба мэргэжлийн дэмжлэг, мэдээлэл дутагддаг, тэр чинээгээр сумын хөгжил удаашрахад хүрдэг байсан юм.

Орон нутгийн эдийн засгийг зах зээлд нийцүүлэн салбарлуулан өргөжүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг зохистой өөрчлөх талаар сумын төр, захиргааны зүгээс зохих хүчин чармайлт тавьж ирсэн билээ. Хамгийн гол нь бүтээлч түншлэл, өргөн хамтын ажиллагааны хүрээнд сумын эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх зохистой механизм бий болгох, зах зээлийн зөв гольдролд оруулахад тэдгээр арга хэмжээ төдийлэн үр бүтээлтэй болж чадаагүй юм.

Эдүгээ суманд байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний бизнес тэр бүр санасан хэмжээгээр өргөжин тэлэхгүй, шинээр бизнес эрхлэх санаачлага оролдлого бүхэн ажил хэрэг болж хараахан чадахгүй байгаа нь бизнесийн өсөлтийг дэмжих санхүүгийн найдвартай эх үүсвэр дутмаг байгаатай холбоотой. Түүнээс гадна бизнес эрхлэх орчин нь бизнесийн чадавхийг дээшлүүлэхэд тэр бүр тааламжтай бус байгаа явдал зохих сөрөг нөлөөтэй гэж дүгнэж болно.

Ер нь сумын төр, захиргаа нь эдийн засгийн хөгжил, бизнесийн дэвшлийг идэвхгүй ажиглагч юм уу хөндлөнгөөс шууд оролцогч биш, харин эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлт, амьдралын чанарыг дээшлүүлэх гол нөхцөл болох бизнесийг хөгжүүлэхэд эрхзүйн зохицуулалт, шаардлагатай бусад дэмжлэг үзүүлдэг, үйл ажиллагаандаа хамтын ажиллагааны зарчмыг хэрэгжүүлэхийг бүх талаар эрмэлздэг, өөрөө санаачилдаг, олон нийтийг манлайлан чиглүүлдэг түнш байхыг туйлаас эрхэмлэх цаг ирээд байна.

Сумын төр, захиргаа нь янз бүрийн сонирхол бүхий бизнесийн ба иргэний нийгмийн бүлгүүдийг хөгжлийн асуудал дээр зохион байгуулж төвлөрүүлэх, хамтран ажиллах арга хэлбэрээр тэднийг дэмжих бүрэн чадавхитай байгууллага мөн болохыг стратеги боловсруулах явцад хуримтлуулсан туршлага маань харууллаа. Олон улсын байгууллагаас үзүүлсэн дэмжлэгийн ачаар орон нутагтаа бизнесийг дэмжин хөгжүүлэх үйл ажиллагааг үр ашигтай зохион байгуулах, зохицуулахад сумын төр, захиргааны зүгээс явуулах үйл ажиллагааны механизмаа тодорхойлж авлаа, шинээр сэтгэх, ажиллах таатай нөхцөл бүрдлээ.

ДЕЛТА төслийг хэрэгжүүлэхэд оролцсон хандивлагч ба хэрэгжүүлэгч байгууллагууд, төслийг гүйцэтгэгчид бидний хамтын чармайлтаар бүтсэн эдийн засгийн хөгжлийн стратеги маань манай сумын эдийн засаг, бизнес цэцэглэн хөгжих баталгаа болж чадсан гэдэгт гүнээ итгэж байна.

## 1.2. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн үндэслэл

Сумынхнаа олон нийтийн чин эрмэлзэлд тулгуурлан тэдний идэвхтэй оролцоо, дэмжлэгтэйгээр анх удаа боловсруулсан сумын ЭЗХ-ийн стратеги нь орон нутгийн эдийн засаг ба бизнесийн хөгжлийг дэмжих орчинг боловсронгуй болгох талаар тулгамдаж буй болон ирээдүйн чиг хандлагатай холбоотой нэн тэргүүний асуудлыг оролцооны зарчимд тулгуурлан тодорхойлох хамгийн дөхөмтэй, хэрэгжих боломжтой арга замыг эрэлхийлсэн хамтын хүчин зүтгэлийн үр дүн билээ. Тэргүүлэх ач холбогдолтой хэмээн хамтаараа тодорхойлсон зорилгоо амжилттай хэрэгжүүлснээр стратегийн үр шимийг олон нийтэд хүртээх, олон нийтийн зүгээс зүй зохистой хүртэх суурь нөхцлийг бүрдүүлж чадах юм.

Орон нутгийн хөгжлийн бодлого, төрийн үйлчилгээг сумын төр, захиргаанаас хэрэгжүүлж буй арга зам, хэлбэр нь эргээд эдийн засгийн дотоод боломж, давуу байдал, гадаад таатай нөхцлийг аль болох өгөөжтэй ашиглах, бизнесийг тогтоон барих, өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр явуулах үйл ажиллагааны чанар, үр дүнд шууд болон дам нөлөө үзүүлдэг, тэр чинээгээр орон нутгийн эдийн засаг, бизнест зайлшгүй харгалзах хүчин зүйл юм.

Бизнес эрхлэгчид, байгууллага, иргэдэд тэгш үйлчлэх зохистой орчинг бүрдүүлэх явдал төр, захиргааны үндсэн зорилго мөн. Үнэн чанартаа аливаа бизнесийн хүрээ, түүний хэмжээ далайц бол бизнеийн орчныг бизнестэй холбодог хүчин зүйл хараахан биш. Энэ ч учраас сумын ЭЗХ-ийн стратеги боловсруулах явцад өмчлөл, зохион байгуулалтын хэлбэр, хэмжээгээр нь ялгаварлахүйгээр үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй иргэд, бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллах нийтлэг зарчмыг сумын төр, захиргаанаас баримталсан болно.

Орон нутгийн төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, сумын эдийн засгийн хөгжилд таагүй нөлөөлж байгаа, нөлөөлж болзошгүй орчны болон бусад хүчин зүйлсийг залруулах, зөөлрүүлэх, саад бэрхшээл, эрсдэлийг багасгах, даван туулах арга замыг агуулгын болоод хэлбэрийн хувьд оновчтой сонгоход стратегийн үндсэн баримжаа чиглэсэн болно. Стратегийн гол томъёолол, бүтцийг эцэслэн боловсруулахаас өмнө явуулсан бизнес орчны судалгаа болон СВОТ шинжилгээ нь эдийн засаг, бизнесийн хөгжлийн одоогийн байдал, хүрсэн түвшинг тодруулах, хэтийн чиглэл хандлагын талаар сумынхны үнэлэмж, төсөөллийг харуулсан суурь мэдээлэл бүрдүүлэхэд ач холбогдолтой боллоо.

Сумын төр, захиргаа болон олон нийтийн хамтын хүчин чармайлтын бодит үр дүн, эдийн засгийн хөгжлийн илүү өндөр түвшинд хүрэхийн төлөө иргэд, бизнесийнхэн, төр, олон нийтийн байгууллагуудын нийтлэг хүсэл тэмүүлэл, ирээдүйн тухай санал төсөөллийг төлөөлж байгаа гэдэг үндэслэлээр бидний боловсруулсан дунд хугацааны стратегийн агуулгыг нь тодорхойлох боломжтой.

Сумынхаа орчмын бүс нутгийн хүний ба байгалийн нөөц, эдийн засгийн хөгжлийн өнөөгийн ба ирээдүйн төлөв байдал, соёл, түүхийн өв сан зэрэг чухал ач холбогдол бүхий хэд хэдэн хүчин зүйлсийг стратеги боловсруулахад харгалзан үзсэн болно. Эцэст нь, манай сумын харьцангуй давуу талууд, олон нийтийн идэвх зүтгэл, чин эрмэлзэлтэй холбоотой аливаа боломж бүхнийг стратегид тусгахыг эрмэлзлээ.

«Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай» хуулийн 8 дугаар зүйлийн 1-д «Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь ...нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж...», «Сум, дүүргийн Хурал нь тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх эрхтэй», мөн хуулийн 18.1.2-ийн «а»-д «нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн болон жилийн үндсэн чиглэлийг батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах;» хэмээн заасан нь сумын ЭЗХ-ийн стратеги боловсруулах эрх зүйн үндэслэл болж өглөө.

Хувийн хэвшлийнхнээс ихээхэн идэвх чармайлт, санаачлага гаргаж сумын төр захиргаатай хамтран ажиллаагүйсэн бол стратеги боловсруулах тухай бодохын ч хэрэггүй байсныг зориуд тэмдэглэн хэлэх нь зүйтэй. Стратеги боловсруулах үйл ажиллагаа нь өөрөө сумынхны дунд зохих хүлээлт бий болгосон төдийгүй хүлээлтээ амжилттай, бодит үр өгөөжтэй ажил хэрэг болгох, стратегийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүлээх үүрэг хариуцлагын талаар энэ ажилд оролцсон, хувь нэмрээ оруулсан хүмүүс нийтлэг ойлгоцтой боллоо

.

Бүтээлч хамтын ажиллагаа, хүчин чармайлтын үр жимс болсон стратеги маань амжилттай хэрэгжинэ гэдэгт сумын төр, захиргааны байгууллага, иргэд, бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн байгууллагууд бүрэн итгэж байна. Стратегид тусгасан төсөл, бизнесийн хөгжлийг дэмжих чиглэлээ үр дүнтэй хэрэгжүүлэх замаар алсын хараа, зорилго, зорилтдоо хүрэхэд байгаа нөөц боломжоо туйлын зохистой хуваарилан ашиглах болон чадавхи, давуу талаа хариуцлагатай зохицуулах асуудал олон нийтэд үр өгөөжийг хүртээх боломжийг хангах талаасаа нэн чухал гэдгийг цохон тэмдэглэж байна.

Тариалан сумын эдийн засгийн хөгжлийн стратегийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн 2007 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж сумын хөгжлийн дунд хугацааны чиг баримжаа, ялангуяа бизнес хөгжих орчин, төрийн үйлчилгээг шинэ шатанд гарган сайжруулах алсын харааг оновчтой томъёолж, энэ хүрээнд стратегийн зорилго, зорилтууд, төслүүдийг зөв тодорхойлж чадсан гэж үзэн санал нэгтэй сайшаан баталлаа.

## 1.3. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн мөн чанар, агуулга

Бизнесийн орчинг цаашид улам сайжруулж, боловсронгуй болгоход олон нийтийн оролцоо, хүчин чармайлтыг дэмжин идэвхжүүлэх, орон нутгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг харгалзан хандивлагчид, хөрөнгө оруулагчдаас дэмжлэг туслалцаа үзүүлж болох гол чиглэлүүдийг оролцооны зарчмаар тогтоосон явдал стратегийн үндсэн агуулгыг тодорхойлж байна. Орон нутагтаа бизнес хөгжүүлэх орчныг сайжруулахад тулгамдаж буй цаг үеийн ба хэтийн шийдвэрлэвэл зохих асуудлуудын талаархи олон нийтийн мэдлэг, хандлага дээр тулгуурлан стратегийг боловсруулсан нь түүний мөн чанарыг илэрхийлнэ.

Арга зүйн хувьд орон нутгийн эдийн засгийн хөгжлийг төлөвлөхөд баримталж байгаа сүүлийн үеийн үзэл баримтлал, онол-практикийн үндсэн асуудлуудыг стратеги боловсруулах ажиллагааны бүх шатанд харгалзсан болно.

Тариалан сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн гол зарчмыг товчлон тодорхойлбол:

- Дунд хугацааны стратегийн хэрэгжилтийг хангах асуудлыг сумын төр, захиргаа, иргэд, бизнесийн ба олон нийтийн байгууллагатай бүх түвшинд холбох замаар эдийн засгийн тогтвортой өсөлт бий болгох, төрийн зүгээс үзүүлэх үйлчилгээг чанаржуулах,

- Бизнесийг өргөжүүлэх, салбарлуулан хөгжүүлэх, шинээр бизнес эхлэхэд бизнесийн орчноор дамжуулан сумын төр, захиргаанаас үзүүлэх дэмжлэгтэй холбоотой төслүүдийг оролцогчдын туршлага мэдлэг, санал төсөөлөл дээр үндэслэн тодорхойлох,
- Орон нутгийн бодлого боловсруулагчид, бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг нэгтгэх замаар хөгжлийн алсын хараа, нийтлэг зорилгоо стратегийн хэлбэрээр тодорхойлох жишээг сумын олон нийтэд бодитойгоор харуулах,
- Орон нутгийн эдийн засгийн хөгжлийн дэвшлийг хангах, өсөлт бий болгох, олон нийтийн бүтээлч оролцоо, хувь нэмрийг өргөжүүлэхэд оролцогчдыг хөтлөх хэрэглүүр болох талаас нь стратеги төлөвлөлтийг таниулан ойлгуулах,
- Санхүүгийн ба техникийн дэмжлэг үзүүлдэг хандивлагчид, хөрөнгө оруулагчдад хандах, нөлөөлөх арга хэрэглүүр болгон ашиглах үндэслэл, боломжтой нь холбон стратегийг хүлээн авах нийтлэг хандлага ойлголтыг олон нийтийн дунд бэхжүүлэх,
- Хамтач уур амьсгалыг бэхжүүлж, нээлттэй, ажил хэрэгч байдлыг хангах, эдийн засаг, бизнесээ цэцэглүүлэн хөгжүүлэх хэрэгцээ шаардлагад мэдрэмжтэй орчинг бүрдүүлэх зэрэг болно.



# БҮЛЭГ 2

# СТРАТЕГИ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 2.1. Үндсэн зарчим, арга зүй

Олон нийтийн идэвхтэй, чин эрмэлзэлт оролцоог хөхүүлэн дэмжих янз бүрийн арга хэрэгслийг ашиглах боломжийг хангах үндэслэлээр сумын эдийн засгийн хөгжлийн стратегийг боловсруулах үйл ажиллагааг зохион байгууллаа. Энэ зорилгоор бий болгосон албан ёсны бүтцийн хүрээнд болон нээлттэй хэлэлцүүлэг, зөвшилцөл зэрэг бусад арга хэмжээгээр дамжуулан олон нийтийг энэхүү үйл ажиллагаанд бүтээлчээр оролцуулж чадсан юм. Олон нийтийн саналын үндсэн дээр сумын эдийн засаг, бизнесийн хөгжил, тогтвортой өсөлтийг хангах нийтлэг ба гол гогцоо асуудлаа хамтын оюун ухаанаар тодорхойлох зарчмыг хангахад стратеги боловсруулах үйл ажиллагааг бүхэлд нь чиглүүлэв.

***А. Үндсэн зарчим.*** Тариалан сумын ЭЗХ-ийн стратегийг боловсруулахад баримталсан гол зарчмууд:

- Эдийн засгийн өсөлт, бизнесийн хөгжлийг нийгмийн амьдрал, байгаль орчин, иргэдийн амьжиргааны чанарын тулгамдсан асуудлуудтай холбох, зөв тэнцвэржүүлэх,
- Орон нутгийн бизнесийн хөгжил, хөрөнгө оруулалтын уур амьсгалыг сайжруулахад сумын төр, захиргааны байгууллагаас гүйцэтгэх үүргийг тодорхой болгох,
- Эдийн засгийн ололт, бий болсон өсөлтийг тогтворжуулахад төр-хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэх,
- Стратеги төлөвлөлтийг олон нийтийг хамарсан бүтээлч үйл ажиллагааны хэлбэрээр сумын түвшинд зохион байгуулж зангидах,
- Одоо байгаа бизнесийг дэмжих, орон нутагтаа тогтоон барих асуудлыг шинэ бизнес бий болгохтой эн тэнцүү авч үзэх,
- Гадаад эх үүсвэр, хүчин зүйлд дулдуйдахыг эрмэлзэхээс илүү дотоод нөөц боломжоо энэ чиглэлд дайчлахад анхаарах,
- Төр-хувийн хэвшлийн түншлэлийг сумын эдийн засгийн хөгжлийн асуудлаар бодлого, стратегийг хэрэгжүүлэх арга хэрэглүүр болгон ашиглах,

***Б. Арга зүйн асуудлууд.*** Сумын ЭЗХ-ийн стратегийг боловсруулах ажлыг Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн «Орон нутгийн удирдлага ба төрийн үйлчилгээг шинэчлэх санаачлага» хөтөлбөрөөс Дэлхийн Банктай хамтран боловсруулж Албани, Косово зэрэг орны хэд хэдэн хотын эдийн засгийн хөгжлийн стратеги төлөвлөгөө боловсруулахад хэрэглэгдэж баталгаажсан арга зүйгээр гүйцэтгэлээ. Сумын ЭЗХ-ийн стратеги боловсруулах үйл ажиллагааг процессийн хувьд зөв зохион байгуулахад нэн зохимжтой, эмх цэгцтэйгээс гадна бизнесийн хөгжлийн орчинг бодлого, зорилготой сайжруулахад чиглэгдсэн алсын хараа, зорилго, зорилт, түүнчлэн төслүүдийг дунд хугацааны баримжаатайгаар олон нийтийн дунд харилцан ойлголцолд тулгуурлан боловсруулахад тохиромжтой хэмээн энэхүү арга зүйг сонгосон болно.

Орон нутгийн чадавхийг бэхжүүлэх, идэвхжүүлэх үйл ажиллагааг стратеги боловсруулах арга зүйн хүрээнд хамтруулан хэрэгжүүллээ. Юуны өмнө бизнес хөгжихөд ахиц өөрчлөлт авчрах тэнцвэржсэн орчин бүрдүүлэх замаар иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлт бий болгоход сумынхны хүчин чармайлт, байгаа нөөц боломжийг уялдуулан зохицуулах асуудал стратеги боловсруулах арга зүйн үндэслэл болсон юм.

## 2.2. Зохион байгуулалтын ба зохицуулалтын арга хэмжээ

Стратеги боловсруулахад баримталсан зохион байгуулалтын зарчим нь сумын ЗДТГ, төслийн үндсэн багаас гадна олон нийт, оролцогчдыг стратеги боловсруулах үйл ажиллагаанд түншлэлийн журмаар, зохион байгуулалттайгаар шууд оролцуулах боломжийг хангахад чиглэгдсэн болно.

Сумын ЭЗХ-ийн стратеги боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээтэй холбогдсон арга хэмжээг хариуцсан бие даасан төлөөллийн бүтцийг сумын ИТХ юм уу Засаг даргын шийдвэрээр томилж ажиллуулах замаар иргэдийн оролцоог үндсэнд нь хангалаа.

***Төлөвлөлтийн Комисс***

Төлөвлөлтийн комиссыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2007 оны нэгдүгээр сар 9-ний өдрийн хуралдааны тогтоолоор томилон ажиллуулсан билээ. Засаг даргаар ахлуулсан тус комисс стратеги боловсруулах ажлыг зохицуулалт, удирдамжаар

СЭЗХ–ийн стратеги боловсруулахад оролцсон төлөөллийн бүтэц



хангах, ажлын явц, стратегийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийхтэй холбоотой асуудлаар шийдвэр гаргахад гол үүрэг гүйцэтгэсэн юм. Сумын эдийн засаг-бизнесийн хөгжлийн асуудлаар зөвшилцөх, шийдвэр гаргахад оролцох мэдлэг туршлага, чин хүсэл зэргээр нь хүмүүсийг сонгож, төлөвлөлтийн комиссын бүрэлдэхүүнд оруулсан болно.

Сумын засаг дарга болон ИТХ-ын дарга, сумын үндсэн багийн гишүүдээс гадна комиссын удирдлагын дор байгуулагдсан ажлын хэсэг тус бүрээс 2-3 хүнийг бүрэлдэхүүнд нь оруулж энэ комиссыг байгуулсан юм.

Төлөвлөлтийн комисс нь стратеги боловсруулах үйл ажиллагааг зохицуулахаас гадна төрийн ба хувийн хэвшлийн байгууллагуудын идэвхтэй, чин эрмэлзэлтэй оролцоог хангах, тэдний дунд өргөн хүрээтэй ярилцлага, зөвшилцлийг олон хэлбэрээр зохион байгуулах, өрнүүлэхэд анхаарч ирлээ. Энэ комисс стратегийн хэрэгжилтийг зохицуулах, хяналт үнэлгээгээр хангах, шаардлагатай засвар өөрчлөлтийн асуудлаар нэгдсэн шийдвэр гаргах чиглэлээр ДЕЛТА төсөл дууссаны дараа үргэлжүүлэн ажиллах юм.

**Төлөвлөлтийн Комиссын бүрэлдэхүүн:**

1. **Т.Цолмон**
   Засаг дарга, ИТХ-ын төлөөлөгч (төслийн үндсэн багийн гишүүн)
2. **Х.Батчулуун**
   ИТХ-ын дарга, ИТХ-ын төлөөлөгч
3. **Д.Гомбосүрэн**
   Засаг даргын орлогч бөгөөд төрийн сангийн төлөөлөгч (төслийн үндсэн багийн ахлагч)
4. **Ч.Сүрэнхорлоо**
   ИТХ-ын ажилтан, ИТХ-ын төлөөлөгч (төслийн үндсэн багийн гишүүн)
5. **М.Лхагвасүрэн**
   «Туяа-Увс» хоршооны дарга (төслийн үндсэн багийн гишүүн)
6. **А.Жамсран**
   Хувиараа бизнес эрхлэгч (бизнесийн төлөөллийн ажлын хэсгээс)
7. **Ж.Намсрай**
   Сумын малын эмч, ИТХ-ын төлөөлөгч (бизнесийн төлөөллийн ажлын хэсгээс)
8. **С.Нямсамбуу**
   ЗДТГ-ын ХХАА-н түшмэл, ИТХ-ын төлөөлөгч (төрийн байгууллагын төлөөллийн ажлын хэсгээс)
9. **С.Мягмаржав**
   Ахлах сургуулийн сургалтын менежер (төрийн байгууллагын төлөөллийн ажлын хэсгээс)
10. **Г.Хүрэлдээ**
    Иргэн (иргэний нийгэм, олон нийтийн төлөөллийн ажлын хэсгээс)
11. **И.Цээлэй**
    Эмэгтэйчүүдийн холбооны дарга (иргэний нийгэм, олон нийтийн төлөөллийн ажлын хэсгээс)
12. **Х.Хөтөө**
    Малчдын зөвлөх, малын эмч (малчдын төлөөллийн ажлын хэсгээс)
13. **С.Нямсамбуу**
    Малчин (малчдын төлөөллийн ажлын хэсгээс)

*Төслийн цндсэн баг*

СЭЗХ-ийн стратеги боловсруулах энэ бүтцийн цөм болж ажилласан төслийн үндсэн баг нь СЭЗХ-ийн стратеги боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд цаашдаа хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх, засвар өөрчлөлт оруулах үндэслэл санал боловсруулах асуудлыг хариуцан үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах болно. Төслийн үндсэн баг нь төсөл хэрэгжүүлэгч ба гүйцэтгэгч байгууллагууд, түншүүд болон эдийн засгийн хөгжлийн асуудлыг сонирхон оролцох хүсэлтэй иргэд, байгууллагуудтай хамтран ажиллахад ихээхэн үүрэг гүйцэтгэсэн болно. Төслийн үндсэн багийг Засаг даргын захирамжаар дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллууллаа.



1. **Ц.Гомбосүрэн**
   Төслийн үндсэн багийн ахлагч,
   Засаг даргын орлогч
2. **С.Цолмон**
   Сумын Засаг дарга
3. **Ч.Сүрэнхорлоо**
   ИТХ-ын ажилтан
4. **М.Лхагвасүрэн**
   «Туяа-Увс» хоршооны дарга
5. **Э.Чимэдцэрэн**
   Бизнес хөгжлийн албаны менежер

Төслийн үндсэн багийн бүрэлдэхүүнд янз бүрийн мэргэжлийн хүмүүсийг сонгож оруулсан нь стратегийг иж бүрэн боловсруулахад чухал ач холбогдолтой болов.

*Ажлын хэсэг*

Сумын хөгжлийн стратеги боловсруулахад зөвлөх үүрэгтэй ажлын 4 хэсэг байгуулж төлөвлөлтийн комиссын шууд удирдлагын дор ажиллуулав. Ажлын хэсэг бүр янз бүрийн төлөөллийг оролцуулсан 5-аас дээш гишүүнтэй, дотроо сумын ИТХ-аас *2*-оос доошгүй хүнийг төрийн удирдлагын ажлын хэсэгт заавал оруулах зарчим баримталсан бөгөөд төслийн үндсэн багийн нэг гишүүн ажлын хэсгийн ахлагчаар ажиллав. Ажлын хэсэг байгуулсан гол зорилго нь олон нийтийн оролцоог төлөөллийн журмаар хангах боломжийг өргөжүүлэх явдал байлаа. Ийнхүү ажлын хэсгүүд олон нийтийг ДЕЛТА төслийн суман дахь баг, бүтцүүдтэй холбох үүргийг чухлаар гүйцэтгэж ирлээ.

**Төрийн удирдлага, үйлчилгээний ажлын хэсэг:**

1. **Х.Батчулуун**
   ИТХ-ын дарга
2. **Н.Хадаахүү**
   ЗДТГ-ын дарга
3. **П.Эрдэнэ**
   ЗДТГ-ын нягтлан бодогч
4. **С.Нямсамбуу**
   ХХАА-н түшмэл

5. **М.Чойсүрэн**
   Байгаль орчны хяналтын улсын байцаагч
6. **Я.Норов**
   Татварын байцаагч
7. **Х.Тогтох**
   Хөхөө багийн засаг дарга
8. **Б.Зулаа**
   Хүн эмнэлгийн салбарын нягтлан бодогч
9. **Н.Ичинхорлоо**
   Нийгмийн даатгалын байцаагч
10. **Т.Баатарсайхан**
    Нийгмийн халамжийн ажилтан
11. **Г.Баасанжав**
    Ахлах сургуулийн нягтлан бодогч
12. **Х.Түмэнжаргал**
    Соёлын төвийн эрхлэгч
13. **Ч.Цогоо**
    Байгаль хамгаалагч
14. **Мо.Жамсран**
    Хүн эмнэлгийн салбарын эрхлэгч
15. **Ш.Даваасамбуу**
    Мянган багийн хүний эмч
16. **Б.Дөш**
    Бага сургуулийн сургалтын менежер
17. **Б.Баттулга**
    Багш
18. **С.Мягмаржав**
    Ахлах сургуулийн сургалтын менежер
19. **А.Толя**
    Цэцэрлэгийн эрхлэгч
20. **Б.Баттөгс**
    Багш



**Олон нийт, иргэний нийгмийн ажлын хэсэг:**

1. **Т.Самбуу**
   ЗДТГ-ын нярав
2. **Б.Машлай**
   Хувиараа бизнес эрхлэгч
3. **К.Оюунцэцэг**
   Хувиараа бизнес эрхлэгч
4. **Г.Хүрэлдэй**
   Иргэн
5. **М.Бямбаа**
   Албан бус боловсролын багш
6. **И.Доржсүрэн**
   Малын индексжүүлсэн даатгал төслийн ажилтан
7. **М.Дуламжав**
   Номын санч



8. **И.Цээлэй**
   Эмэгтэйчүүдийн холбооны дарга
9. **Т.Санж**
   Өндөр настан
10. **Тэгшжаргал**
    Алтай-Соёны төслийн идэвхжүүлэгч

**Бизнесийн төлөөллийн ажлын хэсэг:**

1. **Ү.Аюуш**
   Хувиараа бизнес эрхлэгч
2. **Ж.Намсрай**
   Малын эмч
3. **Ц.Дамдинсүрэн**
   Хувиараа бизнес эрхлэгч
4. **А.Жамсран**
   Хувиараа бизнес эрхлэгч
5. **Баг.Жамсран**
   «Туяа-Увс» хоршооны нягтлан бодогч
6. **О.Цонхио**
   Хувиараа бизнес эрхлэгч
7. **Ө.Агваандорж**
   Хувиараа бизнес эрхлэгч



8. **Т.Жав**
   Хувиараа бизнес эрхлэгч
9. **Б.Найдан**
   Хувиараа бизнес эрхлэгч
10. **У.Алтансүх**
   Хувиараа бизнес эрхлэгч

**Малчдын төлөөллийн ажлын хэсэг:**

1. **Б.Отгонбаяр**
   Мянган багийн малчин
2. **Ө.Батчулуун**
   Хөхөө багийн хадланч
3. **Х.Хөтөө**
   Малчдын зөвлөх, малын эмч
4. **А.Чимэд-Очир**
   Мянган багийн малчин
5. **Мо.Нацагдорж**
   Мянган багийн малчин
6. **Бу.Самбуу**
   «Алтандуулга» ХК-ийн нягтлан бодогч
7. **Бо.Зундуй**
   Хөхөө багийн малчин
8. **С.Нямсамбуу**
   Мянган багийн малчин
9. **И.Таранпүрэв**
   «Зүүн гол» малчдын бүлгийн ахлагч
10. **Н.Маамуу**
   Мянган багийн малчин

## 2.3. Олон нийтийн оролцоо ба зөвшилцөл

Сумын эдийн засаг-бизнесийг хөгжүүлэх олон нийт хүлээн зөвшөөрсөн, хэрэгжих боломжтой чиглэлүүдийг үзэл баримтлал сайтай, хэтийн баримжаатай, чанартай боловсруулах явдал сумын төр захиргааны хувьд нэлээд тулгамдсан асуудал байсаар ирсэн билээ. Гэхдээ хөгжлийн стратегиэ ямар арга зүйгээр боловсруулахаа бүрэн гүйцэд төсөөлж чадаагүй, сумынхаа иргэд, байгууллагуудыг оролцуулах арга замаа үндэслэлтэй төлөвлөөгүй явж ирсэн тал байсныг ил тод хэлэх нь зүйтэй. Сумын эдийн засгийн хөгжлийн асуудлыг дан ганц захиргааны үүрэг, хариуцах ажил мэтээр ойлгодог явдал олон нийтийн дунд түгээмэл байсны дээр тэд өөрсдөө

энэ үйл ажиллагаанд оролцож, хувь нэмэр оруулах иргэний үүргээ төдийлэн сайн ухаараагүй явж ирсэн юм.

Сумынхаа хөгжлийн үйл явцад хувь нэмрээ оруулах иргэний мэдлэг ойлголтыг батжуулах, чин эрмэлзлийг дэмжихэд төслийн эхнээс анхаарч зохих арга хэмжээ авч ирлээ. Энэ чиглэлээр хэрэгжүүлсэн эхний шатны арга хэмжээ болох бизнес орчны судалгаа, СВОТ шинжилгээ нь иргэд, бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн олон төлөөллийг хангалттай хэмжээнд хамарч чадсан юм. Түүнчлэн олон нийтэд ойлголт өгөх, оролцоог өрнүүлэх арга хэмжээг уулзалт, ярилцлага, багийн иргэдийн хурал зэрэг арга хэмжээний үед таниулан сурталчлах, мэдээлэл гаргах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах зэргээр хэрэгжүүлэв. Эдгээр арга хэмжээ, үйл ажиллагааны үр дүнд сумынхаа иргэдийн дийлэнхид нь тодорхой мэдээлэл хүрсэн нь төслийн ажил анхнаасаа оролцоог сайтар хангаж, олон нийтийг идэвхжүүлж чадсаныг гэрчилнэ.

Сумынхаа ЭЗХ-ийн стратеги боловсруулахад төр захиргаа, бизнес эрхлэгчид, төрийн үйлчилгээний болон олон нийт, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, хувь хүмүүс зэрэг нийтдээ 60 шахам хүн албан үүргийнхээ дагуу болон төлөөллийн журмаар шууд оролцов. Стратеги төлөвлөгөө боловсруулах ажил, арга хэмжээнд аль болох олон байгууллага, хүнийг оролцуулахыг байнга хичээж ажилласны үр дүнд хүмүүсийн сэтгэлгээнд өөрчлөлт орж, төсөл, түүний үр дүнг жинхэнэ «өмчлөгчид» болохоо ойлгох, мэдрэх чухал нөхцлийг бүрдүүлж чадсан гэж үзэж байна.

## 2.4. Бизнесийн орчны судалгаа

Бизнесийн орчны судалгаа явуулах, түүний үр дүнг сумын эдийн засаг-нийгмийн хөгжлийн олон жилийн статистик үзүүлэлтүүдээр баталгаажуулах нь сумын эдийн засгийн хөгжлийн өнөөгийн түвшин, өрсөлдөх чадвар, хэтийн төлөв, тулгамдаж буй асуудлыг үндэслэл, баримжаа сайтай тодруулах хамгийн боломжтой арга хэрэгсэл юм.

Бизнесийн орчны судалгааны хүрээнд бизнесийн хөгжил, орон нутгийн бизнесийг дэмжих орчны асуудлаар оролцогчдын санал бодол, үнэлэмжийг судлах санал асуулгыг таван бүлэгт хамаарах 41 асуултаар явуулснаас гадна сумын эдийн засгийн үндсэн статистик үзүүлэлтүүд болон бусад мэдээллийг сүүлийн 5-10 жилийг хамруулан цуглуулж, дүн шинжилгээ хийлээ. Бизнесийн орчны судалгааны дүнг СВОТ шинжилгээ хийх, цаашилбал бизнес орчны талаар сумын ЭЗХ-ийн стратегид тусгагдах гол үндэслэл, дүгнэлтүүдийг томъёолох суурь материал болгон ашиглав.

Эдийн засгийн хөгжлийг дэмжих, бизнес хөгжих таатай орчин бүрдүүлэхэд сумын төр захиргааны зүгээс эдүгээ гүйцэтгэж буй үүргийг хувийн хэвшлийнхний

үнэлгээнд тулгуурлан тодорхойлсон явдал энэ судалгааны нэг чухал үр дүн болсон юм. Тухайлбал:

1. Орон нутгийн бизнес эрхлэгчдийн санал дүгнэлтийг ул суурьтай таньж ойлгоход шаардлагатай мэдээ, тоо материал, баримт мэдээл цуглуулах
2. Сумын эдийн засаг-нийгмийн амьдралд оршин буй давуу ба сул талууд, бизнесээ өргөжүүлэх, өсөлт бий болгох, хадгалахад бизнес эрхлэгчдэд тулгарч буй асуудлуудтай холбоо бүхий мэдээ баримт хуримтлуулах
3. Бизнесийн орчинг сайжруулах, боловсронгуй болгох шаардлага, тулгамдаж буй асуудлуудыг тухай бүр нь мэдэрч ажиллахын тулд орон нутгийнхны үнэлэмж, санал бодлыг судлах зэрэг болно.

Энэ судалгааг бүх шатанд амжилттай зохион байгуулж явуулахад бид бүх талаар анхаарч ажилласныг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Сумынхаа бизнес эрхлэгчдийг энэ судалгаанд өргөн хамруулсны дээр тэдний гаргасан санал зөвлөмжийг ЭЗХ-ийн стратегид тусгасан явдал орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх шаардлага, арга замын талаар нийтлэг ойлголтод хүрэхэд чухал түлхэц өгсөн юм. Ийм байдлаар сумын эдийн засгийн өсөлтөд жинтэй нөлөө үзүүлсээр ирсэн, цаашдаа ч энэ нөлөө нь улам өсөх бизнесийн бүлгүүдийн санал үнэлэмжийг сумынхаа ЭЗХ-ийн стратегид тусгах үндсэн мэдээллээр хангаж өгсөнд бизнес орчны судалгааны ач холбогдол оршиж байгаа гэж үзэж буй болно. Төр-хувийн хэвшлийн түншлэлийг тогтворжуулах сумын ЭЗХ-ийн стратегийг байнга хянан сайжруулах урт хугацааны удирдамж болох талаасаа бизнесийн орчны судалгааны үр дүн, дүгнэлтүүд чухал ач холбогдолтой юм.

## 2.5. СВОТ шинжилгээ

Бизнес орчны судалгааны дүнг задлан шинжлэх, сумын эдийн засгийн хөгжлийн өнөөгийн байдал болон ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох, бизнесийн орчныг сайжруулахтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэх стратегийн чиглэлүүдийг тогтоох зорилгоор СВОТ шинжилгээг явууллаа. Сумын бизнес эрхлэгчдэд тулгарч байгаа гол асуудлуудыг тодорхойлж, эерэг болон сөргөөр илэрч болох бүх талууд, тэдгээрийн зохистой шийдлийг хослолоор зэрэгцүүлэн томъёолоход СВОТ шинжилгээний зорилго, хандлага чиглэгдсэн болно. Ингэснээр төсөөлөн буй зорилгодоо хүрэх хамгийн зохистой, хэрэгжих боломжтой хувилбарыг сонгох болон сумын ЭЗХ-ийн стратегийг дээр дурьдсан хандлагад тулгуурлан боловсруулах үндэслэлийг тодорхойлж чадлаа.

Давуу тал ба боломжийг өндөр үр дүнд хүрэх стратегийн ирээдүйн чиглэл гэдэг агуулгаар авч үзэн нягтлан тодруулахад СВОТ шинжилгээ чухал хэрэглүүр болж

өглөө. Үүний чацуу оршин буй сул тал ба саад бэрхшээлийг даван туулахын тулд хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойллоо. Сумын эдийн засгийн хөгжил, бизнес орчны өнөөгийн байдлыг нарийвчлан үнэлэх, эдийн засгийн хөгжлийн стратегийн гол шийдлийг СВОТ шинжилгээгээр тогтоолоо.

СВОТ шинжилгээг хийхдээ бизнес орчны судалгаанаас гарсан дүгнэлтийг сумын олон нийтээр хэлэлцүүлсэн дүн, эдийн засгийн холбогдох судалгаанд илүүтэй түшиглэсэн болно. Төрийн үйлчилгээ, бизнесийн хөгжлийн чиглэлээр СВОТ шинжилгээний матрицийн 4 элементийг тодорхойлсноор «Давуу тал-Боломж», «Давуу тал-Саад бэрхшээл», «Сул тал-Боломж», «Сул тал-Саад бэрхшээл»-ийн СВОТ хослолыг нарийвчлан шинжлэх боломж хангагдсан юм. Базаж хэлбэл, сумын ЭЗХ-ийн стратегийн алсын хараа, зорилго, зорилтыг томъёолж, төслүүдийг сонгоход СВОТ шинжилгээний дүн суурь мэдээлэл болж өглөө.

## 2.6. Алсын хараа–зорилго–зорилт–хөтөлбөр–төсөл

***Алсын хараа:*** Стратегийн алсын хараа нь сумын нийт иргэдийн чин эрмэлзэл, хэтийн хүсэл тэмүүллийг тусгахаас гадна хэтийн ирээдүйд хүрэх түвшингийн талаархи тэдний төсөөллийг нэгтгэн илэрхийлдэг билээ. Түүнчлэн стратегийн зорилго, зорилтод хүрэхэд олон нийтийг алсын хараа хөтөлж чадна. Нийгэм-эдийн засгийн ба бизнесийн хөгжил, эдийн засгийн чадавхи, байгалийн нөөц баялаг, бизнесийн дадлага туршлага, уламжлал, ёс заншил, язгуур урлаг зэрэг эдүгээ цагийн нөхцөл боломж, бодит байдал дээр тулгуурлан стратегийг хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхойлж өгдөг.

Нөөц боломжоо аль чиглэлд түлхүү зориулах, үр ашигтай дайчлан ашиглахад сумын захиргаа, олон нийтэд хөтөч болдог алсын харааг сумын эдийн засгийн хөгжлийн үйл явц, стратегийн үндсэн бүрдэл хэсгүүдийг цогцоор хамарсан, дунд хугацаанд хүрэх үр ашгийн баримжаа, чиглэлтэйгээр томъёолсон гэж үзэж байна.

Алсын хараа маань сумын эдийн засаг, байгаль орчин, ахуй соёл, түүхэн уламжлал дээр суурилсан болохыг нотлох онцлог нөхцөл байдлыг тодруулахыг оролдлоо. Алсын хараа уян хатан, стратегийг хэрэгжүүлэх явцад гарч болох өөрчлөлтөд нийцүүлэн хянан өөрчлөх, сайжруулах боломжтойгоор томъёологдсон болохыг тэмдэглэн хэлэх нь зүйтэй юм.

***Зорилго:*** Орон нутгийн эдийн засгийн хөгжлийн стратеги нь угаасаа орон зайн ба цаг хугацааны хэмжүүрээр тодорхойлогдох дэвшил, ахиц өөрчлөлт бий болгох тухай асуудал билээ. Хүрч болох дэвшил, хэрэгжүүлэн бий болгох өөрчлөлтийг

урьдчилан төсөөлж, тодорхойлох үндсэн дээр стратегийнхээ үр дүн, өгөөжийг хэрхэн томъёолохоо шийдэх чиг баримжаа авахад сумынханд дэмжлэг үзүүлэх үүднээс стратегийн зорилго тодорхойлох асуудалд хандсан юм. Алсын хараандаа амжилттай хүрэхэд хөтлөн залах үндсэн чиглэлийг тодорхойлохоос зорилгоо томъёолох ажлаа эхлэсэн болно. Сумын эдийн засгийн хөгжлийн нийтлэг ба тусгай асуудлуудад тулгуурласан, стратегийн тэргүүлэх чиглэлүүдийг багтаасан байх шаардлагыг тавьж ажиллалаа. Алсын хараа ба зорилтын амьд холбоог хангахуйцаар зорилгоо томъёолоход анхаарлаа.

***Зорилт:*** Зорилгоор дамжин алсын хараанд хүрэх, түүнчлэн хөтөлбөр, төсөлтэй зорилгыг холбох чухал хэрэглүүр нь зорилт юм. Стратеги болон тусгайлсан зорилго, төслийн хэрэгжилтийг хяналт үнэлгээ хийхэд ашиглах хүрэх түвшингийн үзүүлэлт, тоон хэмжигдэхүүнтэйгээр зорилтыг томъёолох зарчмыг баримтлалаа. Товчхон хэлэхэд, зорилтыг зорилгын шууд үргэлжлэл байхаар төсөөлж ажилласан болно. Сумын бизнес орчны судалгаа, СВОТ шинжилгээгээр тогтоогдсон давуу талаа бэхжүүлэх, сул талаа даван туулах, боломжийг зөв ашиглах, саад бэрхшээлийг үндэслэлтэй тооцож ажиллах боломжийг стратегийн зорилтууд сумынханд олгож байгаа юм.

***Хөтөлбөр:*** Хамтад нь хэрэгжүүлснээр тодорхой зорилт хангагдах талаас нь харж хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээр нь төслүүдийг бүлэглэх замаар томъёолсон хэд хэдэн хөтөлбөрийг стратегид оруулллаа. Өөрөөр хэлбэл, зорилтыг зорилгоос шууд салбарлуулан гаргахад төвөгтэй байсны учир хөтөлбөрийг ийнхүү завсрын шатлал маягтайгаар боловсруулсан юм. Цаашдаа төслүүдийг нэгтгэн бие даасан томоохон хөтөлбөр боловсруулах суурь материал болох учраас стратегийн хөтөлбөрт ийнхүү ач холбогдол өгсөн болно.

***Төсөл:*** Уламжлалт аргачлалаар бол стратеги төлөвлөгөө боловсруулах ажил үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр үндсэндээ шувтардаг билээ. Харин үйл ажиллагааны төлөвлөгөөний оронд тодорхой хөтөлбөрөөс уламжлуулан харилцан холбоо бүхий төслүүдийг стратегидээ тусгасан нь бидний хэрэглэсэн арга зүйн шинэлэг хандлага боллоо. Ийнхүү төсөл нь «алсын хараа-зорилго-зорилт-хөтөлбөр-төсөл» гэсэн гинжин холбооны төгсгөл хэсэг болж байгаа юм. Товч танилцуулгыг төсөл тус бүрээр боловсруулж стратегид тусгасан болно. Төслийн танилцуулгад товч тодорхойлолт, хүлээгдэж буй үр дүн, зорилтот бүлэг, төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид, боломжит хувь нэмэр оруулагчид, урьдчилсан боломж, зэхэц нөхцөл, эрсдэлтэй хүчин зүйлс, шаардагдах хөрөнгө оруулалт, хэрэгжүүлэх хугацаа, үр дүнгийн тогтворжилтийн талаархи товч мэдээллийг багтаалаа.

Тодруулан хэлэхэд, төсөл сонгох, боловсруулах ажлыг хэд хэдэн шат дамжлагатайгаар хэрэгжүүлсэн болно. Олон нийтийн хэлэлцүүлэг, ажлын

хэсгүүдийн саналыг төслийн үндсэн багийн хэмжээнд нэгтгэн боловсруулж гаргасан хувилбарыг Төлөвлөлтийн Комиссоор хэлэлцэн зохих засвар, нэмэлт өөрчлөлт оруулж төслүүдийг эцэслэн боловсруулллаа.

Тариалан сумын эдийн засгийн хөгжлийн стратегид нийтдээ 35 төсөл тусгагдсан болно.

***Бизнесийн хөгжлийг дэмжих чиглэлүүд.*** Эдийн засгийн өсөлт бий болгох, сум орноо хөгжүүлэхэд нутгийн бизнесийн үүрэг онцгой чухал учраас бизнесийн хөгжлийг дэмжих стратеги чиглэлүүдийг оролцогчдын хамтаар тодорхойлж стратегид тусгаж өглөө. Нийтдээ 27 чиглэлийг товчилсон тодорхойлолттойгоор энэхүү стратегид оруулав. Төслийн үндсэн баг, ажлын хэсгүүд, Төлөвлөлтийн комиссын шугамаар болон олон нийттэй хийсэн уулзалт, зөвшилцөөнөөр дээрхи чиглэлүүдийг тогтоосон болно.

## 2.7. Хүлээгдэж буй үр дүн

Стратегийг хэрэгжүүлснээр олон талтай, тооны хувьд ч цөөнгүй чухал үр дүн гарна хэмээн төсөөлж байгаа бөгөөд хүлээгдэж буй зарим гол үр дүнг тодруулбал:

- Сумын ЭЗХ-ийн стратегийг хэрэгжүүлэхэд сумаас оруулах хөрөнгө, хувь хандивыг жил бүрийн төсөв, төлөвлөгөөнд тусгах асуудлыг шийдвэрлэхэд ИТХ, ЗДТГ-т чиглэл болж өгөх,
- Стратегийн дэд хэсгүүдийн хэрэгжилтийг хариуцсан алба, байгууллага, ажилтны үйл ажиллагааг зохицуулах чадавхи, боломжийг дээшлүүлэх,
- Стратегид тусгагдсан тэргүүлэх чиглэл төслүүдийг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хамтран санхүүжүүлэх боломжийг өргөжүүлэх,
- ЭЗХ-ийн стратегийг хэрэгжүүлэхэд оролцох, хувь хандив оруулах сонирхол бүхий орон нутгийн, үндэсний, олон улсын бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчид, хандивлагчдыг татах, тэдэнд хандах боломж сайжрах,
- Сумын эдийн засгийг хөгжүүлэх чадавхи, орон нутгийн нөөц боломж тодорхойлогдсон, ашиглалт, эргэлтэд зохих хэмжээгээр орсон байх,
- Бизнес, бизнес орчны холбогдолтой мэдээллийн сүлжээ бий болж төлөвших, бэхжих,
- Төрийн үйлчилгээний байгууллагын чадавхи дээшилж, үйлчилгээний чанар сайжрах,

## 2.8. Стратегийг хэрэгжүүлэх

ЭЗХ-ийн стратеги нь сумын төр, захиргааны байгууллага, аж ахуйн нэгжүүд, бизнес эрхлэгчдийн хувьд эдийн засаг-бизнесийн хөгжлийн бодлого, гол гогцоо асуудлуудаар чиглэл авах албан ёсны баримт бичиг мөн. Энэ агуулгаараа тухайн үеийн шаардлага, нөхцөл байдлаас хамааруулан стратегийг байнга хянан өөрчилж, шинэчилж байх ёстой.

Тариалан сумын ЭЗХ-ийн стратегийг хэрэгжүүлэх ажил хоорондоо нягт уялдаа бүхий 4 үндсэн арга хэмжээгээр дамжин хэрэгжинэ.

- Санхүүгийн эх үүсвэрийг идэвхжүүлэх, санхүүжилт олох,
- Төр-хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх,
- Хяналт үнэлгээг хугацаатай төлөвлөн хэрэгжүүлэх,
- Хянан сайжруулах, нэмэлт өөрчлөлт хийх,

Стратеги хэрэгжих хугацаа сумын одоогийн ба дараачийн сонгуулиар томилогдох удирдлагын бүрэн эрхийн хугацаанаас урт байх учраас түүний хувь заяа нь шинэ удирдлага үйл ажиллагааны залгамж чанарыг цаашид хэр хадгалж, олон нийтийн оролцоог хэрхэн хангаснаас ихээхэн хамаарна.

Стратегиэ хэрэгжүүлэх гол этгээд болохын хувьд хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр олох, гаргах үүрэг хариуцлага сумын төр, захиргаанд ногдож байгааг бид ойлгож ажиллах ёстой. Ер нь стратегид шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах санал бэлтгэх, ИТХ-аар батлуулах асуудлыг сумын ЗДТГ хариуцах нь зүйтэй гэж үзэж буй болно. Өөрөөр хэлбэл, стратегийн болоод төслийн хэрэгжилтийг зохицуулах, стратегийг хянах, зохих нэмэлт өөрчлөлт оруулж байх асуудлыг Төлөвлөлтийн комисстой хамтран сумын ЗДТГ санаачилж, гаргасан шийдвэрийн биелэлтийг хариуцах юм. Санхүүгийн ба техник ажиллагааны туслалцаа дамжлэг авах асуудлаар сумын захиргаа хандивлагчид, засгийн газар, олон улсын байгууллага, хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллана.

Стратегийн хэрэгжилтийн явц гүнзгийрэхийн хэрээр энэ үйл явцад оролцох олон нийтийн сонирхол, идэвх дээшлэх нь мэдээж. Иймээс оролцогчидтой хамтран стратегийн хэрэгжилтийн байдлыг байнга хянаж, үнэлж байх нь алдаа оноогоо дүгнэж, шинээр дэвшигдэн гарч ирэх асуудлууд, шаардлагыг оновчтой тодорхойлон стратегийн хүрээнд шийдвэрлэх боломжийн хангаж өгнө. Төсөл маань сумынхны өмч учраас хяналт үнэлгээг хамтран хэрэгжүүлж байх үүрэг сумын удирдлага, олон нийтэд оногдох юм. Төлөвлөлтийн комисс энэ ажилд чухал үүрэг гүйцэтгэх болно.

## 2.9. Стратеги хэрэгжүүлэх зохион байгуулалтын асуудлууд

Стратегийн хэрэгжилт, хяналт үнэлгээний асуудлыг хариуцсан Төлөвлөлтийн комисс ажиллаж байгаа тухай өмнө өгүүлсэн билээ. Тус комисс жилдээ 1-2 удаа хуралдаж, стратегийн хэрэгжилтийн талаар төслийн үндсэн багийн ахлагчийн тайлан, хяналт үнэлгээний дүнг авч хэлэлцэж зохих шийдвэр гаргаж байх юм. Түүнчлэн жилд нэг удаа, баримжаалбал арван хоёрдугаар сард стратегийн хэрэгжилтийн явц, үр дүнг хэлэлцэж, стратегид оруулах нэмэлт өөрчлөлтийг батлуулахаар ИТХ-д оруулах санал бэлтгэнэ. Комиссын бүрэлдэхүүн өөрчлөгдөж болох ч стратегийн хэрэгжилтийг бүх талаар дэмжих, хяналт үнэлгээ хийх ажил үүрэг нь хэвээр байх юм.

ЗДТГ нь стратегийн хэрэгжилтийг хангуулах асуудлыг шууд хариуцах ба дараах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

- Төлөвлөлтийн комиссын үйл ажиллагааг хэвийн явуулах захиргааны ба ажил явуулаллагад дэмжлэг үзүүлэх,
- Стратегид нэр зааж тусгагдсан болон хэрэгжилтийн бусад үе шатанд шинээр оролцогчдоос хариуцах үйл ажиллагааг зохицуулах,
- Стратегийн хэрэгжилтийг олон нийтэд байнга мэдээлж, тэдний санал зөвлөгөөг тусгах, олон нийтийн оролцоог идэвхжүүлэх шинэ арга хэлбэрүүдийг санаачилж нэвтрүүлэх
- Стратегийн хэрэгжилтийн явцад 2 жил тутамд нэг удаа хяналт үнэлгээ хийж, хэрэгжилт тухайн үеийн шаардлага, нөхцөл байдалтай уялдуулан нэмэлт тодотгол хийх, ИТХ-аар батлуулах, бусад төсөл хөтөлбөрт тусгуулах.

## 2.10. Стратегийн санхүүжилт

Улсын төсвөөс тодорхой хөрөнгө оруулалт авах талаар хөөцөлдөхийн чацуу орон нутгийн иргэд, нутгийн зөвлөл бизнесүүд, хандивлагчид, хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагуудаас хөрөнгө оруулалт хийх явдлыг дээд зэргээр дэмжин ажиллаж, энэхүү стратегийг хэрэгжүүлэх санхүүжилтийн асуудлыг хамтран шийдвэрлэх зорилт тавих юм. Орон нутгийнхнаас стратегид тусгагдсан арга хэмжээнд шууд хөрөнгө оруулах нь стратегийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх томоохон боломжийг хангана.



# БҮЛЭГ 3

# УВС АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН ТАНИЛЦУУЛГА

***Түүхийн хуудаснаас.*** Тус сум 1925 оны 12 дугаар сард байгуулагдсан бөгөөд УИХ-ын 1999 оны 130-р тогтоолоор Хархираа сумыг татан буулгаж тус сумтай нэгтгэснээр газар нутаг, нөөц, үйлдвэрлэлийн ба бизнесийн хэмжээ нэмэгдсэн төдийгүй, төрийн үйлчилгээний цар хүрээ ихээхэн тэлсэн билээ. Тариалан сум эдүгээ аймагтаа хүн ам, үйлдвэрлэлийн хэмжээгээрээ томд орох засаг захиргааны нэгж болж өргөжин хөгжсөөр байна.

## 3.1. Газар зүй, цаг уурын нөхцөл, байгалийн нөөц баялаг

Байгалийн бүс*: Их нууруудын хотгор*
Эдийн засгийн муж*: Баруун бүс, бүсийн тулгуур төв нь Ховд хот*

***Нутаг дэвсгэр, түүний тогтоц.*** Их нууруудын хотгорын давтагдашгүй өвөрмөц хэв шинж бүхий далайн төвшнөөс дээш 1100-1600 метр өргөгдсөн газар нутагт оршдог. Тус сумын газар нутгийн онцлог нь 4126 метр өндөр өргөгдсөн мөнх цаст Хархираа уулаас «Дэлхийн байгалийн цогцолбор» хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн Увс нуурын хөвөө орчмоор 800 метр хүрч намсах өндөрлөгийн өөрчлөлтөөр нөхцөлдсөн гэж үздэг байна.

Тариалан сум 247.8 мянган га нутаг дэвсгэртэй. Нутаг дэвсгэрийн 93.7%-ийг ХАА-н эдэлбэр газар, 1.1%-ийг ой мод, 0.4% нь усны нөөц газар эзэлдэг.

Алтайн нурууны хойт төгсгөл болох Хархираа-Түргэний уулсын тогтоц нь Цагаан салаа, Харгайт, Гурван хороо, Бургастай, Орлого, Намир зэрэг голууд, Увс нуур, их бага Адуун нуур, Яст, Шарнуур, Хөхнуур зэрэг олон нууртайгаараа онцлог. Нийтдээ 14 гол горхи, 8 нуур, 18 булаг шанд гадаргын усны нөөцийг бүрдүүлдэг.

Говь, элсэн цөлд ургадагаас бусад чийгсэг, тагийн, хуурайсаг олон зүйлийн мод, бут, сөөг, өвслөг ургамал бий. Зэрлэг ан амьтдын өлгийн нутаг гэж үзэж болох ба агнуурын ба ажиглах, судлахад сонирхолтой амьтдаас гадна нүүдлийн болон суурин шувууд амьдардаг.

Тариалан сумын нутаг дэвсгэрийн бүтэц, бүрэлдэхүүн

| | Нийт нутаг дэвсгэр | Хэмжээ, га | Бүтэц, % |
|---|---|---|---|
| | | 247800 | 100.0 |
| 1. | ХАА-н эдэлбэр газар | 232093.9 | 93.7 |
| | 1.1. Бэлчээр | 225813 | 91.1 |
| | 1.2. Хадлан | 1679.7 | 0.7 |
| | 1.3. Тариалангийн талбай | 1346.4 | 0.5 |
| | 1.3.1 Үүнээс: тариалдаг талбай | 296.9 | 0.1 |
| | 1.3.2 атаржсан газар | 850 | 0.3 |
| 2. | Ойн нөөц | 2849 | 1.1 |
| 3. | Усны эдэлбэр газар | 968 | 0.4 |
| 4. | Тусгай хамгаалалттай газар | 7501 | 3.0 |
| 5. | Зам, шугам сүлжээний газар | 3703.5 | 1.5 |
| 6. | Хот, суурины эдэлбэр газар | 195.7 | 0.1 |
| 7. | Уул уурхайн газар | 488.9 | 0.2 |

***Цаг уур.*** Нутаг дэвсгэрийн өвөрмөц тогтоц нь эх газрын цаг уурын эрс тэс өвөрмөц нөхцлийг бүрдүүлдэг. Зундаа 35-40 хэм хүртэл халж, өвөлдөө 32-40 хэм хүртэл хүйтэрдэг. Дулааны улиралд нам дор газраа зунд 35-40 хэм хүртэл халж байхад уулархаг хэсгээрээ 15-20 хэм байдаг нь нэн таатай. Цаг уурын энэхүү өвөрмөц байдал хүйтний улиралд нэгэн адил ажиглагдана. Тухайлбал, өвөл олон жилийн дунджаар -30 хэм хүйтрэх ба хүйтний оргил үе болох нэгдүгээр сард -40 хэм давж хүйтрэх явдал жил бүр давтагдана. Монгол орны бусад бүс нутгаас ялгаатай нь хүйтрэлт, дулааралтын шилжилт аажим, сарын хэлбэлзэл багатай явагддагаараа онцлогтой.

***Байгалийн баялаг.***
*Нүүрсний орд:* Хар тарвагатайн орд сумын төвөөс 90, Довт 25, Бургастай 40, Бааль 25 км зайд оршино.
*Алтны орд:* Хужиртын орд сумын төвөөс 84, Мээрэн 34, Бор хавцал 110, Сангийн ширэг 86, Намирын эх 115, Бургастайн гол 35 км зайтай.
*Барилгын материал:* Овоотын шохой сумын төвөөс 35, Тоосгоны шавар 5, Элс хайрга чулуу 2-3 км.
*Давс, хужир:* Увс нуурын хөвөөний давс, хужир сумын төвөөс 50, Шар бүрдийн хужир 20 км.

***Байгалийн үзэсгэлэнт газар.*** Мөнх цаст Хархираа, Түргэн, Намирын эхний уулс, Аагай, Хайдаа, Адуун нуур, Гурван хороо сумын төвөөс 120 км, Хонхийн хоо 90 км, Арцат хоо, Шүртийн улаан 150 км, Хөхөө-Мянганы уул 10 км зайтай. Түүнчлэн түүхийн дурсгалт ба давтагдашгүй үзэсгэлэнт газрууд болох Халгайтын дэнжийн хиргисүүр, хүн хөшөө хүрэхэд 15 км, Мянганы хөндий 15 км, Бургастайн чулуужсан тогтоцтой толгод 25-30 км, Галдан бошигтын унхраг, бух 1-5 км, Даралтат услалтын системийн толгойн барилга 2 км, механик ба гар усалгаатай хүртэл 10 км, янгирын сүг зураг 5 км, Увс нуурын баруун хаяа хөвөө хүрэхэд 50 км явна.

Тус сумын нутаг дэвсгэр төрөл бүрийн өнгөт ба үнэт металл зэрэг ашигт малтмалын нөөцөөр харьцангуй баялаг бөгөөд Хар тарвагатай, Довтын нүүрсний уурхай болон Хужирт, Мээрэн, Бор хавцал, Сангийн ширгийн алтны шороон ордуудад байнгын олборлолт явуулж байна.

## 3.2. Эдийн засгийн үндсэн ба туслах салбар

Сумын эдийн засгийн үндсэн салбар нь уламжлалт газар тариалан, бэлчээрийн мал аж ахуй юм. Зах зээлд шилжихээс өмнө төрийн ба хоршооллын өмчид байсан мал аж ахуй, газар тариалан, бусад үйлдвэрлэл бүрмөсөн тарснаар хувийн жижиг үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний чиглэлийн олон тооны жижиг

бизнесүүд шинээр төрөн гарлаа. Хэдийгээр дотоодын нийт бүтээгдэхүүний бүтцэд тусгагдсанаар нүүрсний 2, алтны 3 уурхайгаас бүрдсэн уул уурхайн олборлох үйлдвэр сумын эдийн засгийн үндсэн салбарын нэг хэмээн тооцогддог ч сумын эдийн засагт үзүүлэх нөлөө нь бага юм. Ийм учраас тус сумын хувьд мал аж ахуй, газар тариалангаа эдийн засгийн үндсэн салбарт тооцдог. Сүүлийн жилүүдэд мал аж ахуй, газар тариалангийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн жин өсөх хандлагатай байна. 2001 онтой харьцуулбал мал аж ахуйн салбар тогтвортой, бусад салбарууд өсөлт бууралттай боловч сумын дотоодын нийт бүтээгдэхүүн дүнгээрээ 62.1% өсчээ.






Бизнесийн нэгжийн тооны өсөлт

| Бизнес эрхлэгчдийн төрөл | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 |
|---|---|---|---|---|---|---|
| Аж ахуйн нэгж | 15 | 16 | 16 | 13 | 12 | 7 |
| • Хувьцаат компани | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| • ХХК | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 |
| • Хоршоо | 12 | 13 | 13 | 10 | 9 | 4 |
| Малчин өрх | 679 | 688 | 701 | 677 | 661 | 647 |
| Хувиараа хөдөлмөр эрхлэгч | 14 | 16 | 19 | 18 | 20 | 26 |
| Бизнесийн нэгжийн тоо | 718 | 720 | 736 | 608 | 693 | 680 |

Бизнесийн үйл ажиллагаанд аж ахуйн нэгж 7, хувиараа бизнес эрхлэгч 26, малчин өрх 647 оролцож байна.

## 3.3. Хүн ам зүй, хүний нөөц, чадавхи

2006 оны эцсээр тус сум 4906 хүн амтай байсны 46.45% нь 0-15 насны хүүхэд, 31.15% нь 16-35 насны залуучууд, 22.4% нь 36-аас дээш насны, 5.2% нь тэтгэврийн насны ахмадууд, 50.3% нь эмэгтэйчүүд байна. Өндөр насны болон халамжийн тэтгэвэр авдаг 490 хүн байна. Ерөнхий боловсролын бүрэн дунд ба бага 3 сургуульд 1200-аад хүүхэд, их дээд сургууль, коллежид тус сумын харъяат 160 гаруй хүүхэд суралцаж байгаа бөгөөд жилд дунджаар 160-171 хүүхэд мэндэлж хүн амын цэвэр өсөлт 27.6 промиль байна.



Хөдөлмөрийн насны идэвхтэй хүн амын 98.5 хувь нь ажил эрхэлдэг. Сумын хүн амын тоо, түүний дотор ажиллагсдын тоо сүүлийн жилүүдэд буурч байгаа нь орон нутгийн удирдлагын анхаарлыг татаж байгаа юм. Ажиллагсдын тоог салбараар авч үзвэл, мал аж ахуйд дийлэнх хэсэг нь буюу 71.0%, газар тариаланд 17.8%, боловсролын салбарт 3.9%, худалдаа, үйлчилгээнд 2.7%, эрүүл мэндийн салбарт 1.8%, төрийн байгууллагад 1.5%, уул уурхайн үйлдвэрт 1% нь ажиллаж байна.

2006 оны байдлаар албан ёсны бүртгэлтэй ажилгүй 31 хүн байсан нь хөдөлмөрийн насны хүн амын 1.5% нь болж байгаа юм. 2006 оны байдлаар сумын нийт өрхийн 41,4 хувь нь ядуу, нэн ядуу гэсэн ангилалд багтаж байсан нь сумын эдийн засгийн хөгжлийн эмзэг асуудал юм. Хүн амын амьжиргааны түвшин сүүлийн жилүүдэд сайжрах хандлагатай боловч өсөлтийн хурдац нь удаан байна.






## 3.4. Сумын орон нутгийн удирдлагын зохион байгуулалт

Тариалан сумын нутгийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт орон нутгийн төрийн удирдлагын тогтсон журмын дагуу дараах байдлаар бүрэлдэж байна.

Нутгийн удирдлагын бүтэц




Сумын нутгийн удирдлага ИТХ, ЗДТГ, баг гэсэн 3 шатлалаас бүрдэх ба ИТХ 2, ЗДТГ 12, баг 6 ажиллагсадтай. Нутгийн захиргааны зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх бөгөөд эрүүл мэнд, боловсролын байгууллага улсын нэгдсэн төсвөөс, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн ажилтан, татвар, цагдаа, ус цаг уурын ажиглагч 7 хүн байгууллагын босоо тогтолцоогоор аймгийнхаа салбараас санхүүждэг.

Орон нутгийн төсвийн зарлага байнга нэмэгдэж байгаа боловч төсвийн орлого нь нэмэгдэхгүй, харин ч буурах хандлагатай байна. 2001 онд орон нутгийн орлогоор төсвийн зарлагаа нөхөж байсан бол 2006 онд төсөвт зардлынхаа дөнгөж 34.3 хувийг орон нутгийн орлогоор нөхөж, үлдсэн хэсгийг улсын төсвөөс авчээ.

Тариалан сумын засаг захиргааны нэгжийн зохион байгуулалт



Багийн эдийн засгийн үзүүлэлт

| | Өрхийн тоо | Хүн амын тоо | Малын тоо, толгой | Тариалангийн талбай, га | Сумын төвөөс зай, км |
|---|---|---|---|---|---|
| Бургастай | 180 | 842 | 31529 | 10 | 70 |
| Тарвагатай | 137 | 655 | 33723 | 20 | 75 |
| Мянган | 205 | 913 | 31404 | 70 | 60–120 |
| Толь | 81 | 343 | 5458 | 5 | 90 |
| Хөхөө | 345 | 1609 | 24396 | 1165 | 0 |
| Хархираа | 147 | 668 | 9327 | 300 | 15 |
| Сумын дүн | 1095 | 5030 | 135837 | 1560 | |

Сумын төсвийн орлого, зарлага, сая төгрөг

| Үзүүлэлтүүд | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 |
|---|---|---|---|---|---|---|
| **Орон нутгийн төсвийн орлого** | 61.4 | 33.9 | 17.3 | 16.1 | 23.7 | 19.6 |
| • Хүн амын орлогын албан татвар | 7.0 | 4.2 | 4.3 | 5.8 | 6.7 | 5.5 |
| • Бууны албан татвар | 0.2 | 0.3 | 0.3 | 0.3 | 0.3 | 0.3 |
| • Үндсэн хөрөнгийн хураамж | | | 0.6 | 0.5 | 0.6 | 0.5 |
| • Ашигт малтмалын нөөцийн төлбөр | 42.6 | 18.9 | 7.5 | 4.9 | 7.5 | 6.3 |
| • Ойн хураамж | 0.4 | 0.4 | 0.4 | 0.3 | 0.5 | 0.5 |
| • Газрын төлбөр | 2.3 | 1.6 | 2.2 | 1.7 | 1.2 | 1.7 |
| • Ус ашигласны төлбөр | 1.2 | 0.6 | 0.5 | 0.5 | 3.6 | 2.3 |
| • Тээврийн хэрэгслийн татвар | 2.5 | 2.9 | | | | |
| • Хүү торгууль | 0.1 | 0.3 | 0.5 | 0.2 | 0.1 | 0.4 |
| • Өөрийн орлого | 3.7 | 3.6 | 0.4 | 1.1 | 2.4 | 0.5 |
| • Бусад орлого | 1.4 | 1.1 | 0.6 | 0.8 | 0.8 | 1.6 |
| **Орон нутгийн төсвийн зарлага** | 41.4 | 43.3 | 38.2 | 44.4 | 55.9 | 57.2 |
| • Цалин | 16.9 | 17.5 | 17.7 | 20.3 | 20.3 | 26.4 |
| • Нийгмийн даатгалын шимтгэл | 4.6 | 4.6 | 4.7 | 5.7 | 5.4 | 7.0 |
| • Гэрэл цахилгаан | 0.4 | 0.4 | 0.4 | 0.4 | 0.5 | 0.6 |
| • Тээвэр шатахуун | 3.4 | 3.9 | 4.1 | 5.4 | 6.5 | 6.9 |
| • Халаалт | 5.3 | 3.1 | 2.7 | 4.2 | 4.4 | 5.2 |
| • Шуудан холбоо | 0.4 | 0.8 | 0.8 | 1.2 | 1.0 | 1.3 |
| • Албан томилолт | 1.1 | 1.0 | 0.9 | 1.0 | 1.4 | 1.9 |
| • Тэтгэмж урамшил | 1.1 | 1.1 | 1.2 | 1.8 | 1.7 | 1.3 |
| • Бусад | 8.2 | 10.9 | 5.7 | 4.4 | 14.7 | 6.6 |
| **Төсвийн татаас** | –20 | 9.4 | 20.9 | 28.3 | 32.2 | 37.6 |

## 3.5. Дотоод, гадаад харилцаа

Сумын орон нутгийн төр, захиргаа, төрийн үйлчилгээний байгууллага, бизнес эрхлэгчид аймгийн ИТХ, засаг даргын тамгын газар, түүний харьяа газар хэлтэс, мэргэжлийн байгууллагуудтай харъяаллын ба ажил үйлчилгээ, мэргэжлийн чиглэлээр ажил төрлийн байнгын харилцаа холбоотой ажилладаг. Бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүд Ховд аймгийн Булган суман дахь боомтоор БНХАУ-тай, Увс аймгийн Давст сумын Хандгайт боомтоор ОХУ-ын Тува улстай хилийн худалдаа, жижиг үйлдвэрийн чиглэлээр хамтран ажилладаг. Цаашдаа үйлдвэрлэл худалдааны чиглэлээр байнгын түншийн харилцаа тогтоож ажиллах нь чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Баян-Өлгий аймаг, Турк, Казакстан улстай харилцаа холбоо тогтоож, боловсрол, бизнес, шашны чиглэлийн үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн төв, Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ аймагт амьдардаг нутгийн уугуул иргэдтэй байнгын холбоо харилцаа тогтоож, нутгийн зөвлөл байгуулан ажиллаж байгаа нь иргэд хоорондын харилцааны чухал хэлбэр болдог.

## 3.6. Ахуй, соёл, иргэншил, үндэсний онцлог

Уламжлалт ахуй, соёл, зан заншлаараа Монгол улсын хэмжээнд нэн өвөрмөцөд тооцогдох хотон хэмээх үндэсний цөөнх Тариалан сумын нийт хүн амын 85.6%-ийг эзэлдэг, хотон ястны өлгий нутаг юм. Түүхэнд тэмдэглэснээр Ойрадын Галдан Бошигт хаан тариалангийн ажил эрхлүүлэх зорилгоор Дорнод Туркестаны Хотан хотоос 200 гаруй өрхийг нүүлгэж ирүүлснээр монгол дахь хотон ястан үүсэн бүрэлдсэн тухай түүхийн ном судрт тэмдэглэсэн байдаг. Олон зуун жилийн туршид ахуй ёс заншил нь нэлээд монголжсон боловч өвөрмөц соёл, ёс заншил нь хадгалагдан үлдэж, түүнээ хойч үедээ өвлүүлэхийг чухалчилж байдаг. Хотон ястан мусульман шашин шүтдэг уламжлалтай. Одоо тус суманд 7 овог байгаа бөгөөд ургийн бичгээ нарийн хөтөлдөг.

Тариаланчуудын давуу тал нь мал аж ахуйгаас гадна тариалан, ялангуяа гар усалгаатай тариалан эрхлэх үе уламжилсан туршлагаа хадгалж чадсан, ясны хөдөлмөрч чанар нь өндрөөр үнэлэгддэг явдал юм.

Тариалан сумын хүн амын дунд үндэсний язгуур урлаг болох бий хуур, өвөрмөц хөгжмийн зэмсэг (икэл), бий биелгээ хэмээх үндэсний язгуур урлаг ихэд дэлгэрч нийтийн хүртээл болсон байна. Тус сумынхан үндэсний өвөрмөц ёс заншил, соёл боловсрол, язгуур урлагдаа түшиглэн аялал жуулчлал, ардын эмнэлэг, соёл, урлагийн бизнес хөгжүүлэх, залуу хойч үедээ өвлүүлэхийг эрхэм зорилгоо болгож байдаг.



# БҮЛЭГ 4

# СУМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ, ХЭТИЙН ТӨЛӨВ

## 4.1. Сумын эдийн засгийн хөгжлийн одоогийн байдал, хэтийн төлөв

***Мал аж ахуй.*** 2006 оны эцсийн байдлаар сумын дүнгээр нийт 135837 толгой мал, үүний дотор 616 тэмээ, 2292 адуу, 4729 үхэр, 76573 хонь, 51627 ямаа тоологджээ. Сумын хэмжээгээр нийт 647 малчин өрх, 1407 малчинтай. Сүүлийн жилүүдэд мал цөөтэй өрхийн тоо буурч, олон малтай өрхийн тоо нэмэгдэж байгаа нь малчдын амьжиргаа сайжрах хандлагатай байгаагийн нэг нотолгоо гэж үздэг. Сумын аж ахуйн нэгж 6, албан байгууллага 2187 толгой малтай байна. Нийт малын 85.3% нь малчин өрхөд хамрагдаж байгаа бөгөөд нэг малчин өрхөд дунджаар 207 толгой мал ногдож байна.

Малчин өрхийг малын тоогоор бүлэглэсэн үзүүлэлт

| Малын тооны бүлэг | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 |
|---|---|---|---|---|---|---|
| 100 хүртэл малтай | 717 | 701 | 649 | 339 | 585 | 503 |
| 101–200 малтай | 190 | 209 | 243 | 233 | 232 | 255 |
| 201–500 малтай | 93 | 103 | 137 | 159 | 184 | 204 |
| 501–999 малтай | 6 | 8 | 11 | 15 | 17 | 21 |
| 1000–аас дээш малтай | 4 | 3 | 2 | 4 | 5 | 6 |
| Дүн | 1010 | 1024 | 1042 | 1038 | 1023 | 989 |

Сумын малын тоо дүнгээрээ тогтвортой нэмэгдэж байгаа боловч ялангуяа ямаа илүү хурдацтай өсч, бод малын өсөлт төдийлөн тогтвортой биш, сүүлийн жил буурах хандлагатай байна.

Малын тоо өсөхийн хамт бэлчээрийн хангамж 65.8 хувьд хүрч, цаашдаа мал өсөлт энэ хэвээр үргэлжилбэл бэлчээрийн ачаалал үлэмж нэмэгдэх, цаашилбал хэтрэх төлөвтэй байна. Сүүлийн жилүүдэд тэжээл бэлтгэлийн хэмжээ 4877 тн-д хүрч 2001 оноос 30.6 хувиар өссөн боловч нэг малд ногдох хэмжээ нь дорвитой нэмэгдээгүй байна. Иймд бэлчээрийн даац хүрэлцээгүй болсон нөхцөл байдал, хүн ам төвлөрсөн хотын ойролцоо байршил, газар тариалан эрхлэх дадлага туршлагадаа тулгуурлан мал аж ахуйг эрчимжүүлэх, саалийн үхэр, тахиа, шувуу зэрэг уламжлалт бус салбарыг хөгжүүлэх явдлыг мал аж ахуйн талаар баримтлах гол чиглэл гэж үзэж байна. Энэ зорилтыг хангахын тулд орон нутгийн удирдлагын зүгээс мал аж ахуйг эрчимжүүлэх бодлого зөвлөмж боловсруулах, сайн чанарын хээлтүүлэгчээр хангах ажлыг зохион байгуулах, бэлчээрийн хүрэлцээ, усан хангамжийг сайжруулахад хүчин чармайлт гаргах нь чухал байна.



***Газар тариалан.*** Тариалан сум олон зууны тэртээгээс газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж ирсэн түүхэн уламжлалтай, тариаланд тохиромжтой үржил шимтэй газар нутагтай. 2006 онд 1570 га-д тариалалт хийсний 260 орчим га-д нь үр тариа, 20 га-д нь төмс, 10 га-д нь хүнсний ногоо, 1285 га-д нь малын тэжээлийн таримал ургамал тариалжээ. Газар тариалангийн үйлдвэрлэлийг аж ахуйн 4 нэгж, 5 байгууллага, 710 өрх эрхэлж байна. Сүүлийн жилүүдэд үр тариа, төмс, хүнсний ногооны тариалалт бага зэрэг буурч, харин усалгаатай нөхцөлд царгас тариалж, малын тэжээл бэлтгэх явдал илт нэмэгджээ. Бүх төрлийн таримал ургамлын га-ийн ургац тогтвортой байгаа нь тариалангийн үйлдвэрлэл эрхлэх боломж сайтайг харуулж байна.

Тус сумын газар тариалангийн үйлдвэрлэлд усалгааны систем их үүрэг гүйцэтгэдэг. «Алтан дуулга» ХК усалгааны тоног төхөөрөмжөө засаж сэлбэхийн зэрэгцээ талбайгаа нэмэгдүүлж техник шинэчлэл хийж ажилласнаар 2004 оны ургац хураалтын ажлаар улсын тэргүүний компаниар шалгарч байв. Цаашдаа газар тариалангийн техникийн шинэчлэл хийх, тариалангийн бүтээгдэхүүнийг сумандаа боловсруулж эцсийн бүтээгдэхүүн гаргах, усалгаатай хадлан нэмэгдүүлэх, царгасны үр үйлдвэрлэж борлуулах, чацаргана, жимс жимсгэнэ тариалах, арвай, царгасыг нутгийн бренд бүтээгдэхүүн болгох зорилт тавьж байна. Газар тариалангийн салбарт дэвшил гаргах үндсэн нөхцөл нь Галдан бошигтын сувгийг сэргээж, үерийн хамгаалалт хийх, усны хангамжийг нэмэгдүүлэх явдал гэж тооцдог.





***Уул уурхай, олборлох үйлдвэр.*** Тариалан сум нүүрс, алт, барилгын материал зэрэг байгалийн баялагтай. Өмнө дурьдсанчлан тус суманд одоо нүүрсний 2 уурхай, алтны 3 уурхай ажиллаж байна.

Уул уурхайн үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд:

- Хар тарвагатайн нүүрсний уурхай 1964 оноос ажиллаж байгаа, Увс, Ховд аймгийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нүүрсний хэрэгцээг хангадаг. Мөн Мээрэнгийн алтны уурхайд олборлолт хийдэг.
- «Дацан трейд» ХК 1997 оноос ажиллаж байгаа. Хужирт, Сангийн ширгийн алтны ордод олборлолт хийдэг. 1999 онд ОХУ-ын «Селгедр-Монголия» ХХК-тай хамтарч Бургастай голд алтны олборлолт хийж жилд 250 кг алт олборлож байсан.
- «Эрдэс-Увс« ХХК 1997 оноос ажиллаж байгаа, Довтын нүүрсний уурхайд олборлолт хийдэг. Өөрийн аймагт албаны нүүрсний борлуулалт хийдэг. Цаашид үйлдвэрлэлээ нэмэгдүүлж гэр ахуйн хэрэгцээний нүүрс гаргах зорилт тавин ажиллаж байна.

Сумын хэмжээгээр жилдээ 40.0 мянга орчим тн нүүрс, 30-250 кг алт олборлож байна. Цаашид олборлох үйлдвэрийн талаар барилгын материалын үйлдвэрлэл шинээр үүсгэн хөгжүүлэх, олборлох үйлдвэрлэл явуулж байгаа болон явуулж дууссан газруудад техникийн ба байгалийн нөхөн сэргээлтийг стандартын хэмжээнд хийхэд илүү анхаарал хандуулан холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах чиглэлтэй байна.





***Боловсруулах үйлдвэр.*** Тариалан суманд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн дахин боловсруулах үйлдвэр сул хөгжсөн. Газар тариаланд түшиглэсэн гурил, арвайн гурил, малын тэжээлийн үйлдвэр, мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээс гадна эсгийний жижиг үйлдвэр ажилладаг. Цаашдаа хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний



боловсруулалтын түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн хүнсний ногоо, жимс жимсгэнийг савлах, мах, сүү, өлөн боловсруулах, хадгалах болон мөнгөний урсгалыг сумын дотор шингээх зорилгоор хүн амын өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг сумынхаа дотоодод үйлдвэрлэх зорилго тавьж, бизнесийн орчныг сайжруулах ажлыг үүнд чиглүүлэх зорилт дэвшүүлж байна

***Худалдаа, үйлчилгээ.*** Сумын эдийн засагт давамгайлах байх суурь эзэлдэг томоохон салбарын нэг нь худалдаа, үйлчилгээ юм. Тус суманд аж ахуйн 3 нэгж, 14 иргэн худалдаа эрхэлж, үйлчилгээний чиглэлээр аж ахуйн 1 нэгж, 33 иргэн үйл ажиллагаа явуулж байна. Иргэдэд чиглэсэн худалдаа үйлчилгээний чанарыг орчин үеийн шаардлагын түвшинд хүргэхийн тулд зам тээвэр, харилцаа холбоо, хууль эрх зүй, түншлэл зэрэг сумын гадаад дотоод дэд бүтцийг сайжруулах нь чухал юм.



***Аялал жуулчлал.*** Одоогоор сумын нутаг дэвсгэр дээр гадаадын анчид ирж агнуур хийж байгаагаас өөрөөр аялал жуулчлал хөгжөөгүй байна.





Аймаг, сумын төвд ойр байршил бүхий Хархираа, Түргэний уулс, Увс нуур зэрэг байгалийн үзэсгэлэнт газар нутаг, ой мод, агнуурын ан амьтан, нутгийн өвөрмөц соёл, язгуур урлагт түшиглэсэн аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой бөгөөд үүнийг сумын хөгжлийн ирээдүйн нөөцийн нэг гэж тооцдог.

## 4.2. Дэд бүтэц, үйлчилгээ

***Зам.*** Тариалан сум аймгийн төвөөс 31 км, улсын нийслэлээс 1350 км алслагдсан, аймгийн төвтэй сайжруулсан шороон зам, улсын нийслэлтэй 400 км хатуу хучилттай, 385 км нь сайжруулсан шороон, 565 км шороон замаар холбогдоно. Сумын дотор бүхэлдээ хээрийн шороон замтай, давааны зам засагдаагүй, замын нөхцөл үндсэндээ тааруу. Сумын төвийг аймгийн төвтэй хатуу хучилттай замаар холбох, сумын төвийн дотоод замыг сайжруулах нь аялал жуулчлал хөгжүүлэх, бизнес эрхлэгчид, иргэдийн бизнесийг дэмжих чухал хүчин зүйл болох юм.

***Эрчим хүч.*** Сумын төв, Хархираа баг ОХУ-аас орж ирсэн баруун бүсийн эрчим хүчний системд холбогдсон, эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй. Бусад багууд болон хөдөөгийн малчдад цахилгааны шугам хүрээгүй. Малчдын 40 гаруй хувь нь нарны сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй болоод байна. Өндөр хүчдэлийн шугамтай газрууд цахилгаан эрчим хүчээр хангагдсан боловч төв шугамаас салбарласан дамжуулах шугам, дотоод холболтууд муудаж, засвар хийх шаардлагатай болсон.

***Хүн эмнэлэг.*** 1931 онд байгуулагдан 1941 онд бага эмчийн, 1971 онд их эмчийн салбар болон бэхэжжээ. Одоо их эмч 3, бага эмч 10, нийт 33 орон тоотой, 2 салбар эмнэлэгтэй 32.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, ЭХО аппарат болон шинжилгээний тоног төхөөрөмжтэй, дуудлагын машин, хөдөөгийн багийн 4 эмч мотоцикльтэйгээр ард иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байна. Эмнэлгийн байрыг өргөтгөх, багаж, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах, гэрийн нөхцөлд ойртуулсан эхчүүдийн амрах байр шинээр байгуулах шаардлагатай байна.

***Боловсрол.*** Сумын сургууль анх 1940 онд байгуулагдаж, 1950 онд 4 анги бүхий анхны хичээлийн байр ашиглалтанд орсон бөгөөд 1967 онд 7 жилийн, 1970 онд 8 жилийн, 1993 онд 10 жилийн сургууль болж өргөжжээ. Сумын төв дэх ахлах сургууль, Хархираа, Толь багийн бага сургуулийн 32 бүлэгт 1100 хүүхэд суралцаж, дотуур байранд 290 хүүхэд сууж, 38 багш, 28 ажиллагсад ажиллаж байна. Хүн амын өсөлтөөс шалтгаалан дунд сургуулийн хичээлийн болон дотуур байрын хүрэлцээ бага, тохижилт хангалтгүйгээс хичээлийн ба дотуур байрыг өргөтгөх шаардлагатай болоод байна.

***Хүүхдийн цэцэрлэг.*** 1955 онд байгуулагдсан. Одоо үндсэн 3 бүлэгт 150-аад хүүхэд, цагийн 1 бүлэгт 26 хүүхэд байнга хамруулдаг. Бэлтгэл бүлэгт 140-160 хүүхдийг хамруулан сургуулийн өмнөх бэлтгэлийг хангаж байна. Яслийн зориулалттай хуучин байранд ажилладаг хүүхдийн цэцэрлэгийн барилгыг өргөтгөж сургуулийн өмнөх боловсролын хамралтын нэмэгдүүлэх шаардлагатай болсон.

***Соёлын төв.*** 1943 онд «Улаан гэр» нэртэйгээр анх үүсч, 1964 онд Орон нутаг судлах кабинет нэртэйгээр өргөжин байгуулагдсан. 2003 онд аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүсийн хандиваар 350 хүний суудалтай соёлын төв, 130-аад үзмэртэй музей ашиглалтанд оруулан ажиллуулж байна. Соёлын төвийг түшиглэн хотон ястны язгуур урлагийг залуу үед өвлүүлэх сургалт зохион байгуулах, байнгын ажиллагаатай урлагийн хамтлаг бий болгох зорилт тавьж байгаа бөгөөд энэ нь сумын урлагийн авъяаснууд орон нутагтаа тогтвортой ажиллах, аялал жуулчлал хөгжих нөхцлийг бүрдүүлэхэд түлхэц болох юм.

***Холбоо.*** Утсан харилцаа 1948 онд байгуулагдсан бөгөөд 1983 оноос «Экран КР-1» станц суурилагдаж үндэсний, «Орбит», 1992 оноос «Азиасат» станц байгуулагдаж үндэсний телевизийн нэвтрүүлэг хүлээн авч үзэж байна. 2001 онд бүх багийг радио холбоогоор хангасан «ВИСАТ» системд шилжсэнээр улс, хот хооронд шууд ярих боломжтой болсон. 2002 оноос Өвөрмонголын антен байрлуулан орон нутгийн нэвтрүүлэг явуулж байна. 2007 оноос Интернетийн үйлчилгээ нэвтэрч байна.

***Банкны салбар*** анх 1978 онд улсын банкны салбар нэртэйгээр байгуулагдан, ХААН банкны салбар болон өргөжсөн байна. 2004 оноос «Хас» банкны явуулын үйлчилгээ ажиллаж эхэлсэн. Эдгээр банкны салбарууд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд төлбөр тооцоо, хадгаламж, зээлийн үйлчилгээ явуулж байна.

***Мал эмнэлгийн салбар.*** 1933 онд анх байгуулагдсан бөгөөд 1936 онд малын бага эмчийн салбар, 1964 оноос өргөжин их эмчийн салбар болж 1999 оноос хувьчлагдан одоо хувийн хэвшлийн 2 хоршоо болж 7 мэргэжилтэнтэй ажиллаж байна.

## 4.3. Зах зээл, маркетинг

Тариалан сумын бүтээгдэхүүний борлуулалт, ханган нийлүүлэх зах зээл нь сумын газарзүйн байршил, дотоодын үйлдвэрлэл, иргэдийн хэрэглээний шинж чанараар тодорхойлогдож байна. Хөдөө аж ахуйн түүхий эд, боловсруулсан бүтээгдэхүүнийг ихэвчлэн аймгийн зах зээлд хүргэн худалдаж, өргөн хэрэглээний барааг аймгийн төв, Улаанбаатар хот, хилийн боомтуудаас татдаг.

Аймгийн төвтэй ойр байршдаг учраас сумын иргэдэд чиглэсэн худалдаа, үйлчилгээ аймгийн төвийн зах зээл рүү татагдаж, сумын эдийн засгийн хөгжилд муу нөлөөлдөг тал бий. Цаашдаа аймгаас авдаг сумын дотоод хэрэгцээний бараа бүтээгдэхүүнийг өөрийн үйлдвэрлэлээр хангах, үүний тулд аймгийн төвийнхөөс дутуугүй чанартай үйлдвэрлэл үйлчилгээ бүрдүүлэх, үндэсний болон гадаад зах




зээлд гарах, аялал жуулчлал хөгжүүлэх зорилт тулгарч байна. Энэ зорилтыг хангах зорилгоор арвайн гурил, царгасны үр зэрэг бренд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөтгөх, чанарыг нь орчин үеийн шаардлагын хэмжээнд хүргэх, гахай, тахианы мах, сүү, жимс жимсгэнэ зэрэг эрэлт ихтэй шинэ бүтээгдэхүүн гаргах, худалдаа үйлчилгээний нөхцлийг эрс сайжруулах шаардлагатай байна.

## 4.4. Суманд хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүд

***Дэлхийн Банкны «Тогтвортой амьжиргаа» төсөл*** 2002 онд хэрэгжиж эхэлснээс хойш орон нутгийн санаачлагын сангийн хүрээнд сургууль, цэцэрлэгт халаалт тавих, ахлах сургуульд 96 хос ширээ сандал, сумын халуун усны халаалтын засвар, хүн эмнэлгийг ЭХО аппарат, дуудлагын машин, багийн эмч нарыг мотоциклоор хангах зэрэг 51.8 сая төгрөгийн, бэлчээрийн мал аж ахуйн эрсдэлийн удирдлагын сангаас 1 компанид тоног төхөөрөмжийн зээл, 10 хоршоонд хөнгөлөлттэй зээл олгож, бэлчээрийн 2, ундны усны 1 худаг засварлах, бэлчээр, эрсдэлийн менежментийг сайжруулах төлөвлөгөө, зөвлөмж, зураглал гаргах зэрэг 55.8 сая төгрөгийн, зээлийн эргэлтийн сангаас 6.0 сая төгрөгийн зээл олгож, нийт дүнгээрээ 113.6 сая төгрөгийн өртөг бүхий үйл ажиллагаа хэрэгжсэн юм.

***ННФ-ын ДЕЛТА төсөл:*** «Сумын эдийн засгийн хөгжлийн 2007-2015 оны стратеги» боловсруулах, бизнесийн хөгжлийн алба байгуулах төслийг санхүүжүүлж хэрэгжүүллээ. 2007-2008 онд сумын төвийг тохижуулах, байгаль орчныг нөхөн сэргээх чиглэлээр хоёр төсөл шинээр санхүүжүүлж хэрэгжүүлэх ажилдаа ороод байна

***Дэлхийн Банкны «Малын индексжүүлсэн даатгал» төсөл:*** Малчдын малыг эрсдэлийн даатгалд хамруулах чиглэлээр ажиллаж, 2006 оны байдлаар 88 малчин өрх малаа энэ даатгалд хамруулжээ.

***НҮБ-ын хөрөнгө оруулалттай Алтай-Соёны төсөл:*** Байгаль хамгааллын сургалтууд явуулж, газрын даамал, байгаль хамгаалагчдыг чадавхижуулах, малчдыг сүү цагаан идээ боловсруулах, жолооч нарыг «ойн зохистой хэрэглээ», 4 хүнийг хөтөчийн, Хөхөө багийн иргэдийг төсөл бичих арга зүйн сургалтад хамруулжээ. Өсвөрийн байгаль хамгаалагч бий болгох зорилгоор байгальтай танилцах 20 хүүхэдтэй аялал зохион байгуулж, Хустайн байгалийн цогцолбор газарт 1 хүнийг туршлага судлуулан «Нөхөрлөл хөгжлийн наадам»-д 3 хүнийг оролцуулсан байна. Нутгийн иргэд байгууллагад тусламж болгож, сумын ИТХ-д 5х4 хэмжээтэй асар, 4 багт багийн холбооны зай хураагуур олгожээ.



# БҮЛЭГ 5

# СУМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ

## 5.1. Бизнесийн орчны судалгааны дүн

Орон нутгийн ЭЗХ-ийн стратеги боловсруулах ажлын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны нэг нь сумын бизнесийн орчны судалгаа байв. Судалгааг 2006 оны 8, 9-р сард явууллаа. Энэхүү судалгаа нь ОНЭЗХ-ийн стратеги боловсруулахад шаардагдах суурь мэдээлэл хуримтлуулах зорилготой бөгөөд энэ явцад сумын эдийн засаг, бизнесийн хөгжлийн тухайн үеийн байдал, хэтийн төлвийг ойлгож мэдэх, ололттой талууд ба тулгамдаж буй асуудлын талаар бодитой мэдээлэл авах туршлага дадлага эзэмшихэд нь орон нутгийнханд туслах зорилгыг давхар агуулж байлаа. Судалгааны дүнг олон нийтээр хэлэлцүүлж тэдний саналыг авсан болно.

***Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн тухай товч***

- Бизнесийн орчны судалгаанд бизнес эрхлэгч 46 аж ахуйн нэгж, иргэдийн 50%, 1022 малчдын 4.9% нь хамрагдсан нь сумын бүх бизнес эрхлэгчдийн 6.8% болж байна.
- Судалгаанд өмчлөгч эзэн 67, гүйцэтгэх захирал 4, бусад ажилтан 2 оролцлоо.
- Нийтдээ 50 малчин хамрагдсаны дотор чинээлэг малчин 8.0, боломжийн амьжиргаатай нь 62.0, ядуу нь 30.0 хувийг эзэлж, төлөөллийг боломжийн түвшинд хангав.
- Судалгаанд оролцогчдыг эрхэлж буй үйлдвэрлэл, үйлчилгээний төрлөөр нь хуваавал, мал аж ахуйн 54, газар тариалангийн 21, үйлдвэрлэлийн 5, худалдааны 13, үйлчилгээний 9, уул уурхайн 3 нэгжийн төлөөлөл хамрагджээ.
- Судалгаанд хамрагдагсдын бизнес эрхэлсэн хугацааг нь авч үзвэл 9.5% нь 5 хүртэл жил, 23.3% нь 6-12 жил, 67.1% нь 13-аас дээш жил ажилласан хүмүүс байв.
- Аж ахуйн нэгж, малчин өрхийн 73.9% нь 5 хүртэл, 21.7% нь 6-50, зөвхөн 4.3% нь 50-аас дээш тооны ажиллагсадтай.

***Сумын бизнесийн өргөжилт.*** Тариалан суманд малчдын 84.0%, бусад бизнес эрхлэгчдийн 69.3% нь өөрийн эрхэлж буй бизнесийг өргөжиж байгаа гэж үнэлсэн нь тус суманд бизнесийн үйл ажиллагаа ерөнхий хандлагаараа өргөжиж байгааг илэрхийлж байна. Гэхдээ малчдын 1/6, бизнес эрхлэгчдийн 1/3 нь өөрчлөлт гараагүй гэснийг анхаарвал зохих асуудал юм.

***Бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүнээ борлуулдаг зах зээл.*** Тус сумын бизнес эрхлэгчид бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнийхээ 2/3-ийг суман дотроо борлуулдаг байна. Гэтэл малчид бүтээгдэхүүнийхээ 60 хувийг аймгийн төвд хүргэн борлуулж байгаа нь ойр байршдагтай холбоотой. Тус сумын бизнес эрхлэгчид үндэсний болон бүс нутгийн зах зээлд оролцоо багатай хэвээрээ байна. Борлуулалтын тодорхой хэсэг аймгийн төв рүү шилжиж байгаа нь томоохон зах зээлтэй холбогдох гэсэн эерэг тэмүүлэл боловч мөнгөний урсгалыг гадагшлуулах сөрөг нөлөөтэй.

***Бизнесийн ирээдүйн хэтийн төлөвийн талаарх бизнес эрхлэгчдийн үнэлгээ.*** Сумын дүнгээр судалгаанд оролцогчдын 74.0 хувь, үүний дотор бизнес эрхлэгчдийн 95.7, малчдын 64.0 хувь нь бизнесийнхээ ирээдүйг өөдрөг, өсөн хөгжих боломжтой гэж үнэлснийг сэтгэл зүйн болон ирээдүйдээ итгэх итгэл сайн байгаа гэж үзэж байна.

***Мэргэжилтэй ажиллагсдын хангамж, хэрэгцээ.*** Судалгааанд оролцсон бизнес эрхлэгчдийн 65.2 хувь нь бизнесээ өргөжүүлэхэд мэргэжилтэй ажиллах хүч хэрэгтэй гэж хариулжээ. Судалгааны дүн нь орон нутгийнхний мэргэжил, дадлагыг дээшлүүлэх талаар сумандаа хэрэгжүүлж болох сургалтын чиглэлийн талаар чухал

мэдээлэл болсон юм. Орон нутгийн бизнесийнхэн хамгийн эрэлттэй сургалтын тоонд санхүү, бүртгэл, компьютер, технологи, менежмент, маркетинг зэрэг чиглэлийг оруулж ач холбогдол өгч байна. Малчдын тухайд чадвараа бэхжүүлэх, технологи ба менежментийг сайжруулах, малын ашиг шим, бүтээгдэхүүний чанарын хяналтын сургалт, дадлагажуулалтын арга хэмжээ шаардлагатай гэжээ.

***Бизнесийн өрсөлдөөн.*** Судалгаанд хамрагдсан хүмүүсийн үзэж байгаагаар сумандаа болон аймгийн төвийн зах зээлд бизнесийн өрсөлдөөн илүү ажээ. Малчид үндэсний хэмжээнд өрсөлдөнө гэдгийг тайлбарлаж байгаагаас харвал тус сумынхан патентийг нь эзэмшдэг «Арвайн гурил», «Бэд - царгас өвс» зэрэг бүсийн ба аймгийн брэнд бүтээгдэхүүнийг өрөгжүүлэхийг сонирхож буйтай холбоотой юм.

***Бизнес, борлуулалтаа сайжруулах арга хэмжээ.*** Бараа үйлчилгээний нэр төрөл, чанарыг сайжруулах, үнийг бууруулах, хэрэглэгч, захиалагчаа зөв сонгох явдал хэрэглэгчдийг илүү татах, борлуулалтаа нэмэгдүүлэх гол арга зам гэж үзэж байна. Сумын бизнес эрхлэгчдийн хувьд энэ нь бизнесээ өргөжүүлэхийн зэрэгцээ борлуулалтаа нэмэгдүүлэх асуудлыг уялдаатай авч үзсэн нь бизнесээ хөгжүүлэх боломжийг зөв төсөөлж байгаагийн илрэл юм.

***Бизнесийг хөгжүүлэхэд бизнесийн холбоо, байгууллагуудын туслалцаа.*** Малчдын 70%, бизнес эрхлэгчдийн 28.6% нь бизнесийн холбоо, байгууллагууд тусалдаггүй гэжээ. Гэвч орон нутгийн эдийн засаг, бизнес хөгжихэд бизнесийн холбоо, байгууллагуудын дэмжлэг туслалцааг авах асуудлыг хоёр талтай авч үзэх ёстой. Бизнесийн холбоо, байгууллагууд малчдад бараг хүрдэггүй нийтлэг дүр зураг энэ суман дээр ажиглагдлаа.

***Бизнесээ цаашид өргөжүүлэх сонирхол***. Судалгаанд оролцогчдын тал орчим нь сумандаа, 30 гаруй хувь нь аймгийн төвд байршуулж өргөтгөх, 10-30 хувь нь чанарыг сайжруулах, эрчимжүүлэх, харин 60 гаруй хувь нь үйлдвэрлэлийнхээ хэмжээг нь томруулна гэсэн дүн малчид, бизнес эрхлэгчид бизнесээ цаашид өргөтгөх сонирхолтой байгааг харууллаа.

***Шинээр бизнес эрхлэх болон өргөтгөхөд тохиолдож буй гол бэрхшээлүүд***. Бизнес эрхлэгчдийн хувьд хамгийн ноцтой бэрхшээлүүд нь хөрөнгө, санхүүгийн дутагдал, технологийн ба дэд бүтцийн асуудалтай холбоотой ажээ. Бэлчээр, усны хүрэлцээ муу, цаашдаа улам хүндрэх төлөвтэй болж байгаа сөрөг үр дагавар бүхий экологийн өөрчлөлтүүдийг гол бэрхшээл хэмээн малчид нэрлэж байна. Мэдээлэл муу байгааг хоёр бүлгийнхэн аль аль нь дурьджээ.

Зээлийн хүү өндөр, шатахууны үнэ өсөж байгаа, үйлдвэрлэл явуулах байр дутагдалтай зэрэг гадны хүчин зүйлс буюу саад бэрхшээлийн чанартай







асуудлуудыг бизнес эрхлэгчид, малчдын аль аль нь гол бэрхшээлд тооцож байна. Сум, зах зээлээс хол нутагладаг, бүтээгдэхүүний борлуулах боломж муу байдгийг малчид бэрхшээл хэмээн үздэг ажээ.

***Орон нутгийн захиргаа, бизнесүүдийн хамтын ажиллагаа.*** Орон нутгийн засаг захиргаатай ажиллахад зарцуулах жилд хугацаа харьцангуй богино (бизнес эрхлэгчдийнхээр 19, малчдынхаар 14 хоног) боловч энэхүү хугацааг боломжийн гэж үзэж байна. Энэ нь эдийн засаг-нийгмийг хөгжүүлэх үйл ажиллагааг төр-хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжүүлэх чиглэлийг стратегид тусгах үндэслэл болно.

***Сумын захиргааны зүгээс бизнест учирч буй сөрөг нөлөөлөл.*** Сумын төр захиргааны үйл ажиллагаанаас болж бизнест ноцтой сөрөг нөлөөлөл учрах нь харьцангуй бага гэсэн ерөнхий дүн судалгаанаас гарч байна. Гэхдээ үйлчилгээний төлбөр хураамж нь өндөр, мөрдөгдөж буй хууль тогтоомж, зохицуулалтад давхардал гардаг, зөрчилддөг, эсвэл сумын зах зээл дэх шудрага бус өрсөлдөөнийг хууль тогтоомжийн дагуу зохицуулах талаар үр нөлөө бүхий арга хэмжээ авдаггүй, зарим асуудлаар нийтлэг мөрдөх, тодорхой журам байхгүй гэх мэт зарим асуудлууд нөлөөлдөг гэсэн санааг судалгаанд оролцогчид илэрхийлжээ.

***Сумын төр, захиргаанаас хүсч байгаа дэмжлэг.*** Бизнес эрхлэгчдээс хүсэж буй дэмжлэгийн ерөнхий хандлага, агуулга нь бизнес өргөжүүлэх, шинээр эхлэхэд тохиолдох бэрхшээлтэй нэлээд уялдаатай байна. Хөрөнгийн эх үүсвэр олох, дэд бүтцийг сайжруулах, зах зээл олох, борлуулалтад дэмжлэг үзүүлэх зэрэг зуучлах ба уламжлан шийдвэрлүүлэх арга хэмжээнээс гадна мэдээллээр хангах семинар, сургалт, дадлагажуулалтын арга хэмжээ зохион байгуулах ажлууд багтаж байна. Бэлчээр ашиглалт, хамгаалалт, усны хангамжийг сайжруулах, бүтээгдэхүүн

борлуулалт, хөрөнгийн эх үүсвэр олох, банктай харилцахад зуучлах, төсөл хэрэгжүүлж малчдыг хамруулах, малчдын хоршилтыг дэмжих зэрэг эдүгээ нэн тулгамдсан асуудлуудыг хөндөж сумаас арга хэмжээ авах, дэмжлэг үзүүлэхийг хүссэнийг малчин зоны эрэлт гэж ойлгох нь зүйтэй.

***Бизнесийн үйл ажиллагаа, өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйлс.*** Бизнес эрхлэгчдийн хувьд бизнесийн үйл ажиллагаанд их нөлөө бүхий хүчин зүйлсийн тоонд дэд бүтцийн салбаруудаас автозам, агаарын тээвэр, нийтлэг үйлчилгээнээс холбоо, эрчим хүч, усан хангамж, амьжиргааны чанарыг харуулах хүчин зүйлсээс татвар, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах байр, бусад хүчин зүйлсээс авилгал, санхүүгийн эх үүсвэр олох боломж, бизнест дэмжлэг үзүүлэх үйлчилгээний боломж зэргийг оруулсан нь бодит байдалтай нэлээд дүйж байна.

Малчдын үзэж байгаагаар бэлчээрийн усан хангамж, хэв журмын зөрчил, гэмт хэрэг, санхүүжилт олох боломжийг тэдний бизнес үйл ажиллагаанд хамгийн их нөлөөтэй, түүнчлэн бизнесийн дэмжлэг авах боломж хомсдуу нь зохих нөлөө үзүүлж байна гэж тодорхойлжээ. Мал аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулахад малын хулгайг бууруулах, нийгмийн сөрөг үр дагавар бүхий бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авилгал гар харах явдлыг арилгах, санхүүжилтийн эх үүсвэр олох боломж, бизнес дэмжих үйлчилгээ тааруухан байгаад цаашид анхаарах нь зүйтэй.

***Суман дахь хамгийн өсөлттэй салбарууд.*** Малчид, бизнес эрхлэгчдийн үзэж байгаагаар сүүлийн 5 жилийн байдлаар хамгийн их өсөлттэй салбарын тоонд мал аж ахуй, газар тариалан, уул уурхай, худалдаа үйлчилгээ орж байна. Энэ нь гол төлөв тооны өсөлтийг харгалзан эрэмбэлсэн үзүүлэлт бөгөөд хөдөөгийн эдийн засаг-бизнесийн гол ноён нуруу болсон салбарууд өсөлттэй байгаа нь эдийн засгийн өсөлт бий болгох таатай давуу тал юм.

***Суман дахь хамгийн их уналттай салбар.*** Сүүлийн 5 жилд ахуйн үйлчилгээ, эрүүл мэнд, дэд бүтэц, мал эмнэлэг, усан хангамж зэрэг салбарууд хамгийн их уналттай байгаа гэж бизнес эрхлэгчид, малчид үзсэн байна. Төрийн ба хувийн хэвшлийн үйлчилгээний салбарыг уналттай гэж дүгнэж байгаа нь сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн чиг баримжааг бизнесийн орчин, төрийн үйлчилгээг сайжруулахад чиглүүлэх нь чухал болохыг нотолгоо гэж үзэж байна.

***Хөрөнгө оруулалтыг татаж байгаа салбарууд.*** Алт, нүүрс зэрэг ашигт малтмалын нөөц, тариаланд тохиромжтой нөхцөл, ажилсаг, боловсролтой хүний нөөцөд түшиглэсэн салбарууд хөрөнгө оруулалтыг татаж байна гэж судалгаанд оролцогсод үзжээ. Түүнчлэн байнгын эрчим хүч, аймгийн төвд ойр оршдог, мал аж ахуй эрхэлж ирсэн уламжлал зэрэг нөхцлүүд тодорхой давуу талыг нөхцөлдүүлж

буй ажээ. Цаашдаа эдгээр давуу талд түшиглэхээс гадна бусад салбарын хөгжлийг түлхүү дэмжих замаар эдийн засгийн бодитой өсөлтийг тогтворжуулах явдал стратегийн чухал зорилт байх нь мэдээж юм.

***Бизнесийн хөгжилд саад болж буй сул талууд.*** Мал аж ахуй зонхилсон эдийн засгийн суурь бүхий сумдтай адил байгалийн бэрхшээлээс авахуулаад бизнес тогтвортой эрхлэхэд шаардлагатай санхүүгийн сул чадавхи, техник-технологи хоцрогдсон, материал, шатахуун, тээврийн зардлын өсөлт, банк-зээлийн тааламжгүй нөхцөл, мал аж ахуйд нэн чухал усны ба бэлчээрийн хомсдол, сургалт-мэдээлэл дутагдалтай зэрэг олон хүчин зүйлсийг тус сумын бизнесийн хөгжилд тааламжгүй нөлөөлдөг хэмээн тодорхойлжээ. Авто зам, банк, үйлдвэрлэл, үйлчилгээний байр зэрэг дэд бүтцийг сайжруулахын хамт архидалт, ажилгүйдэл, малын хулгай, хүнд сурталтай тэмцэл явуулах асуудлаар оновчтой шийдвэр гаргаж хэрэгжүүлэх нь чухал байна.

***Сумын эдийн засгийн орчин, хөгжлийн өөрчлөлт.*** Бизнес эрхлэгчдийн 82, малчдын 97% нь тус суманд бизнес эрхлэх орчин сайжирсан гэж үзсэн нь тэдний бизнесийн үйл ажиллагаа өөдрөг байгаа гэсэн өмнөх хариулттай нийцэж байна. Нэг талаас энэ нь бизнес хөгжүүлэх таатай орчин бүрдүүлэхэд сумын төр, захиргааны зүгээс зохих хэмжээнд анхаарч ирсэнтэй холбоотой дүгнэлт мөн. Сумын дүнгээр, санал асуулгад оролцогчдын 20 орчим хувь сумын эдийн засаг хурдацтай өсч байгаа, 60 гаруй хувь нь дунд зэрэг гэж үнэлжээ. Сүүлийн 5 жилд шинээр алтны уурхай нээгдсэн, газар тариалангийн үйлдвэрлэл өргөжсөн, мал сүргийн тоо толгой өсч байгаа зэрэг тооны ба чанарын өсөлтийг үндэслэн судалгаанд хамрагдагсдын олонхи нь сумын эдийн засгийн хөгжлийн өсөлтийг дунд зэрэг гэж үнэлж байгаа нь эдийн засгийн хөгжлийн өсөлтийн хурдацад сэтгэл хангалуун биш байгаагийн илрэл гэж тооцож болох юм.

## 5.2. СВОТ шинжилгээ

Сумын бизнесийн орчны талаархи олон нийтийн үнэлгээний дүнд тулгуурлан сумын хөгжлийн дотоод орчны давуу болон сул тал, гадаад орчны боломж, саад бэрхшээлийг СВОТ шинжилгээний матрицаар тодорхойлов.

СВОТ шинжилгээний матриц

| Дотоод орчны | | Гадаад орчны | |
|---|---|---|---|
| **Давуу тал** | **Сул тал** | **Боломж** | **Саад бэрхшээл** |
| 1. Хүн ам нь бэлчээрийн мал ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх уламжлалт дадлага туршлагатай.<br>2. Сумын иргэд нь аймгийн бусад сумдаас илүү ажилсаг.<br>3. Мал аж ахуй, газар тариалан эрхлэх тохиромжтой бэлчээр, газар нутагтай<br>4. Алт, нүүрс, шохой зэрэг байгалийн ашигт малтмалын баялаг нөөцтэй.<br>5. Аялал жуулчлал хөгжүүлэх байгалийн үзэсгэлэнт болон түүх, соёлын дурсгалт газар, язгуур урлагийн өв уламжлалтай.<br>6. Бизнес эрхлэх арга ухаан, дадлага туршлага төлөвшсөн, бизнесээ өргөтгөх, шинээр нэмэгдүүлэх сонирхолтой.<br>7. Хүн ам харьцангүй олон тул худалдаа үйлчилгээний боломжийн багтаамж бүхий зах зээлтэй.<br>8. Байршлын хувьд аймгийн төвд ойр<br>9. Олон нийтийн санаачлага, бүтээлч идэвх сайжирч байгаа.<br>10. Томоохон үйлдвэрлэл эрхэлдэг бизнесүүд нь бага зэргийн эрсдлийг дааж гарах эдийн засгийн чадавхитай. | 1. Бизнес эрхлэгчдийн хөрөнгийн хуримтлал, санхүүгийн эх үүсвэр дутмаг<br>2. Орон нутгийн төсвийн хүрэлцээ муу, зарцуулах эрх хязгаарлагдмал.<br>3. Ажил эрхлэлтийн түвшин доогуур, ажилгүйчүүдийн боловсрол, мэргэжил хангалтгүй.<br>4. Мэргэжилтэй ажиллагсдын эрэлтийг орон нутгийн сургалтаар хангаж чадахгүй байгаа.<br>5. Бизнес эрхлэгчдийн хоршилт, хамтын ажиллагаа сул, тус тусдаа хувиа хичээж ажилладаг.<br>6. Сайн хүчин чадал бүхий жижиг дунд үйлдвэр хөгжөөгүй.<br>7. Техник, технологи, байгууламж хоцрогдсон.<br>8. Ханган нийлүүлэх төвлөрсөн зах зээлээс хэт хол.<br>9. Бэлчээрийн даац хэтэрч буй, усан хангамж хүрэлцээгүй.<br>10. Зочид буудал, ахуйн үйлчилгээ хангалтгүй.<br>11. Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах зориулалтын байр хүрэлцээгүй.<br>12. Жижиг дунд бизнес эрхлэгчид эрсдэлийг даах чадваргүй, эрсдэлээс хамгаалах тогтолцоонд хамрагдаагүй. | 1. Төвлөрсөн эрчим хүчний системд холбогдсон.<br>2. Сумын төв нь Мобиком, Скайтелийн сүлжээтэй.<br>3. Олон улсын байдал, хамтын ажиллагаа бизнесийн хөгжилд таатай нөлөөлдөг.<br>4. Хөгжлийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой<br>5. Үндэсний язгуур урлаг, өв соёлыг гадаадад их сонирхдог | 1. Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл байгаль, цаг ууraas шууд хамааралтай.<br>2. Банкны зээлийн хугацаа нь богино, хүү нь өндөр, барьцаа хөрөнгө шаарддаг.<br>3. Малын хулгай их, олон нийтийн аюулгүй байдал, хуулийн хэрэгжилт сул.<br>4. Замын нөхцөл түйлын муу.<br>5. Хөдөөгийн малчид эрчим хүч, холбооны үйлчилгээнд хамрагдаагүй.<br>6. Улсын төсвийн хөрөнгө оруулалт бага.<br>7. Төвлөрлийг сааруулах үйл явц удаашралтай.<br>8. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал тодорхойгүй.<br>9. Сумын хөгжил, үндэсний цөөнхийг дэмжих дэмжлэг бага.<br>10. Татварын хууль, дүрэм заавар бизнесийн хөгжилд сөрөг нөлөөлдөг,<br>11. Том бизнесийн нөлөөлөл хангалтгүй. |

| Дотоод орчны | | Гадаад орчны | |
|---|---|---|---|
| Давуу тал | Сул тал | Боломж | Саад бэрхшээл |
| 11. Сумын удирдлага бизнесийн үйл ажиллагааг дэмжиж хамтран ажилладаг.<br>12. Бизнесийн өрсөлдөөнд сумын захиргааны оролцоо бага<br>13. ОХУ, БНХАУ–тай гадаад худалдааны харилцаатай.<br>14. Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, олборлох үйлдвэрлэлд хөрөнгө оруулах, шинэ салбарууд үүсгэн хөгжүүлэх боломж харьцангуй сайн | 13. Бизнесийн мэдээлэл, мэдээллийн сан бүрдээгүй.<br>14. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулаагүй.<br>15. Байгаль хамгаалах цэгцтэй бодлого боловсрогдоогүй<br>16. Бизнест идэвхтэй, бүтээлч хэсгийн манлайлал, нийтэд үзүүлэх нөлөөлөл хангалтгүй.<br>17. Мал аж ахуйн үйлдвэрлэл эрчимжээгүй, боловсруулах үйлдвэр сул хөгжсөн.<br>18. Бизнесийн холбоод, хандивлагч, олон улсын байгууллагуудтай тогтоосон холбоо бага.<br>19. Бэлэнчлэх сэтгэлгээ буурахгүй байгаа | | |

## 5.3. Сумын хөгжлийн стратегийн алсын хараа, зорилго

Сумын хөгжлийн стратегийн агуулгыг дараах байдлаар тодорхойлсон болно. Үүнд:

1. Стратегийн алсын хараа, зорилго
2. Стратегийн зорилго, зорилт, хөтөлбөр, төсөл
3. Бизнесийн хөгжлийг дэмжих чиглэлүүд
4. Стратегийг хэрэгжүүлэх матриц
5. Төсөл эрэмбэлэх матриц
6. Төслийн хураангуй тодорхойлолт

Стратегийн алсын хараа, зорилго



## 5.4. Алсын хараа–зорилго–зорилт–хөтөлбөр–төслийн матриц

Алсын хараа: Онгон байгалийн үнэт баялаг, хөдөлмөрч түүхэн уламжлал, үндэсний ёс заншил, язгуур урлагаараа иргэдийнхээ ажиллаж амьдрах, сурч боловсрох таатай орчныг бүрдүүлэн, өөрийн үйлдвэрлэж боловсруулсан бүтээгдэхүүнээр эдийн засгаа бэхжүүлж, иргэдийнхээ амьжиргааны түвшинг дээшлүүлсэн сум байх

| Зорилго (Зо) | Зорилт (Зт) | Хөтөлбөр (Хө) | Төсөл (Т) | No |
|---|---|---|---|---|
| **Зо1:** Байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх | **Зо1:Зт1:** Ойжуулсан ба ойн зурвас байгуулсан талбайн хэмжээ 3 га байгааг 2010 гэхэд 8 га болгож өргөжүүлэх | **Зо1:Зт1:Хө1:** Байгаль, амьдрах орчны хамгаалалт | **Зо1:Зт1:Хө1:Т1:** Сумын байгаль орчны байдлын үнэлгээ хийх | 1 |
| | | | **Зо1:Зт1:Хө1:Т2:** Сумын төвийн төвлөрсөн хогийн цэгийн талбайг багасгах | 2 |
| | | **Зо1:Зт1:Хө2:** Ойн нөхөн сэргээлт, ойжуулалт | **Зо1:Зт1:Хө2:Т1:** Ойн зурвас бүхий нутаг, жимс жимсгэнийн талбайн ойжуулалт, сумын төвийн цэцэрлэгжүүлэлт | 3 |
| | **Зо1:Зт3:** Ашиглалт багатай байгаа 20000 га бэлчээрийг 2010 он гэхэд, 20000 га бэлчээрийг 2015 он гэхэд тус тус байнгын ашиглалтад оруулах | **Зо1:Зт3:Хө1:** Бэлчээрийн хамтын менежмент нэвтрүүлэх | **Зо1:Зт3:Хө1:Т1:** Бэлчээр, бэлчээр дэх бусад нөөцийн ашиглалт, зохицуулалтыг сайжруулах урт хугацааны төлөвлөгөө, журам боловсруулж хэрэгжүүлэх | 4 |
| | | **Зо1:Зт3:Хө2:** Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах | **Зо1:Зт3:Хө2:Т1:** Галдан бошигтын сувгийг сэргээж, толгойн хэсэгт үерийн хамгаалалт хийх | 5 |
| | | | **Зо1:Зт3:Хө2:Т2:** Хавар–намрын бэлчээрт худаг шинээр гаргах | 6 |
| **Зо2:** Үндэсний ёс заншил, язгуур урлаг, соёл, түүх дурсгалт газрыг хамгаалах, өвлүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх | **Зо2:Зт1:** 2009 он гэхэд жил бүр 200–аас доошгүй жуулчин, амрагч хүлээн авах чадавхи бий болгох | **Зо2:Зт1:Хө1:** Аялал, жуулчлалын бизнесийг дэмжих | **Зо2:Зт1:Хө1:Т1:** Улаангом–Тариалан чиглэлийн 31 км засмал зам тавих | 7 |
| | | | **Зо2:Зт1:Хө1:Т2:** Аялал жуулчлалын хөтөлбөр, танилцуулга, мэдээллийн гарын авлага хэвлүүлэх | 8 |
| | **Зо2:Зт2:** Үндэсний ёс заншил, язгуур урлагийн сургалтыг 2007 оноос эхлэн тогтмол зохион байгуулж, жил бүр 100–аас доошгүй хүн хамруулах | **Зо2:Зт2:Хө1:** Үндэсний ёс заншил, язгуур урлагийг өвлүүлэх, дэлгэрүүлэх | **Зо2:Зт2:Хө1:Т1:** Үндэсний ёс заншил, язгуур урлагийн сургалтын хөтөлбөр, гарын авлага, үзүүлэх материал бэлтгэх | 9 |
| | | | **Зо2:Зт2:Хө1:Т2:** Үндэсний хөгжмийн зэмсгээр хангагдсан язгуур урлагийн хамтлаг ЗДТГ–ын дэргэд байгуулах | 10 |
| | | | **Зо2:Зт2:Хө1:Т3:** Соёлын төвийн засвар, тохижилт | 11 |
| | | | **Зо2:Зт2:Хө2:Т4:** Үндэсний мичид, зурхайн байртай болох | 12 |

| Зорилго (Зо) | Зорилт (Зт) | Хөтөлбөр (Хө) | Төсөл (Т) | No |
|---|---|---|---|---|
| **Зо3:** Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний нөхцлийг сайжруулах, мэргэжилтэй ажиллах хүч бэлтгэх, амьдралын хэвийн нөхцөл бүрдүүлэх | **Зо3:Зт1:** 2015 он гэхэд сумын сургууль, цэцэрлэг, эмнэлгийн байрын ачааллыг багасгаж, үндэсний стандартад хүргэх | **Зо3:Зт1:Хө1:** Суурь боловсролын үйлчилгээний нөхцлийг сайжруулах | **Зо3:Зт1:Хө1:Т1:** Ахлах сургуулийн хичээлийн ба дотуур байрын их засвар, өргөтгөл, тохижилт | 13 |
| | | | **Зо3:Зт1:Хө1:Т2:** Цэцэрлэгийн өргөтгөл | 14 |
| | | **Зо3:Зт1:Хө2:** Эрүүл мэндийн үйлчилгээний нөхцлийг сайжруулах | **Зо3:Зт1:Хө2:Т1:** Сумын хүн эмнэлгийн өргөтгөл, тоног төхөөрөмжийн шинэчлэл | 15 |
| | **Зо3:Зт2:** 2007 оноос жил бүр 50–иас доошгүй хүнийг сургах, дадлагажуулах чадавхи бүрдүүлэх | **Зо3:Зт2:Хө1:** Нутгийн иргэдийн мэргэжлийн чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх | **Зо3:Зт2:Хө1:Т1:** ЗДТГ–ын дэргэд сургалтын байр гаргаж тохижуулах | 16 |
| | | | **Зо3:Зт2:Хө1:Т2:** Мэргэжүүлэх болон давтан сургах сургалтын эрэлтийн судалгаа явуулах | 17 |
| | **Зо3:Зт3:** 2010 он гэхэд мал хулгайн гэмт хэргийг 50% багасгах | **Зо3:Зт3:Хө1:** Малын хулгайг багасгах | **Зо3:Зт3:Хө1:Т1:** Цагдаагийн тасагтай болж, үйлчилгээний хүрээг өргөтгөх | 18 |
| | | | **Зо3:Зт3:Хө1:Т2:** Малчдыг хөдөлгөөнт холбооны сүлжээнд хамруулах | 19 |
| | | | **Зо3:Зт3:Хө1:Т3:** Малын хөдөлгөөнийг хянах дохиоллын систем нэвтрүүлэх | 20 |
| | **Зо3:Зт4:** 2015 он гэхэд спортоор хичээллэгсдийн тоог 40% нэмэгдүүлэх | **Зо3:Зт4:Хө1:** Биеийн тамир, спортыг дэмжих | **Зо3:Зт4:Хө1:Т1:** ЗДТГазрыг түшиглүүлэн чийрэгжүүлэх танхим байгуулах | 21 |
| | | | **Зо3:Зт4:Хө1:Т2:** Нийтийн биеийн тамир, сонирхогчдын спорт хөгжүүлэх, дэмжих сан бий болгох | 22 |

| Зорилго (Зо) | Зорилт (Зт) | Хөтөлбөр (Хө) | Төсөл (Т) | No |
|---|---|---|---|---|
| **Зо4:** Уламжлалт үйлдвэрлэлийг боловсронгуй болгон маркетингийг сайжруулах | **Зо4:Зт1:** 2015 он гэхэд мал аж ахуйн нийт бүтээгдэхүүний 5 хувийг эрчимжсэн аж ахуйгаас үйлдвэрлэх | **Зо4:Зт1:Хө1:** Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих | **Зо4:Зт1:Хө1:Т1:** Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулах | 23 |
| | | | **Зо4:Зт1:Хө1:Т2:** Мал эмнэлэг, үржлийн албыг өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх үндэслэл санал боловсруулах | 24 |
| | | | **Зо4:Зт1:Хө1:Т3:** Малын үүлдэр угсааг сайжруулахад зуучлах үйлчилгээ нэвтрүүлэх | 25 |
| | **Зо4:Зт2:** 2010 гэхэд худалдаа үйлчилгээний жижиг бизнесийг эрүүл ахуйн шаардлага хангасан байраар 100% хангах | **Зо4:Зт2:Хө1:** Худалдааны нөхцөл, ахуйн үйлчилгээг сайжруулахад дэмжлэг үзүүлэх | **Зо4:Зт2:Хө1:Т1:** Хүнсний захын барилга | 26 |
| | | | **Зо4:Зт2:Хө1:Т2:** Худалдаа, ахуйн үйлчилгээний нэгдсэн төвийн зориулалттай барилга | 27 |
| **Зо5:** Сумын бизнесийн орчныг сайжруулж, олон нийтийн идэвхийг өрнүүлэх | **Зо5:Зт1:** 2012 он гэхэд бизнес дэмжих төрийн үйлчилгээнд сэтгэл ханамжтай байдлыг 90%-иас доошгүй хэмжээнд хүргэх /оролцогчдын санал асуулгаар тогтоох/ | Зо5:Зт1:Хө1: Төрийн болон захиргааны үйлчилгээг сайжруулах боломж бүрдүүлэх | **Зо5:Зт1:Хө1:Т1:** Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах | 28 |
| | | | **Зо5:Зт1:Хө1:Т2:** Сум, багийн төр, захиргааны байрын засвар, өргөтгөл, тохижилт | 29 |
| | | | **Зо5:Зт1:Хө1:Т3:** Сумын төвийн гудамж, хорооллыг хаягжуулах, зам, замын тэмдгийг сайжруулах | 30 |
| | | | **Зо5:Зт1:Хө1:Т4:** Төрийн албанд ажиллагсдын орон сууцны хангамжийг сайжруулах (32 айлын орон сууц) | 31 |
| | | | **Зо5:Зт1:Хө1:Т5:** Нэг цэгийн үйлчилгээ нэвтрүүлэх | 32 |
| | **Зо5:Зт2:** 2015 он гэхэд бизнес эрхлэгчдийн сайжруулсан дэд бүтцийн үйлчилгээнд хамрагдалтыг 20 хувиас 80 хувьд хүргэх. | **Зо5:Зт2:Хө1:** Сумын төвийн эрчим хүч, дулааны хангамжийг сайжруулах | **Зо5:Зт2:Хө1:Т1:** Сумын төвийг дулааны нэгдсэн сүлжээнд хамруулах | 33 |
| | | | **Зо5:Зт2:Хө1:Т2:** Сумын төвийн цахилгааны шугам сүлжээний шинэчлэл | 34 |
| | | | **Зо3:Зт3:Хө1:Т3:** Сумын төвийн гэрэлтүүлгийг сайжруулах | 35 |

## 5.5. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн хэрэгжилтийн матриц

| Төслийн дугаар | Төслийн код, нэр | Өртөг | | Санхүүжилт | | | | | | Түншүүд | Хэрэгжүү-лэлт | | Хэрэгжилтийн байдал | Ашиг хүртэгчид |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Орон нутаг | | Улсын төсөв | | Хандив-лагчид | | | | | | |
| | | сая төг. | '000 $ | % | сая төг. | % | сая төг. | % | сая төг. | | Эхлэх | Дуусах | | |
| 1 | **Зо1:Зт1:Хө1:Т1:** Сумын байгаль орчны байдлын үнэлгээ хийх | 5.0 | 4.3 | 0 | 0 | 100 | 5 | 0 | 0 | Засаг даргын тамгын газар<br>Уул уурхайн компаниуд<br>Мэргэжлийн байгууллагууд | 2009 | 2009 | СХБ | Сумын нийт иргэд<br>Уул уурхайн компаниуд |
| 2 | **Зо1:Зт1:Хө1:Т2:** Сумын төвийн төвлөрсөн хогийн цэгийн талбайг багасгах | 20.0 | 17.2 | 10 | 2 | 0 | 0 | 90 | 18 | Засаг даргын тамгын газар<br>Бизнес эрхлэгчид ба байгууллагууд<br>Иргэд<br>Хандивлагчид | 2008 | 2008 | СХБ | Сумын нийт иргэд |
| 3 | **Зо1:Зт1:Хө2:Т1:** Ойн зурвас бүхий нутаг, жимс жимсгэнийн талбайн ойжуулалт, сумын төвийн цэцэрлэгжүүлэлт | 30.0 | 25.8 | 20 | 6 | 30 | 9 | 50 | 15 | Засаг даргын тамгын газар<br>Бизнес эрхлэгчид аж ахуйн нэгжүүд<br>Мэргэжлийн байгууллагууд<br>Хандивлагчид | 2008 | 2015 | Эхэлсэн, СХБ | Сумын нийт иргэд<br>Аж ахуйн нэгж, байгууллагууд |

Тэмдэглэгээ: СХБ - санхүүжилт хийж байгаа

| Төслийн дугаар | Төслийн код, нэр | Өртөг | | Санхүүжилт | | | | | | Түншүүд | Хэрэгжүү-лэлт | | Хэрэгжилтийн байдал | Ашиг хүртэгчид |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Орон нутаг | | Улсын төсөв | | Хандив-лагчид | | | | | | |
| | | сая төг. | '000 $ | % | сая төг. | % | сая төг. | % | сая төг. | | Эхлэх | Дуусах | | |
| 4 | **Зо1:Зт3:Хө1:Т1:** Бэлчээр, бэлчээр дэх бусад нөөцийн ашиглалт, зохицуулалтыг сайжруулах урт хугацааны төлөвлөгөө, журам боловсруулж хэрэгжүүлэх | 6.0 | 5.2 | 50 | 3 | 0 | 0 | 50 | 3 | Засаг даргын тамгын газар<br>Мал бүхий иргэд, аж ахуйн нэгжүүд<br>"Тогтвортой амьжиргаа" төсөл | 2008 | 2008 | СХБ | Засаг даргын тамгын газар<br>Сумын нийт иргэд<br>Малчид |
| 5 | **Зо1:Зт3:Хө2:Т1:** Галдан бошигтын сувгийг сэргээж, толгойн хэсэгт үерийн хамгаалалт хийх | 50.0 | 43.0 | 0 | 0 | 0 | 0 | 100 | 50 | Хандивлагчид<br>Засгийн газар<br>Бизнес эрхлэгчид | 2009 | 2010 | СХБ | Сумын нийт иргэд<br>Бизнес эрхлэгчид<br>Газар тариалангийн аж ахуйн нэгж<br>Өрхийн тариалан эрхлэгчид |
| 6 | **Зо1:Зт3:Хө2:Т2:** Хавар–намрын бэлчээрт худаг шинээр гаргах | 50.0 | 43.0 | 0 | 0 | 70 | 35 | 30 | 15 | Засгийн газар<br>Хандивлагчид<br>Бизнес эрхлэгчид | 2007 | 2015 | Эхэлсэн, СХБ | Сумын нийт иргэд<br>Бизнес эрхлэгчид |
| 7 | **Зо2:Зт1:Хө1:Т1:** Улаангом–Тариалан чиглэлийн 31 км засмал зам тавих | 3000.0 | 2577.3 | 0 | 0 | 100 | 3000 | 0 | 0 | Засгийн газар<br>ЗДТГ<br>Хандивлагчид | 2009 | 2011 | СХБ | Сумын нийт иргэд<br>Бизнесийн байгууллагууд |
| 8 | **Зо2:Зт1:Хө1:Т2:** Аялал жуулчлалын хөтөлбөр, танилцуулга, мэдээллийн гарын авлага хэвлүүлэх | 3.0 | 2.6 | 50 | 1.5 | 0 | 0 | 50 | 1.5 | ЗДТГ<br>Хандивлагчид<br>Бизнес эрхлэгчид<br>Мэргэжлийн байгууллагууд | 2008 | 2008 | СХБ | Сумын төр, захиргааны байгууллагууд<br>Сумын нийт иргэд<br>Бизнес эрхлэгчид |

| Төслийн дугаар | Төслийн код, нэр | Өртөг | | Санхүүжилт | | | | | | Түншүүд | Хэрэгжүүлэлт | | Хэрэгжилтийн байдал | Ашиг хүртэгчид |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Орон нутаг | | Улсын төсөв | | Хандивлагчид | | | | | | |
| | | сая төг. | '000 $ | % | сая төг. | % | сая төг. | % | сая төг. | | Эхлэх | Дуусах | | |
| 9 | **Зо2:Зт2:Хө1:Т1:** Үндэсний ёс заншил, язгуур урлагийн сургалтын хөтөлбөр, гарын авлага, үзүүлэх материал бэлтгэх | 10.0 | 8.6 | 10 | 1 | 0 | 0 | 90 | 9 | Иргэд<br>Хандивлагчид<br>Бизнес эрхлэгчид<br>Мэргэжлийн байгууллагууд | 2007 | 2015 | СХБ | Сумын нийт иргэд |
| 10 | **Зо2:Зт2:Хө1:Т2:** Үндэсний хөгжмийн зэмсгээр хангагдсан язгуур урлагийн хамтлаг ЗДТГ-ын дэргэд байгуулах | 10.0 | 8.6 | 0 | 0 | 0 | 0 | 100 | 10 | ЗДТГ<br>Хандивлагчид<br>Мэргэжлийн байгууллагууд | 2008 | 2011 | СХБ | Сумын нийт иргэд<br>Ардын авьяастнууд |
| 11 | **Зо2:Зт2:Хө1:Т3:** Соёлын төвийн засвар, тохижилт | 20.0 | 17.2 | 0 | 0 | 100 | 20.0 | 0 | 0 | Засгийн газар<br>ЗДТГ | 2009 | 2009 | СХБ | Сумын нийт иргэд |
| 12 | **Зо2:Зт2:Хө2:Т2:** Үндэсний мичид, зурхайн байртай болох | 50.0 | 43.0 | 100 | 50 | 0 | 0 | 0 | 0 | Иргэд<br>Хандивлагчид | 2007 | 2010 | Эхэлсэн, СХБ | Сумын нийт иргэд |
| 13 | **Зо3:Зт1:Хө1:Т1:** Дунд сургуулийн хичээлийн ба дотуур байрын их засвар, өргөтгөл, тохижилт | 400.0 | 343.6 | 0 | 0 | 70 | 280 | 30 | 120 | Засгийн газар<br>ЗДТГ<br>Хандивлагчид<br>Дунд сургууль | 2008 | 2011 | СХБ | Сумын нийт иргэд<br>Дунд сургуулийн сурагчид |
| 14 | **Зо3:Зт1:Хө1:Т2:** Цэцэрлэгийн өргөтгөл | 30.0 | 25.8 | 0 | 0 | 100 | 30 | 0 | 0 | Засгийн газар<br>ЗДТГ<br>Хандивлагчид | 2008 | 2008 | СХБ | Сумын нийт иргэд<br>Өсвөр насны хүүхдүүд |

| Төслийн дугаар | Төслийн код, нэр | Өртөг | | Санхүүжилт | | | | | | Түншүүд | Хэрэгжүү-лэлт | | Хэрэгжилтийн байдал | Ашиг хүртэгчид |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Орон нутаг | | Улсын төсөв | | Хандив-лагчид | | | | | | |
| | | сая төг. | '000 $ | % | сая төг. | % | сая төг. | % | сая төг. | | Эхлэх | Дуусах | | |
| 15 | **ЗоЗ:Зт1:Хө2:Т1:** Сумын хүн эмнэлгийн өргөтгөл, тоног төхөөрөмжийн шинэчлэл | 100.0 | 85.9 | 0 | 0 | 50 | 50 | 50 | 50 | Засгийн газар<br>Хандивлагчид<br>ЗДТГ<br>Аймгийн Эрүүл мэндийн газар<br>Сумын хүн эмнэлэг | 2007 | 2009 | Эхэлсэн, СХБ | Сумын нийт иргэд |
| 16 | **ЗоЗ:Зт2:Хө1:Т1:** ЗДТГ-ын дэргэд сургалтын байр гаргаж тохижуулах | 10.0 | 8.6 | 20 | 2 | 50 | 5 | 30 | 3 | ЗДТГ<br>Хандивлагчид<br>Иргэд, байгууллагууд | 2007 | 2008 | Эхэлсэн, СХБ | Сумын төрийн ба хувийн хэвшлийн байгууллагууд<br>Нийт иргэд |
| 17 | **ЗоЗ:Зт2:Хө1:**<br>Т2: Мэргэжүүлэх болон давтан сургах сургалтын эрэлтийн судалгаа явуулах | 1.0 | 0.9 | 100 | 1 | 0 | 0 | 0 | 0 | ЗДТГ<br>Хандивлагчид<br>Мэргэжлийн байгууллагууд | 2008 | 2008 | СХБ | Сумын нийт иргэд<br>Бизнес эрхлэгчид |
| 18 | **ЗоЗ:Зт3:Хө1:Т1:**<br>Цагдаагийн тасагтай болж, үйлчилгээний хүрээг өргөтгөх | 30.0 | 25.8 | 0 | 0 | 100 | 30 | 0 | 0 | ЗДТГ<br>Хандивлагчид/<br>Австралийн засгийн газар<br>Мэргэжлийн байгууллагууд | 2010 | 2011 | СХБ | Сумын нийт иргэд<br>ЗДТГ<br>Цагдаагийн ажилтнууд |
| 19 | **ЗоЗ:Зт3:Хө1:Т2:**<br>Малчдыг хөдөлгөөнт холбооны сүлжээнд хамруулах | 40.0 | 34.4 | 0 | 0 | 0 | 0 | 100 | 40 | Хандивлагчид<br>Хувийн хэвшил | 2008 | 2015 | СХБ | Сумын нийт иргэд |

| Төслийн дугаар | Төслийн код, нэр | Өртөг | | Санхүүжилт | | | | | | Түншүүд | Хэрэгжүүлэлт | | Хэрэгжилтийн байдал | Ашиг хүртэгчид |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Орон нутаг | | Улсын төсөв | | Хандивлагчид | | | Эхлэх | Дуусах | | |
| | | сая төг. | '000 $ | % | сая төг. | % | сая төг. | % | сая төг. | | | | | |
| 20 | **Зо3:Зт3:Хө1:Т3:** Малын хөдөлгөөнийг хянах дохиоллын систем нэвтрүүлэх | 50.0 | 43.0 | 0 | 0 | 0 | 0 | 100 | 50 | Хандивлагчид<br>ЗДТГ<br>Цагдаагийн тасаг | 2009 | 2015 | СХБ | Сумын нийт иргэд |
| 21 | **Зо3:Зт4:Хө1:**<br>Т1: ЗДТГазрыг түшиглүүлэн чийрэгжүүлэх танхим байгуулах | 100.0 | 85.9 | 0 | 0 | 50 | 50 | 50 | 50 | Засгийн газар<br>Хандивлагчид<br>Засаг даргын тамгын газар | 2009 | 2010 | СХБ | Сумын нийт иргэд<br>Лицей дунд сургууль |
| 22 | **Зо3:Зт4:Хө1:Т2:**<br>Нийтийн биеийн тамир, сонирхогчдын спорт хөгжүүлэх, дэмжих сан бий болгох | 5.0 | 4.3 | 100 | 5 | 0 | 0 | 0 | 0 | ЗДТГ<br>Хандивлагчид<br>Хувийн хэвшил | 2008 | 2015 | СХБ | ЗДТГ<br>Сумын нийт иргэд |
| 23 | **Зо4:Зт1:Хө1:Т1:**<br>Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулах | 1.0 | 0.9 | 100 | 1 | 0 | 0 | 0 | 0 | ЗДТГ<br>Хандивлагчид<br>Мэргэжлийн байгууллагууд | 2008 | 2008 | СХБ | ЗДТГ<br>Малчид, тариаланчид |
| 24 | **Зо4:Зт1:Хө1:Т2:** Мал эмнэлэг, үржлийн албыг өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх үндэслэл санал боловсруулах | 30.0 | 25.8 | 20 | 6 | 0 | 0 | 80 | 24 | ЗДТГ<br>Хандивлагчид<br>Увс аймгийн ХХААГ | 2008 | 2010 | СХБ | ЗДТГ<br>Хувийн мал эмнэлгүүд<br>Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид |

Тэмдэглээ: СХБ - Санхүүжилт хийж байгаа

| Төслийн дугаар | Төслийн код, нэр | Өртөг | | Санхүүжилт | | | | | | Түншүүд | Хэрэгжүү-лэлт | | Хэрэгжилтийн байдал | Ашиг хүртэгчид |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Орон нутаг | | Улсын төсөв | | Хандив-лагчид | | | | | | |
| | | сая төг. | '000 $ | % | сая төг. | % | сая төг. | % | сая төг. | | Эхлэх | Дуусах | | |
| 25 | **Зо4:Зт1:Хө1:Т3:** Малын үүлдэр угсааг сайжруулахад зуучлах үйлчилгээ нэвтрүүлэх | 20.0 | 17.2 | 20 | 4 | 0 | 0 | 80 | 16 | Засгийн газар<br>ЗДТГ<br>Хандивлагчид | 2007 | 2012 | Эхэлсэн, СХБ | ЗДТГ<br>Сумын нийт иргэд |
| 26 | **Зо4:Зт2:Хө1:Т1:** Хүнсний захын барилга | 10.0 | 8.6 | 50 | 5 | 0 | 0 | 50 | 5 | Засгийн газар<br>ЗДТГ<br>Хандивлагчид | 2008 | 2009 | СХБ | Хувийн хэвшил<br>Сумын нийт малчид, иргэд |
| 27 | **Зо4:Зт2:Хө1:Т2:** Худалдаа, ахуйн үйлчилгээний нэгдсэн төвийн зориулалттай барилга | 200.0 | 171.8 | 10 | 20 | 0 | 0 | 90 | 180 | Засгийн газар<br>Хувийн хэвшил<br>Хандивлагчид | 2011 | 2013 | СХБ | Сумын нийт иргэд<br>Бизнес эрхлэгчид |
| 28 | **Зо5:Зт1:Хө1:Т1:** Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах | 12.0 | 10.3 | 10 | 1.2 | 40 | 4.8 | 50 | 6 | Хандивлагчид<br>Аймгийн газрын алба | 2008 | 2009 | СХБ | ЗДТГ |
| 29 | **Зо5:Зт1:Хө1:Т2:** Сум, багийн төр, захиргааны байрын засвар, өргөтгөл, тохижилт | 130.0 | 111.7 | 20 | 26 | 50 | 65 | 30 | 39 | Засгийн газар<br>ЗДТГ<br>Хандивлагчид | 2007 | 2010 | Эхэлсэн, СХБ | ЗДТГ<br>Сумын нийт иргэд |
| 30 | **Зо5:Зт1:Хө1:Т3:** Сумын төвийн гудамж, хорооллыг хаягжуулах, зам, замын тэмдгийг сайжруулах | 25.0 | 21.5 | 0 | 0 | 0 | 0 | 100 | 25 | Хандивлагчид | 2008 | 2009 | СХБ | ЗДТГ<br>Сумын төвийн иргэд |

| Төслийн дугаар | Төслийн код, нэр | Өртөг | | Санхүүжилт | | | | | | Түншүүд | Хэрэгжүүлэлт | | Хэрэгжилтийн байдал | Ашиг хүртэгчид |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Орон нутаг | | Улсын төсөв | | Хандивлагчид | | | | | | |
| | | сая төг. | '000 $ | % | сая төг. | % | сая төг. | % | сая төг. | | Эхлэх | Дуусах | | |
| 31 | **Зо5:Зт1:Хө1:Т4:** Төрийн албанд ажиллагсдын орон сууцны хангамжийг сайжруулах (32 айлын орон сууц) | 240.0 | 206.2 | 0 | 0 | 100 | 240 | 0 | 0 | Засгийн газар | 2008 | 2015 | СХБ | ЗДТГ<br>Төрийн албан хаагчид |
| 32 | **Зо5:Зт1:Хө1:Т5:** Нэг цэгийн үйлчилгээ нэвтрүүлэх | 8.0 | 6.9 | 25 | 2 | 0 | 0 | 75 | 6 | ЗДТГ<br>Хандивлагчид<br>Бизнес эрхлэгчид | 2007 | 2008 | СХБ | Нийт иргэд<br>Бизнес эрхлэгчид<br>ЗДТГ |
| 33 | **Зо5:Зт2:Хө1:Т1:** Сумын төвийг дулааны нэгдсэн сүлжээнд хамруулах | 300.0 | 257.7 | 0 | 0 | 100 | 300 | 0 | 0 | Засгийн газар<br>Хандивлагчид | 2010 | 2013 | СХБ | ЗДТГ<br>Албан байгууллага, аж ахуйн нэгжүүд |
| 34 | **Зо5:Зт2:Хө1:Т2:** Сумын төвийн цахилгааны шугам сүлжээний шинэчлэл | 50.0 | 43.0 | 0 | 0 | 100 | 50 | 0 | 0 | Засгийн газар<br>ЗДТГ<br>Хандивлагчид<br>Эрчим хүчний байгууллага | 2009 | 2010 | СХБ | Нийт иргэд<br>Бизнес эрхлэгчид |
| 35 | **Зо3:Зт3:Хө1:Т3:** Сумын төвийн гэрэлтүүлгийг сайжруулах | 30.0 | 25.8 | 0 | 0 | 0 | 0 | 100 | 30 | Засгийн газар<br>ЗДТГ<br>Хандивлагчид<br>Эрчим хүчний байгууллага | 2008 | 2008 | СХБ | ЗДТГ<br>Албан байгууллага, аж ахуйн нэгжүүд<br>Сумын төвийн иргэд |

## 5.6. Төсөл эрэмбэлсэн матриц

| Эрэмбэ | Төслийн матриц дахь дугаар | Төслийн код, нэр | Хатуу (Х), Зөөлөн (З) | Нэн чухал | Чухал | Чухал биш | Дундаж оноо |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 34 | **Зо5:Зт2:Хө1:Т2:** Сумын төвийн цахилгааны шугам сүлжээний шинэчлэл | х | 13 | 2 | 1 | 2.75 |
| 2 | 32 | **Зо5:Зт1:Хө1:Т5:** Нэг цэгийн үйлчилгээ нэвтрүүлэх | з | 11 | 5 | 0 | 2.69 |
| 3 | 3 | **Зо1:Зт1:Хө2:Т1:** Ойн зурвас бүхий нутаг, жимс жимсгэнийн талбайн ойжуулалт, сумын төвийн цэцэрлэгжүүлэлт | х | 8 | 6 | 1 | 2.69 |
| 4 | 7 | **Зо2:Зт1:Хө1:Т1:** Улаангом–Тариалан чиглэлийн 31 км засмал зам тавих | х | 11 | 4 | 1 | 2.63 |
| 5 | 13 | **Зо3:Зт1:Хө2:Т1:** Сумын хүн эмнэлгийн өргөтгөл, тоног төхөөрөмжийн шинэчлэл | х | 10 | 6 | 0 | 2.63 |
| 6 | 14 | **Зо3:Зт1:Хө1:Т2:** Цэцэрлэгийн өргөтгөл | х | 9 | 7 | 0 | 2.56 |
| 7 | 29 | **Зо5:Зт1:Хө1:Т2:** Сум, багийн төр, захиргааны байрын засвар, өргөтгөл, тохижилт | х | 10 | 5 | 1 | 2.56 |
| 8 | 30 | **Зо5:Зт1:Хө1:Т3:** Сумын төвийн гудамж, хорооллыг хаягжуулах, зам, замын тэмдгийг сайжруулах | х | 9 | 6 | 1 | 2.50 |
| 9 | 13 | **Зо3:Зт1:Хө1:Т1:** Дунд сургуулийн хичээлийн ба дотуур байрын их засвар, өргөтгөл, тохижилт | х | 8 | 7 | 1 | 2.44 |
| 10 | 23 | **Зо4:Зт1:Хө1:Т1:** Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулах | з | 8 | 7 | 1 | 2.44 |
| 11 | 25 | **Зо4:Зт1:Хө1:Т3:** Малын үүлдэр угсааг сайжруулахад зуучлах үйлчилгээ нэвтрүүлэх | з | 7 | 9 | 0 | 2.44 |
| 12 | 2 | **Зо1:Зт1:Хө1:Т2:** Сумын төвийн төвлөрсөн хогийн цэгийн талбайг багасгах | х | 7 | 8 | 1 | 2.38 |
| 13 | 24 | **Зо4:Зт1:Хө1:Т2:** Мал эмнэлэг, үржлийн албыг өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх үндэслэл санал боловсруулах | з | 7 | 8 | 1 | 2.38 |
| 14 | 35 | **Зо3:Зт3:Хө1:Т3:** Сумын төвийн гэрэлтүүлгийг сайжруулах | х | 8 | 6 | 2 | 2.38 |
| 15 | 1 | **Зо1:Зт1:Хө1:Т1:** Сумын байгаль орчны байдлын үнэлгээ хийх | з | 6 | 9 | 1 | 2.31 |

| Эрэмбэ | Төслийн матриц дахь дугаар | Төслийн код, нэр | Хатуу (Х), Зөөлөн (З) | Нэн чухал | Чухал | Чухал биш | Дундаж оноо |
|---|---|---|---|---|---|---|---|
| 16 | 5 | **Зо1:Зт3:Хө2:Т1:** Галдан бошигтын сувгийг сэргээж, толгойн хэсэгт үерийн хамгаалалт хийх | х | 3 | 12 | 1 | 2.31 |
| 17 | 6 | **Зо1:Зт3:Хө2:Т2:** Хавар-намрын бэлчээрт худаг шинээр гаргах | х | 7 | 7 | 2 | 2.31 |
| 18 | 19 | **Зо3:Зт3:Хө1:Т2:** Малчдыг хөдөлгөөнт холбооны сүлжээнд хамруулах | х | 4 | 12 | 0 | 2.25 |
| 19 | 27 | **Зо4:Зт2:Хө1:Т2:** Худалдаа, ахуйн үйлчилгээний нэгдсэн төвийн зориулалттай барилга | х | 6 | 8 | 2 | 2.25 |
| 20 | 28 | **Зо5:Зт1:Хө1:Т1:** Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах | з | 6 | 8 | 1 | 2.19 |
| 21 | 33 | **Зо5:Зт2:Хө1:Т1:** Сумын төвийг дулааны нэгдсэн сүлжээнд хамруулах | х | 4 | 11 | 1 | 2.19 |
| 22 | 16 | **Зо3:Зт2:Хө1:Т1:** ЗДТГ-ын дэргэд сургалтын байр гаргаж тохижуулах | х | 5 | 10 | 0 | 2.19 |
| 23 | 31 | **Зо5:Зт1:Хө1:Т4:** Төрийн албанд ажиллагсдын орон сууцны хангамжийг сайжруулах (32 айлын орон сууц) | х | 7 | 5 | 4 | 2.19 |
| 24 | 4 | **Зо1:Зт3:Хө1:Т1:** Бэлчээр, бэлчээр дэх бусад нөөцийн ашиглалт, зохицуулалтыг сайжруулах урт хугацааны төлөвлөгөө, журам боловсруулж хэрэгжүүлэх | з | 11 | 5 | 0 | 2.13 |
| 25 | 8 | **Зо2:Зт1:Хө1:Т2:** Аялал жуулчлалын хөтөлбөр, танилцуулга, мэдээллийн гарын авлага хэвлүүлэх | з | 3 | 12 | 0 | 2.06 |
| 26 | 17 | **Зо3:Зт2:Хө1:Т2:** Мэргэжүүлэх болон давтан сургах сургалтын эрэлтийн судалгаа явуулах | з | 1 | 15 | 0 | 2.06 |
| 27 | 26 | **Зо4:Зт2:Хө1:Т1:** Хүнсний захын барилга | х | 6 | 6 | 3 | 2.06 |
| 28 | 11 | **Зо2:Зт2:Хө1:Т3:** Соёлын төвийн засвар, тохижилт | х | 1 | 15 | 0 | 2.06 |
| 29 | 18 | **Зо3:Зт3:Хө1:Т1:** Цагдаагийн тасагтай болж, үйлчилгээний хүрээг өргөтгөх | з | 5 | 7 | 3 | 2.00 |
| 30 | 20 | **Зо3:Зт3:Хө1:Т3:** Малын хөдөлгөөнийг хянах дохиоллын систем нэвтрүүлэх | з | 2 | 12 | 2 | 2.00 |
| 31 | 10 | **Зо2:Зт2:Хө1:Т2:** Үндэсний хөгжмийн зэмсгээр хангагдсан язгуур урлагийн хамтлаг ЗДТГ-ын дэргэд байгуулах | з | 0 | 14 | 2 | 1.88 |
| 32 | 9 | **Зо2:Зт2:Хө1:Т1:** Үндэсний ёс заншил, язгуур урлагийн сургалтын хөтөлбөр, гарын авлага, үзүүлэх материал бэлтгэх | з | 1 | 11 | 4 | 1.81 |

| Эрэмбэ | Төслийн матриц дахь дугаар | Төслийн код, нэр | Хатуу (X), Зөөлөн (З) | Нэн чухал | Чухал | Чухал биш | Дундаж оноо |
|---|---|---|---|---|---|---|---|
| 33 | 22 | **Зо3:Зт4:Хө1:Т2:** Нийтийн биеийн тамир, сонирхогчдын спорт хөгжүүлэх, дэмжих сан бий болгох | з | 2 | 9 | 5 | 1.81 |
| 34 | 12 | **Зо2:Зт2:Хө2:Т2:** Үндэсний мичид, зурхайн байртай болох | x | 1 | 9 | 6 | 1.69 |
| 35 | 21 | **Зо3:Зт4:Хө1:Т1:** ЗДТГазрыг түшиглүүлэн чийрэгжүүлэх танхим байгуулах | x | 1 | 9 | 4 | 1.56 |

## Төсөл эрэмбэлсэн арга зүй

Сумын ЭЗХ-ийн стратегид тусгагдсан төслүүдийг үнэхээр чухал шаардлагатай эсэх гэсэн шалгуураар орон нутгийн оролцогчдын саналд тулгуурлан эрэмблэсэн болно.

Төслийг эрэмбэлэх ажиллагааны үе шатууд:

Үе шат 1: Төслүүдийг эдийн засгийн агуулгаар нь хатуу (х), зөөлөн (з) гэж ангилах

Үе шат 2: Төсөл бүрийн чухал шаардлагатай эсэхийг оролцогчдоор үнэлүүлэх

Үе шат 3: Оролцогчдын онооны дүнг нэгтгэж, төсөл бүр дээр дундаж оноо тодорхойлох

Үе шат 4: Хамгийн олон оноо авсан төслийг эхэнд нь тавьж уруудуулах маягаар эрэмбэлэх

Үе шат 5: Шинэчлэн тогтоосон эрэмбийн дагуу төслийн эрэмбийн матриц хийх

## 5.7. Бизнесийг дэмжих стратегийн чиглэлүүд

| Үндсэн чиглэл | Дэмжих үйл ажиллагаа | Товч тодорхойлолт | Холбоо барих байгууллага, утас |
|---|---|---|---|
| Шинээр нээх үйлчилгээ | 1. Жуулчны бааз байгуулж ажиллуулах | Байгалийн үзэсгэлэнт газар, үндэсний язгуур урлаг, түүх соёлын дурсгалт газарт түшиглэн сумын төвийн ойр гадаадын жуулчид, дотоодын амрагч, жуулчдад зориулсан байнгын ажиллагаатай бааз байгуулна. | ЗДТГ, утас: 50456301, 50458862 |
| Мал аж ахуйн шинэ салбаруудыг үүсгэн хөгжүүлэх чиглэл | 2. Сүүний үнээний ферм байгуулах | Аймаг сумын төвийн иргэдийн хэрэгцээг хангах зорилгоор өндөр ашиг шимтэй тус бүр 5–10 үнээтэй 4 ферм байгуулна. | ЗДТГ, ХХАА–н түшмэл<br>Мал эмнэлэг үржлийн алба утас: 50458862 |
| | 3. Гахайн аж ахуй байгуулах | Аймгийн төвийн махны хэрэгцээнд зориулсан гахайн аж ахуйг Тээл, Хотгорын чиглэлд байгуулна. | ЗДТГ, ХХАА–н түшмэл<br>Мал эмнэлэг үржлийн алба утас: 50458862 |
| | 4. Тахианы аж ахуй ахуй байгуулах | Аймаг, сумын төвийн өндөг, махны хэрэгцээнд зориулсан тахианы жижиг аж ахуйг Тээл, Хотгорын чиглэлд байгуулна. | ЗДТГ, ХХАА–н түшмэл<br>Мал эмнэлэг үржлийн алба утас: 50458862 |
| | 5. Царгасны үр үйлдвэрлэл | Сумын дотоод, тариалалтыг нэмэгдүүлэх, гадаад зах зээлд нийлүүлэх чиглэлээр Тээлийн боом, Хар толгойд шинэ тариалангийн талбай, аж ахуй бий болгоно. | ЗДТГ, ХХАА–н түшмэл<br>утас: 50458862<br>Алтандуулга ХК<br>Туяа–Увс хоршоо |
| Жимс, жимсгэнийн аж ахуй хөгжүүлэх чиглэл | 6. Чацарганы талбай байгуулах | Гадаад дотоодын зах зээлд чацаргана нийлүүлэх аж ахуйг Сам дамчаад 3 га талбайтайгаар байгуулна. | ЗДТГ, утас: 50456301, 50458862 |
| | 7. Жимс, жимсгэнийн талбай байгуулах | Гадаад дотоодын зах зээлд зориулан чацаргана, жимс жимсгэнэ үйлдвэрлэх аж ахуйг Тээлийн шугуй, Сам дамчаад 5 га талбайтайгаар байгуулна | ЗДТГ, утас: 50456301, 50458862<br>ХХАА–н түшмэл<br>Иргэд, аж ахуйн нэгжүүд |

| Үндсэн чиглэл | Дэмжих үйл ажиллагаа | Товч тодорхойлолт | Холбоо барих байгууллага, утас |
|---|---|---|---|
| Үр тариа, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэл | 8. Төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх | Иргэд, аж ахуйн нэгжүүдийн төмс, хүнсний тариалалтыг нэмэгдүүлэх, чанартай үрээр хангах, сургалт үзүүлэх сургууль явуулах, туршлага судлуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ. | ЗДТГ, утас: 50456301, 50458862<br>ХХАА–н түшмэл<br>Иргэд, аж ахуйн нэгжүүд |
| | 9. Усалгаатай газар тариалан | Иргэд, аж ахуйн нэгжүүдийн хадлан, тарианы газарт усны сувгийг хүргэх, тэднийг гар болон механик усалгааны техник төхөөрөмжөөр хангах, усалгаатай газар тариалан эрхлэх арга зүйд сургах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | ЗДТГ, утас: 50456301, 50458862<br>ХХАА–н түшмэл<br>Иргэд, аж ахуйн нэгжүүд |
| | 10. Газар тариалангийн техникийн шинэчлэл | Газар тариалан эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгжүүдийг нутаг орны нөхцөлд зохицсон бага оврын бүтээмж өндөртэй техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах, хуучин техникүүдийг шинэчлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | ЗДТГ, утас: 50456301, 50458862<br>ХХАА–н түшмэл<br>Иргэд, аж ахуйн нэгжүүд |
| | 11. Нарийн ногооны хүлэмж | Аймаг, сумын төвийг шинэ ногоогоор тасралтгүй хангах зорилгоор хүлэмж байгуулах, ажиллагчдыг сургах, шаардагдах, үр, бордоогоор хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | ЗДТГ, утас: 50456301, 50458862<br>ХХАА–н түшмэл<br>Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага |
| | 12. Халтар арвай тариалж, арвайн үр үйлдвэрлэх | Аж ахуйн нэгж, иргэдийн арвайн тариалалтыг нэмэгдүүлэх, гадаад дотоод зах зээлд зориулж арвайн үр үйлдвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | ЗДТГ ХХАА–н түшмэл<br>утас: 50458862<br>Алтандуулга ХК<br>Холбогдох иргэд |
| | 13. Төмс, хүнсний ногооны зоорь байгуулах | Иргэд аж ахуйн нэгжүүдийн тариалсан төмс хүнсний ногоог урт хугацаанд хадгалж борлуулах боломж олгох нэгдсэн агуулах байгуулж үйлчлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | ЗДТГ, утас: 50456301, 50458862<br>Холбогдох аж ахуйн нэгж |
| Орон нутгийн байгалийн түүхий эд ашиглах чиглэл | 14. Тоосго, блокны үйлдвэр байгуулах | Орон нутагт олдоцтой барилгын материалд түшиглэн сум, аймгийн хэрэгцээг хангах тоосго, хайрга, блокны үйлдвэрлэл шинээр нээж ажиллуулах үйл ажиллагаа хамрагдана. 2–3 нэгж байх боломжтой. | ЗДТГ, утас: 50456301, 50458862 |

| Үндсэн чиглэл | Дэмжих үйл ажиллагаа | Товч тодорхойлолт | Холбоо барих байгууллага, утас |
|---|---|---|---|
| Дотоодын хэрэгцээг хангах үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл | 15. Зөөлөн хатуу оёдлын цех | Сумын иргэдийн дотоод хэрэгцээг хангах, ажлын байр бий болгох зорилготой зөөлөн, хатуу оёдлын цех байгуулах, уг үйл ажиллагаанд сонирхсон иргэдийг сургах, мэргэшүүлэх арга хэмжээ зохион байгуулна. 2–3 нэгж байх боломжтой. | ЗДТГ, утас: 50456301, 50458862<br>Нийгмийн халамжийн ажилтан |
| | 16. Техникийн засвар үйлчилгээний төв | ХАА–н техник, автомашин, мотоцикль, жижиг үйлдвэрийн техник төхөөрөмж, гэр ахуйн цахилгаан тоног төхөөрөмжийг орон нутагтаа засварлах байртай болох, тоног төхөөрөмжөөр хангах, ажлын байр бий болгох, сургалт зохион байгуулах | ЗДТГ, утас: 50456301, 50458862<br>Аж ахуйн нэгжүүд |
| | 17. Гэрийн модон эдлэлийн цех | Гэрийн мод, модон эдлэлийн сумын дотоод хэрэгцээг хангах, засварлах боломж бүрдүүлэх, шинэ ажлын байр бий болгох, багаж хэрэгслийн туслалцаа үзүүлэх, сонирхсон иргэдийг сургах арга хэмжээ хэрэгжинэ. | ЗДТГ, утас: 50456301, 50458862<br>Аж ахуйн нэгжүүд |
| | 18. Ундаа, цэвэр усны үйлдвэр | Ундаа, цэвэр усны сумын дотоод хэрэгцээг хангах зорилгоор тоног төхөөрөмжөөр хангах, сонирхсон иргэдийг сургах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | ЗДТГ, утас: 50456301, 50458862<br>Аж ахуйн нэгжүүд |
| | 19. Талх нарийн боовны цех | Талх нарийн боовны сумын дотоод хэрэгцээг хангах, шинэ ажлын байр бий болгох, холбогдох багаж, техник тоног төхөөрөмжөөр хангах, сонирхсон иргэдийг сургах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | ЗДТГ, утас: 50456301, 50458862<br>Аж ахуйн нэгжүүд |

| Үндсэн чиглэл | Дэмжих үйл ажиллагаа | Товч тодорхойлолт | Холбоо барих байгууллага, утас |
|---|---|---|---|
| Сумын дотор үйлдвэрлэсэн түүхий эдийн боловсруулалтын түвшинг дээшлүүлэх чиглэл | 20. Малын тэжээлийн үйлдвэр | Иргэд, аж ахуйн нэгжүүдийн хадлан, тариалангийн бүтээгдэхүүнд түшиглэн малын тэжээл бэлтгэх үйлдвэр байгуулах арга хэмжээ хэрэгжинэ. | ЗДТГ, утас: 50456301, 50458862<br>Алтандуулга ХК |
| | 21. Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ боловсруулах, савлах цех | Иргэд, аж ахуйн нэгжүүдийн хүнсний ногоо, жимс, жимсгэнийг гэрээний үндсэн дээр боловсруулах, савлах үйлдвэр байгуулах арга хэмжээ хэрэгжинэ. Уг арга хэмжээ нь хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгоход чухал хүчин зүйл болно. | ЗДТГ, утас: 50456301, 50458862<br>Аж ахуйн нэгж, иргэд |
| | 22. Бог будааны үйлдвэрийн техникийн шинэчлэл хийх | Уг арга хэмжээний хүрээнд одоо байгаа бог будааны үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, байрыг засварлах, ажиллагсдыг сургаж дадлагажуулах ажил хийгдэнэ. | ЗДТГ, утас: 50456301, 50458862<br>Туяа–Увс хоршоо |
| | 23. Арвайн гурилын үйлдвэрийн техникийн шинэчлэл, өргөтгөл | Арвайн гурилын үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх, байрыг засварлах, ажиллагсдыг сургаж дадлагажуулах ажил хийгдэнэ. | ЗДТГ, утас: 50456301, 50458862<br>Алтантүрүү нөхөрлөл |
| | 24. Гурилын үйлдвэрийн өргөтгөл | Уг арга хэмжээний хүрээнд одоо ажиллаж байгаа гурилын үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, ажиллагсдыг шинэ техник дээр сургаж дадлагажуулах ажил хийгдэнэ. | ЗДТГ, утас: 50456301, 50458862<br>Аж ахуйн нэгж, иргэд |
| | 25. Сүү боловсруулах цех | Сүү, цагаан идээний аймаг, сумын хэрэгцээг хангах, шинэ ажлын байр бий болгох, холбогдох багаж, техник тоног төхөөрөмжөөр хангах, сонирхсон иргэдийг сургах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | ЗДТГ, утас: 50456301, 50458862<br>Таван засал хоршоо<br>Аж ахуйн нэгж, иргэд |
| | 26. Өлөнгийн анхан шатны боловсруулалт | Малчдын түүхий эдийг боловсруулж гадаад зах зээлд гаргах, ажлын байр бий болгох зорилготой. Үйлдвэрийн техник, багаж хэрэгслээр хангах, ажиллагсдыг сургах, мэргэшүүлэх арга хэмжээ хэрэгжүүлнэ. | ЗДТГ, утас: 50456301, 50458862<br>Туяа–Увс хоршоо, иргэд |
| | 27. Ноос, эсгий, эсгий гутлын үйлдвэр | Малчдын түүхий эдийг боловсруулж дотоод гадаад зах зээлд гаргах, ажлын байр бий болгох зорилготой. Үйлдвэрийн техник, багаж хэрэгслээр хангах, ажиллагсдыг сургах, мэргэшүүлэх арга хэмжээ хэрэгжүүлнэ. | ЗДТГ, утас: 50456301, 50458862<br>З.Тэгшжаргал, иргэд |

## 5.8. Төслийн товч танилцуулга

| №1 | **Төсөл:** Зо1:Зт1:Хө1:Т1: Сумын байгаль орчны байдлын үнэлгээ хийх | **Хөтөлбөр:** Зо1:Зт1:Хө1: Байгаль, амьдрах орчны хамгаалалт |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Манай гариг дээр, түүний дотор Их нууруудын хотгорын бүс нутагт явагдаж буй дулааралт, хуурайшилт зэрэг глобаль ба бүс нутгийн чанартай хүчин зүйлсийн сөрөг нөлөө улам хүчтэй болж байна. Түүнээс гадна уул уурхай, газар тариалан, малын тоо толгойн өсөлт, бэлчээрийн талхлагдалт, ачаалал нэмэгдэх зэрэг тус сумын эдийн засаг-нийгмийн хөгжлийн өвөрмөц зарим үйл явц байгаль орчинд тааламжгүй нөлөөлж буй шинж төрх ажиглагдах боллоо. Ийнхүү одоогоор мэдэгдэж буй өөрчлөлт болон цаашид гарч болох хувирлын байдлыг үнэлэх, улмаар ойрын жилүүдэд болон дунд хугацаанд орчны өөрчлөлт ба антрогени/техникийн нөлөөлөлд өртөж болзошгүй байгаль-экологийн бүрдэл, нөөцийн үнэлгээ хийх шаардлагатай. Энэ үндсэн дээр сум өөрийн эрх хэмжээний хүрээнд авах арга хэмжээ, үйл ажиллагаа, тэдгээрийг хэрэгжүүлэх арга зам, механизмыг тусгасан зөвлөмж гаргана.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Тус сумын нутаг дэвсгэр дээрхи болон орчмын байгаль-экологийн үнэлгээ хийгдэнэ
- Байгаль орчноо хамгаалах, зохистой ашиглахад иргэд, аж ахуйн ба олон нийтийн байгууллага, төр-захиргаанаас хэрэгжүүлэх үйл ажиллагаа, механизм тодорхойлогдоно
- Байгаль-орчны өөрчлөлтийг сумын хэмжээнд хянах, тодорхойлох энгийн шалгуур үзүүлэлтийн систем боловсрогдоно
- Байгаль-орчны өөрчлөлтөд төр, олон нийтийн байгууллага, иргэд хяналт тавих боломжтой болно.

**Зорилтот бүлэг:**
- Сумын нийт иргэд
- Уул уурхайн компаниуд

**Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**
- Засаг даргын тамгын газар
- Уул уурхайн компаниуд
- Мэргэжлийн байгууллагууд

**Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**
- Засгийн газар
- Уул уурхайн компаниуд
- Бизнес эрхлэгчид
- Мэргэжлийн байгууллагууд

**Зэхэц, урьдал нөхцлүүд:**
- Хамтран ажиллах ба дэмжлэг үзүүлэх байгууллагуудтай зөвшилцсөн
- Шаардлагатай мэдээлэл авах байгууллагуудыг тогтоосон байх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:**
- Улсын төсвийн санхүүжилт олдохгүй байх

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг: 5.0**

- Унаа – 0.4
- Зөвлөх ажиллуулсны хөлс – 0.2
- Хээрийн судалгааны зардал – 0.4
- Үнэлгээ, нөөцийн зураглал хийх – 4.0

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2009 онд эхэлж нэг жил

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа тогтвортой үргэлжилнэ.

| №2 | **Төсөл:** Зо1:Зт1:Хө1:Т1: Сумын төвийн төвлөрсөн хогийн цэгийн талбайг багасгах | **Хөтөлбөр:** Зо1:Зт1:Хө1: Байгаль, амьдрах орчны хамгаалалт |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сумын төвийн аж ахуйн байгууллага, айл өрхийн тоо нэмэгдсэн болон шинээр барилга байгууламж барих, засварлах ажил өмнөх жилүүдийг бодвол харьцангуй ихэссэний улмаас ахуйн хог хаягдлыг зохион байгуулалттай цуглуулах, тээвэрлэх, зориулалтын цэгт хаях асуудлыг яаралтай цэгцлэх шаардлагатай байна. Сумын төвийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн эзлэх талбай улам тэлэх болсон учраас юуны өмнө хог хаягдлыг бөөгнөрүүлэх, овоолох зэргээр хумих, талбайн гадуур нь хашлага хийх, хөрс, усанд хор нөлөө багатай хэсгийг нь хөрсөнд далдалж булах, хогийн сав хийж байрлуулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд энэ төсөл чиглэгдэнэ.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Хог хаягдлын задгай цэгийг хамгаалалттай болгох
- Хогийн цэгийг ийнхүү цэгцэлснээр цаашид хог задгай хаях, хөрс, ус, орчныг бохирдуулах явдал буурах
- Сумын төвийн агаарын бохирдол, тоосжилт багасах

**Зорилтот бүлэг:**
- Сумын нийт иргэд

**Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**
- Засаг даргын тамгын газар
- Бизнес эрхлэгчид

**Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**
- Засаг даргын тамгын газар
- Бизнес эрхлэгчид ба байгууллагууд
- Иргэд
- Хандивлагчид

**Зэхэц, урьдал нөхцлүүд:**
- Хогийн цэгийн талбай багасгах төсөлд оролцох сумын байгууллага, аж ахуйн нэгжийг тогтоох
- Том оврын өндөр хүчин чадалтай техник хөлсөөр авч ажиллуулах асуудлыг урьдчилан тохиролцох

**Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг: 50.0**

- Хог далдалж булах нүх байгуулах –15.0
- Хашаа хамгаалалт барих – 2.0
- Хогийн сав хийх, байрлуулах – 0.3
- Ажлын хөлс – 5.0
- Экскаватор хөлсөлсөн зардалд – 23.0
- Сурталчилгаа, мэдээллийн зардал – 0.2
- Хөрс боловсруулах, суулгац тариалах – 4.5

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2008 оноос нэг жил

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа тогтвортой үргэлжилнэ.

| №3 | **Төсөл:** Зо1:Зт1:Хө2: Ойн зурвас бүхий нутаг, жимс жимсгэнийн талбайн ойжуулалт, сумын төвийн цэцэрлэгжүүлэлт | **Хөтөлбөр:** Зо1:Зт1:Хө2: Ойн нөхөн сэргээлт, ойжуулалт |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Энэ төсөл нь ойн нөөцийг нөхөн сэргээх, сумын төв, түүний орчмыг цэцэрлэгжүүлэх гэсэн 2 үндсэн хэсгээс бүрдэнэ. Сумын ойн нөөц багасч байгаатай холбоотойгоор ойн нөхөн сэргээлтийг сумын иргэдийн оролцоотойгоор мэргэжлийн байгууллага, хандивлагчидтай хамтран хийж гүйцэтгэнэ. Сумын төвийг цэцэрлэгжүүлэх, зүлэгжүүлэх ажлын хүрээнд сумын төвийн гол гудамжинд мод тарих, айл өрх албан байгууллагын орчныг цэцэрлэгжүүлэх, чөлөөт цагийн цэцэрлэгийг өргөжүүлэн тохижуулж иргэдийн амрах газар бий болгох юм. Сумын төвийн тоосжилт, агаарын бохирдлыг бууруулж орчны ариун цэврийг сайжруулахад чухал арга хэмжээ болно. Хандивлагчид, хөрөнгө оруулагчид, дэмжигчдийн бодлого, зорилго, сонирхол, хөрөнгийн эх үүсвэрийн олдоцоос хамааруулан энэхүү төслийг хэсэгчилсэн байдлаар хэрэгжүүлэх боломжтой.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Хүчтэй ашиглагдсан ойн бүс, талбайд ойжуулах ажил эхлэнэ
- Ой бүхий талбай, нөөц нэмэгдэнэ.
- Сумын төв, түүний орчмын ногоон бүс, цэцэрлэгжилт сайжирна
- Мод бутыг цэцэрлэгжүүлэх ба орлого нэмэгдүүлэх чиглэлээр тарих хэмжээ өргөжинө

**Зорилтот бүлэг:**
- Сумын нийт иргэд
- Аж ахуйн байгууллагууд

**Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**
- Засаг даргын тамгын газар
- Бизнес эрхлэгчид
- Ойн болон байгаль хамгааллын мэргэжлийн байгууллага

**Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**
- Засаг даргын тамгын газар
- Бизнес эрхлэгчид аж ахуйн нэгжүүд
- Мэргэжлийн байгууллагууд
- Хандивлагчид

**Зэхэц, урьдал нөхцлүүд:**
- Нөхөн сэргээлт шаардлагатай газруудыг урьдчилан тогтоох
- Орчны иргэд, холбогдох хүмүүсийг мод суулгах ажилд сургах, дадлагажуулах
- Айл өрх, аж ахуйн байгууллагууд бэлтгэлээ хангах

**Эрсдэлтэй хүчин зүйлс:**
- Ойжуулах ба цэцэрлэгжүүлэх чиглэлээр тарьсан мод, бут, жимсний суулгацыг мал сүйтгэх
- Ган гандалт тохиолдох

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг: 30.0**

- Хашаа хамгаалалт барих – 8.5
- Ажлын хөлс – 6.0
- Хөрс боловсруулах – 6.5
- Усалгааны шуудуу татах – 4.0
- Салаа суваг татах – 2.0
- Суулгац худалдан авах, тарих – 3.0

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2008–2015 онд

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа тогтвортой үргэлжилнэ.

| №4 | **Төсөл:** Зо1:Зт3:Хө1:Т1: Бэлчээр, бэлчээр дэх бусад нөөцийн ашиглалт, зохицуулалтыг сайжруулах урт хугацааны төлөвлөгөө, журам боловсруулж хэрэгжүүлэх | **Хөтөлбөр:** Зо1:Зт3:Хө1: Бэлчээрийн хамтын менежмент нэвтрүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Худаг, ус хүрэлцээгүйгээс болон бэлчээрийг улирлын ба нүүдэллэн ашиглах хуваарийг мөрдөхгүй ашиглаж байгаагаас даац нь хэтрэх, улмаар талхлагдаж муудах, малчдын хооронд маргаан үүсэх зэрэг сөрөг үзэгдэл нэмэгдэх хандлагатай байна. Энэ нь бэлчээрийг даац, бүтээмжид нь зохицуулан улирлын хуваарьтайгаар тодорхой хугацаанд ээлжлэн ашиглахад малчдыг сургах, үүнийг хэрэгжүүлэх эрхзүйн үндэс бүхий зохицуулалт, төлөвлөлтийг боловсруулж бүлгийн хэмжээнд мөрдүүлэх арга хэмжээг нэн даруй авахыг шаардаж байгаа юм. Санал болгож буй төслийг хэрэгжүүлснээр бэлчээрийг бүлгээр буюу хамтын менежментээр ашиглах, хамгаалах асуудлыг шийдвэрлэх боломж бүрдэнэ

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Бэлчээрийг даац, бүтээмжид нь зохицуулан улирлын хуваарьтайгаар ашиглахад малчдыг сургах<br>• Энэ арга хэмжээг хэрэгжүүлэх эрхзүйн үндэс бүхий зохицуулалт, арга замыг шинэчлэн боловсруулах<br>• Бэлчээрийг бүлгээр буюу хамтын менежментээр ашиглах зохицуулалт нэвтэрч эхлэх<br>• Бэлчээрийн маргаан багасах | • Засаг даргын тамгын газар<br>• Сумын нийт иргэд<br>• Малчид |
| **Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**<br>• Засаг даргын тамгын газар<br>• Нийт малчид<br>• Мал бүхий иргэд, аж ахуйн нэгжүүд | **Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**<br>• Засаг даргын тамгын газар<br>• Мал бүхий иргэд, аж ахуйн нэгжүүд<br>• "Тогтвортой амьжиргаа" төсөл |
| **Зэхэц, урьдал нөхцлүүд:**<br>• Малчдын бүлгүүдийн бэлчээрийн заагийг зураглалд буулгасан байх<br>• Малчдын бүлэгт хамрагдах малчин өрх тодорхой байх<br>• Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө тогтмол хийгддэг байх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:**<br>• Ган зуд болох<br>• Гаднаас мал, малчид бөөнөөр орж ирэх<br>• Усны асуудал |

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** 6.0

- Бэлчээр ашиглалтын түүвэр судалгааны зардал – 0.8
- Бэлчээрийн төлөв байдлын үнэлгээний зөвлөх хөлслөх – 0.6
- Сумын бэлчээрийн шинэчилсэн зургийг хэвлүүлэх – 3.4
- Бэлчээрийг малчдад бүлгээр ашиглуулах арга хэмжээ зохион байгуулах зардал – 0.8
- Сургалт, сурталчилгааны зардал – 0.4

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2008 оноос 2 жил | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа тогтвортой үргэлжилнэ. |
|---|---|

| №5 | **Төсөл:** Зо1:Зт3:Хө2:Т1: Галдан бошигтын сувгийг сэргээж, толгойн хэсэгт үерийн хамгаалалт хийх | **Хөтөлбөр:** Зо1:Зт3:Хө2: Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Тариаланчууд эрт үеэс бэлчээрийн мал аж ахуйгаас гадна өрхийн тариалан эрхлэж ирсэн уламжлалтай. ХАА–н үйлдвэрлэлийн эдгээр өвөрмөц дэд салбарыг тогтвортой хослон эрхлэхэд 17–р зуунд байгуулсан Галдан бошигтын хэмээн алдаршсан гар усалгааны суваг асар их үүрэг гүйцэтгэж ирсэн юм. Цагийн уртад элдэв шороо, чулуу хуримтлагдсан хэсгээр сувгийн гүн багассанаас гадна сүүлийн жилүүдэд ширүүн бороо орж уулын үер олонтой буух болсноос уулын хэц дагаж явсан хэсэг нь усны элэгдэлд орох нь элбэгшлээ. Иргэдийн амьжиргаанд тустайн дээр түүхийн үнэ цэнэ бүхий объект болох энэ сувгийг уг төрх байдлыг нь алдагдуулахгүйгээр сэргээх, үерийн хамгаалалттай болгохын тулд мэргэжлийн байгууллагын оролцоо бүхий төслийг хандивлагчдаас санхүүгийн дэмжлэг авах замаар санаачлан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Алдарт Галдан бошигтийн суваг унаган төрхөөрөө сэргээгдэнэ<br>• Жижиг тариалан эрхлэгчид инженерийн хийцтэй усалгааны системээс хараат байдал арилж, өрхийн тариалан (үр тариа, хадлан, ногоо, жимсний бут) эрхлэгчдийн усалгаа баталгаатай болно<br>• Тариаланд тохиромжтой газрын ашиглалт сайжирна<br>• Түүхийн үнэт өвөө сэргээсэнд ард иргэдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ | • Сумын нийт иргэд<br>• Бизнес эрхлэгчид<br>• Газар тариалангийн аж ахуйн нэгж<br>• Өрхийн тариалан эрхлэгчид |
| **Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**<br>• Засаг даргын тамгын газар<br>• Нийт иргэд | **Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**<br>• Хандивлагчид<br>• Засгийн газар<br>• Бизнес эрхлэгчид |
| **Зэхэц, урьдал нөхцлүүд:** Шаардагдахгүй | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** **50.0**

- Суваг сэргээх зураг хийх – 1.5
- Суваг ухах, цэвэрлэх техник хөлслөх, ажлыг гүйцэтгэх – 20.0
- Толгойн ба тахирласан хэсэг үерийн хамгаалалт, далан барих – 24.0
- Гол бухаас салаа суваг татах, усны хаалт шинээр барих – 4.5

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2009 оноос 3 жил | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа тогтвортой үргэлжилнэ. |
|---|---|

| №6 | **Төсөл:** Зо1:Зт3:Хө2:Т2: Хавар–намрын бэлчээрт худаг шинээр гаргах | **Хөтөлбөр:** Зо1:Зт3:Хө2: Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Худаг, ил усны хүрэлцээ улирлаар өөрчлөгддөг, мөн ундарга муутайгаас болж хүн, мал усаар дутагдах, бэлчээрийн ашиглалт жигд бус байх, орчин нь бохирлогдох, ус ашиглагчдын хооронд маргаан үүсэх зэрэг сөрөг үзэгдэл ихсэх хандлагатай байна. Иймээс тус сумын намаржаа–хаваржааны бүс нутагт нэр бүхий газар 20 орчим худаг шинээр гаргах, засварлаж тохижуулах замаар усан хангамжийг дээшлүүлэх, хамтаар ашиглах зохистой менежмент нэвтрүүлэх шаардлагатай.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Инженерийн ба гар худгийн тоо нэмэгдэж, усан хангамж сайжрах
- Байгалийн усны эх үүсвэрүүдийг төр олон нийтийн хамгаалалтанд авах
- Ус ашиглах хамтын менежмент нэвтэрч маргаан багасах
- Усны тухай хууль орон нутагт хэрэгжих

**Зорилтот бүлэг:**
- Сумын нийт иргэд
- Бизнес эрхлэгчид

**Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**
- Засаг даргын тамгын газар
- Нийт иргэд

**Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**
- Засгийн газар
- Хандивлагчид
- Бизнес эрхлэгчид

**Зэхэц, урьдал нөхцлүүд:**
- Хамгаалалтанд авах байгалийн усны эх үүсвэрүүдийг урьдчилан тогтоосон байх
- Худаг ус цэг шаардлагатай байршлуудыг тогтоосон байх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:**
- Худгийн засвар үйлчилгээ муу хийгдэх
- Мал олноор бөөгнөрч ундаргыг муутгах

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** 50.0

- Уст цэгийн хайгуул хийлгэх – 3.0
- Гүний 5 худаг шинээр гаргах – 21.0
- Эвдэрсэн гүний 5 худаг сэргээн засварлах – 13.0
- Гүн ундаргатай 8 гар худаг шинээр гаргах – 5.2
- Гар худгийг цэвэрлэх, хашлагыг засах, солих – 1.4
- Гүн өрмийн худгийн байр барих – 3.8
- Усны онгоц хийх, байрлуулах – 0.6

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

**Хэрэгжүүлэх хугацаа:** 8 жил, 2007 оноос

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа тогтвортой үргэлжилнэ.

| №7 | **Төсөл:** Зо2:Зт1:Хө1:Т1: Улаангом–Тариалан чиглэлийн 31 км засмал зам тавих | **Хөтөлбөр:** Зо2:Зт1:Хө1: Аялал, жуулчлалын бизнесийг дэмжих |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Улаангом хотыг Тариалан сумын төвтэй холбох зам тавих төслийг (i) аймгийнхаа төвд ойрхон оршдог давуу талаа ашиглан зах зээлд хүчтэй нэвтрэх, бүтээгдэхүүнээ тогтмол нийлүүлэхэд тээврийн асуудлыг хөнгөвчлөх (ii) сумынхаа байгаль, уламжлалт ёс заншил, соёл–түүхийн өвөрмөц байдлыг ашиглан гадаад, дотоодын жуулчдыг хүлээн авахад зам харилцаанаас учирч буй бэрхшээлийг арилгах хоёр гол асуудлыг шийдвэрлэх, дөхөм үзүүлэх шаардлагын улмаас дэвшүүлж байгаа болно.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Сумын иргэдийн бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулах, үйлчилгээнд хүрэх нөхцөл сайжрах<br>• Жуулчид, аялагчдыг хүлээн авах боломж нэмэгдэх<br>• Зам харилцаа сайжирч тээврийн зардал буурах | • Сумын нийт иргэд<br>• Бизнесийн байгууллагууд |
| **Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**<br>• ЗДТГ | **Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**<br>• Засгийн газар<br>• ЗДТГ<br>• Хандивлагчид |
| **Зэхэц, урьдал нөхцлүүд:**<br>• Зам засварын зураг, төсөв гаргах | **Эрсдэлтэй хүчин зүйлс:**<br>• Улсын төсөвт эх үүсвэр тусгагдахгүй |

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг: 3000.0** (Зураг, төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх)

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2009 оноос 3 жил | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төслийн дараа иргэдэд хүрэх үр дүн тогтвортой байна. |
|---|---|

| №8 | **Төсөл:** Зо2:Зт1:Хө2:Т2: Аялал жуулчлалын хөтөлбөр, танилцуулга, мэдээллийн гарын авлага хэвлүүлэх | **Хөтөлбөр:** Зо2:Зт1:Хө1: Аялал, жуулчлалын бизнесийг дэмжих |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Тариалан суманд аялал жуулчлалыг бие даасан салбар болгон хөгжүүлэх боломж одоогоор сайн бүрдээгүй ч жуулчид, зочид, аялагчдыг татах, тэдэнд үзүүлэх, сурталчлах, таниулах зүйл их бий. Увс аймагт ирж буй гадаадын жуулчид, дотоодын аялагчдад уламжлалт соёл, ёс заншил, ардын урлагийн өлгий нутагт болсон сумаа, хүн ардынхаа авъяас чадавхиа сурталчлах, цаашид үндэсний аялал жуулчлалын сүлжээнд орохын тулд аялал жуулчлалын хөтөлбөр, танилцуулга, мэдээллийн гарын авлага хэвлүүлэн гаргаж идэвхтэй сурталчилгаа явуулах шаардлагатай байна. Сумын төр захиргаанаас аялал жуулчлал хөгжүүлэхийг эрмэлзэж буй иргэд, байгууллагынхаа санаачлагыг бүрэн дэмжиж байгаа. Нарийн мэргэжил, ур дүй, сурталчилгааны өвөрмөц арга ажиллагаа шаардах энэ ажлыг төсөл хэлбэрээр хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж буй болно.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Сумын аялал жуулчлалын хөтөлбөр, судалгааны материалтай болно
- Сумаа сурталчлах, аялал жуулчлалыг татах боломж нэмэгдэнэ
- Үндэсний сүлжээний хүрээнд жуулчид, аялагчдыг хүлээн авахад иргэд, байгууллагын оролцоо нэмэгдэнэ

**Зорилтот бүлэг:**
- Сумын төр, захиргааны байгууллагууд
- Сумын нийт иргэд
- Бизнес эрхлэгчид

**Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**
- ЗДТГ
- Аялал жуулчлалын мэргэжлийн байгууллага
- Аж ахуйн нэгж, иргэд

**Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**
- ЗДТГ
- Хандивлагчид
- Бизнес эрхлэгчид
- Мэргэжлийн байгууллагууд

**Зэхэц, урьдал нөхцлүүд:** Шаардлагагүй

**Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** 3.0

- Танилцуулга, хөтөлбөр, мэдээлэл–сурталчилгааны материал бэлтгэх – 1.0
- Боловсруулсан материал хэвлүүлэх – 2.0

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2008 оноос 1 жил

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа тогтвортой үргэлжилнэ.

| №9 | **Төсөл:** Зо2:Зт2:Хө1:Т1: Үндэсний ёс заншил, язгуур урлагийн сургалтын хөтөлбөр, гарын авлага, үзүүлэх материал бэлтгэх | **Хөтөлбөр:** Зо2:Зт2:Хө1: Үндэсний ёс заншил, язгуур урлагийг өвлүүлэх, дэлгэрүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Тариалан сумынхан үндэсний ёс заншил, язгуур урлагийн нэн үнэтэй өвийг удам дамжуулан хадгалж боловч ирсэн залуу үеийнхэндээ уламжлуулан эзэмшүүлэх асуудал олон талын шалтгаанууд, тухайлбал, орчин цагийн соёл, мэдээлэл, урлагийн нөлөө, хүмүүсийн сонирхолд гарч буй зарим өөрчлөлт, материаллаг баазын хомсдол зэргээс үүдэлтэйгээр сулрахад хүрээд байна. Язгуур урлагаа биетээр, урлаг уран сайхны арга хэмжээний хүрээнд сурталчлахаас гадна залуучуудад системтэй зааж эзэмшүүлэх, олон нийтийн мэдээллийн ба хувь хэрэглээний янз бүрийн хэрэгсэлд зориулан баримтжуулах явдал хойшлуулшгүй чухал болж байна.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Язгуур урлаг, ёс заншлыг залуу үед сурталчлах, зааж эзэмшүүлэх арга хэмжээг олон нийтийг хамарсан сургалтыг хэмжээнд явуулах боломж бүрдэнэ<br>• Баримтжуулсан ба үзүүлэх материал байдлаар олон нийтэд хүргэх, сан бүрдүүлж хадгалах нөхцөл бүрдэнэ<br>• Үндэсний ёс заншил, язгуур урлагаа иргэдийн боловсрол, аялал жуулчлал, урлагийн арга хэмжээний өвөрмөц хэрэглүүр болгон ашиглана | • Сумын нийт иргэд |
| **Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**<br>• Засаг даргын тамгын газар<br>• Мэргэжлийн байгууллага<br>• Олон нийтийн ба боловсрол, урлаг соёлын байгууллага | **Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**<br>• Иргэд<br>• Хандивлагчид<br>• Бизнес эрхлэгчид<br>• Мэргэжлийн байгууллагууд |
| **Зэхэц, урьдал нөхцлүүд:** Шаардлагагүй | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** 10.0

- Сургалтын хөтөлбөр боловсруулах – 0.3
- Гарын авлага, үзүүлэх материал бэлтгэх – 1.4
- Гарын авлага, үзүүлэх материал хэвлүүлэх – 4.2
- Сумын аялал жуулчлалын ВЕБ сайт хийлгэх – 2.2
- Сургалт зохион байгуулах – 2.0

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 8 жил 2007–2015 онд | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа тогтвортой үргэлжилнэ. |
|---|---|

| №10 | **Төсөл:** Зо2:Зт2:Хө1:Т2: Үндэсний хөгжмийн зэмсгээр хангагдсан язгуур урлагийн хамтлаг ЗДТГ-ын дэргэд байгуулах | **Хөтөлбөр:** Зо2:Зт2:Хө1: Үндэсний ёс заншил, язгуур урлагийг өвлүүлэх, дэлгэрүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Хотон зоны уламжлалт түүх-соёлын ба урлагийн өвөрмөц үйлдлийг нийтлэг хэрэглэгддэг арга ажиллагаа, зэмсгээр бүрэн харуулах ямар ч боломжгүй. Сумынхаа уран гартан, чадварлаг иргэдийг оролцуулан сайн санаат хүмүүс, байгууллага, хандивлагчдын санхүүгийн дэмжлэгтэйгээр цоор, бий хуур, босоо лимбэ гэх мэт хаана ч хэрэглэгддэггүй хөгжмийн зэмсэг хийх, язгуур урлагийн хамтлаг байгуулах төслийг ЗДТГ-ын ивээл дор хэрэгжүүлэх шаардлагатай.

| | |
|---|---|
| **Хүлээгдэж буй үр дүн:**<br>• Үндэсний хөгжмийн зэмсгийг сумандаа хийдэг болно.<br>• Язгуур урлагийн хамтлаг ЗДТГ-ын дэргэд байгуулж үндэсний ёс заншил, язгуур урлагаа өвлүүлэх, дэлгэрүүлэх арга хэмжээг системтэй явуулна<br>• Олон нийтэд үзүүлэх урлаг соёлын үйлчилгээ нэмэгдэнэ | **Зорилтот бүлэг:**<br>• Сумын нийт иргэд<br>• Ардын авъяастнууд |
| **Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**<br>• Засаг даргын тамгын газар<br>• Мэргэжлийн байгууллага<br>• Ардын авъяастнууд | **Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**<br>• ЗДТГ<br>• Хандивлагчид<br>• Мэргэжлийн байгууллагууд |
| **Зэхэц, урьдал нөхцлүүд:**<br>• Ардын авъяастнуудыг тодруулах<br>• Хөгжмийн зэмсэг хийх уран гартнуудыг олох<br>• Хөгжмийн зэмсэг хийх материал, хийцийн судалгаа | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** 10.0

- Язгуур урлагийн зэмсэг хийх – 2.6
- Язгуур урлагийн сургалт явуулах – 0.4
- Язгуур урлагийн хамтлагийн хувцас хэрэглэл авах, хийлгэх – 3.5
- Язгуур урлагийн хамтлагийн сургуулилалт – 0.6
- Язгуур урлагийн хамтлагийн үзүүлбэрийн хөтөлбөр, танилцуулга бэлтгэх, хэвлүүлэх – 0.6
- Клип хийлгэх, DVD, CD гаргах – 2.3

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2008 оноос 3 жил | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа хамтлаг тогтвортой ажиллана. |
|---|---|

| №11 | **Төсөл:** Зо2:Зт2:Хө1:Т3: Соёлын төвийн засвар, тохижилт | **Хөтөлбөр:** Зо2:Зт2:Хө1: Үндэсний ёс заншил, язгуур урлагийг өвлүүлэх, дэлгэрүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Соёл, урлагийн үйлчилгээ, сургалт явуулах гол байр болох соёлын төвийн барилга, түүний дотоод эд хогшил, тоног төхөөрөмж хуучирч иргэд, жуулчдад үйлчилгээ явуулах шаардлагыг хангаж чадахгүй хүрээд байна. Төслөөр хэрэгжүүлэх арга хэмжээнд төвийн гол заалны тааз, хананд засвар хийх, шалыг солих, орон нутаг судлах музейн өрөөг засварлах, тайзны засал гэрэлтүүлгийг өөрчлөх, дууны техникийг шинэчлэх, музейн үзмэрийн тавиур, гол заалны сандал ширээг шинэчлэх зэрэг үйл ажиллагаа хамрагдаж байна. Эдгээр ажлыг хэсэгчлэн хийх боломжтой.

| | |
|---|---|
| **Хүлээгдэж буй үр дүн:**<br>• Соёл урлагийн арга хэмжээ сумандаа явуулах боломж сайжирна<br>• Язгуур урлагийн сургалтыг жилийн турш зохион байгуулах боломжтой болно.<br>• Олон нийтэд үзүүлэх урлаг соёлын үйлчилгээ нэмэгдэнэ | **Зорилтот бүлэг:**<br>• Сумын нийт иргэд |
| **Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**<br>• Засгийн газар<br>• Засаг даргын тамгын газар | **Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**<br>• Засгийн газар<br>• ЗДТГ<br>• Хандивлагчид |
| **Зэхэц, урьдал нөхцлүүд:**<br>• Соёлын төвийн засварын зураг, төсөв бэлтгэх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |
| **Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** | **20.0** |

- Соёлын төвийн барилгын их засвар – 10.0
- Музейн үзмэрийн тавиур, хоргыг шинэчлэх, суурилуулах – 1.5
- Үзмэр худалдан авч баяжилт хийх – 2.0
- Дууны техник, хэрэгсэл, гэрэл худладан авах, угсрах, байрлуулах – 1.2
- Төвийн гол заалны сандлыг бүрэн солих – 1.2
- Гадаад орчныг тохижуулах – 0.6
- Халаалтын системийг өргөтгөх – 3.5

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

| | |
|---|---|
| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2009 оноос 1 жил | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа соёлын төвийн үйл ажиллагаа тогтвортой явагдана |

| №12 | **Төсөл:** Зо2:Зт2:Хө2:Т2: Үндэсний мичид, зурхайн байртай болох | **Хөтөлбөр:** Зо2:Зт2:Хө1: Үндэсний ёс заншил, язгуур урлагийг өвлүүлэх, дэлгэрүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Үндэстний язгуур ба нийтлэг зан үйлийг залуу үед цаашид өвлүүлэн үлдээх, түгээн дэлгэрүүлэх боломж бүрдүүлсэн, шашны өвөрмөц зан үйлийг илтгэсэн байртай болно. Энэ төслийн бүрэлдэхүүнд сүм, зурхайн байр барих, шашны зан үйлийн ба эд өлгийн зүйлсийг бэлтгэх, хамтарсан сургууль бий болгох, бусад сум хийдтэй харилцаа холбоо тогтоож хамтран ажиллах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Иргэдийн дунд архи, тамхи хэрэглэх, хулгай, гэмт хэрэг хийх зэрэг сөрөг үр дагавар бүхий үйлдлийг багасгахад шашны зүгээс нөлөөлөх
- Үндэсний цөөнхийн өвөрмөц шүтлэг, зан үйлийг өвлүүлж үлдээх, уламжлуулах боломж бүрдүүлэх
- Үнэнчээр хөдөлмөрлөж амьдрах итгэл үнэмшлийг залуу үед төлөвлшүүлэх свөр

**Зорилтот бүлэг:**
- Сумын нийт иргэд

**Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**
- ЗДТГ
- Мэргэжлийн байгууллага

**Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**
- ЗДТГ
- Иргэд
- Хандивлагчид

**Зэхэц, урьдал нөхцлүүд:**
- Байрын зураг төсөл гаргах
- Зурхайчдыг тодруулах

**Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** 50.0

- Хуучин барилгын дээвэр, хоёр талын ханыг буулгах– 0.6
- Мичид зурхайн байрны зориулалтаар шинэчлэн барих – 40.0
- Дотоод чимэглэл, тохижилт – 2.5
- Шашны эд өлгийн зүйл худалдан авах, бэлтгэх, байрлуулах – 3.0
- Хамтарсан сургуулийн танхим байгуулж тохижуулах – 2.6
- Хурал номын зориулалттай тохижилт хийх – 1.3

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2009 оноос 2 жил

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа тогтвортой ажиллана.

<table>
<tr><td>№13</td><td>Төсөл: ЗоЗ:Зт1:Хө1:Т1: Дунд сургуулийн хичээлийн ба дотуур байрын их засвар, өргөтгөл, тохижилт</td><td colspan="2">Хөтөлбөр: ЗоЗ:Зт1:Хө1: Суурь боловсролын үйлчилгээний нөхцлийг сайжруулах</td></tr>
<tr><td colspan="4">Төслийн товч тодорхойлолт: Тус сумын лицей сургуульд 1000 гаруй хүүхэд суралцаж байна. 1–4 дүгээр ангиуд 2 ээлжээр хичээллэж, 150 хүүхдийн багтаамжтай дотуур байранд 300 хүүхэд байрлаж, 60 гаруй хүүхэд дотуур байранд орж чадахгүй байна. Сургуулийн барилга сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, үзүүлэн таниулах материал орчин үеийн шаардлагаас хол хоцорч сургалтын чанарт тааламжгүй нөлөөлж байна. Сумын сургуулийн байр, техник, тоног хэрэгслийн бүхий л нөхцлийг үндэсний стандартын хэмжээнд хүргэж, сургалтын чанарыг сайжруулах боломж, нөхцлийг бүрдүүлэхэд төслийн зорилго оршино. Уг төслөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны бүрэлдэхүүнд дунд сургуулийн хичээлийн ба дотуур байрын өргөтгөл, одоо байгаа байрын их засвар, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, үзүүлэн таниулах материалын хангамжийг сайжруулах асуудал багтаж байгаа болно.</td></tr>
<tr><td colspan="2">Хүлээгдэж буй үр дүн:<br>• Сумын сургуулийн сургалт явуулах нөхцөл үндэсний стандартад хүрэх<br>• Сургалтын чанар дээшлэх<br>• Багшлах бүрэлдэхүүн, чанар сайжрах</td><td colspan="2">Зорилтот бүлэг:<br>• Дунд сургуулийн сурагчид<br>• Сумын нийт иргэд</td></tr>
<tr><td colspan="2">Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:<br>• Засгийн газар<br>• ЗДТГ<br>• Дунд сургууль</td><td colspan="2">Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:<br>• Засгийн газар<br>• Хандивлагчид</td></tr>
<tr><td colspan="2">Зэхэц, урьдал нөхцлүүд:<br>• Сургуулийн хичээлийн ба дотуур байрын өргөтгөлийн зураг төсөв гаргах<br>• Сургуулийн одоо байгаа хичээлийн ба дотуур байрын их засварын төсөв хийх<br>• Сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, үзүүлэн таниулах материалын хангамжийг сайжруулах санал, төсөв бэлтгэх</td><td colspan="2">Эрсдэлтэй хүчин зүйлс:<br>• Санхүүжилтийн асуудал улсын төсөвт тусгагдахгүй байх</td></tr>
<tr><td colspan="4">Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг: 400.0</td></tr>
<tr><td colspan="4">• Хичээлийн ба дотуур байрны их засвар, өргөтгөл – 340.0<br>• Сургалтын тоног төхөөрөмж шинэчлэх – 24.0<br>• Дотуур байрны дотоод тоног төхөөрөмж, зөөлөн эд, соёл–ахуйн зориулалттай техник материалын зардал – 18.5<br>• Гадаад орчны тохижилт – 3.0<br>• Эмэгтэй хүүхдийн дотуур байрны тусгай тохижилт – 14.0</td></tr>
<tr><td colspan="4">Холбоо барих байгууллага, хүн: Тариалан сумын лицей дунд сургуулийн захиргаа</td></tr>
<tr><td colspan="2">Хэрэгжүүлэх хугацаа: 2008–2011 онд<br>3 жил</td><td colspan="2">Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төслийн дараа сургуулийн үйл ажиллагааны сайжралт тогтвортой байна.</td></tr>
</table>

| №14 | **Төсөл:** ЗоЗ:Зт1:Хө1:Т4: Цэцэрлэгийн өргөтгөл, тохижилт | **Хөтөлбөр:** ЗоЗ:Зт1:Хө1:Т4: Суурь боловсролын үйлчилгээний нөхцлийг сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Тариалан сум хүн ам олонтой, ялангуяа төрөлт өндөр учраас цэцэрлэгийн байр, хүрэлцээ шаардлага хангахгүй болсоор удаж байна. Сумын цэцэрлэгийн барилга 1980–аад онд баригдсан бөгөөд өнгөрсөн хугацаанд өргөтгөл, засвар, тохижилт хийгдээгүй болно. Цэцэрлэгийн барилгыг өргөтгөснөөр өсвөр насны хүүхдийн зөв хүмүүжлийг төлөвшүүлэх, цэцэрлэгийн сургалтын орчин, материаллаг баазыг бэхжүүлж, сургуулийн өмнөх боловсролыг сайжруулах нэг үндэс болох юм. Төслөөр цэцэрлэгийн байрыг өргөтгөх, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах, багш, ажиллагсдын чадавхийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Цэцэрлэгийн сургалтын орчин сайжирч, материаллаг баазыг бэхжүүлнэ.
- Цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоо нэмэгдэнэ.

**Зорилтот бүлэг:**
- Сумын нийт иргэд
- Өсвөр насны хүүхдүүд

**Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**
- Засаг даргын тамгын газар

**Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**
- Засгийн газар
- Хандивлагчид

**Зэхэц, урьдал нөхцлүүд:**
- Барилгын засварын зураг, төсөв хийх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** 30.0

- Цэцэрлэг, яслийн байрны өргөтгөл – 24.0
- Сургалтын ба үзүүлэн таниулах зүйлс, тоног төхөөрөмж шинэчлэх – 2.5
- Дотоод тоног төхөөрөмж, соёл–ахуйн зориулалттай техник материал – 1.0
- Тоглоом–амралтын талбай, гадаад орчны тохижилт – 1.0
- Янз бүрийн насны хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролд зориулсан тусгай тохижилт – 1.5

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2008 оноос 2 жил

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа тогтвортой үргэлжилнэ.

| №15 | **Төсөл:** ЗоЗ:Зт1:Хө2:Т1: Сумын хүн эмнэлгийн барилгын өргөтгөл, тоног төхөөрөмжийн шинэчлэл | **Хөтөлбөр:** ЗоЗ:Зт1:Хө2: Эрүүл мэндийн үйлчилгээний нөхцлийг сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сүүлийн 10 гаруй жил засвар өргөтгөл хийгдээгүй төрийн халамж үйлчилгээний цөөхөн объектийн тоонд орох сумын хүн эмнэлгийн барилга хуучирсны дээр сумын хүн ам 3000 гаруй байх үеийн тооцоогоор баригдсан, түүнээс хойш багтаамж, хүчин чадлыг нэмэгдүүлээгүй болно. Ийм учраас эмнэлгийн үйлчилгээг түргэн шуурхай болгох, амбулаториор болон хэвтэж эмчлүүлэгчдэд үзүүлэх эмчилгээний чанарыг дээшлүүлэхэд эмнэлгийн барилгыг өргөтгөж, хүүхдийн, халдварт, нөхөн сэргээх шинэ тасгууд тусад нь нээж ажиллуулан хүн амд үзүүлэх эрүүл мэндийн чанаржуулах шаардлага тавигдаж байна. Төслийн бүрэлдэхүүнд эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчилж орчин үеийн багаж хэрэгслээр хангах, зөөлөн эдийн хангамжийг сайжруулах, эхийн амаржих байр шинээр байгуулах асуудал багтах болно.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Хүн эмнэлгийн хүлээн авах, эмчилгээний ба дараах орчин сайжирч, материаллаг баазыг бэхжүүлнэ.<br>• Хөдөөгийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний байдал, чанар сайжран шуурхай болно. | • Сумын нийт иргэд |
| **Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**<br>• Засаг даргын тамгын газар<br>• Аймгийн Эрүүл мэндийн газар<br>• Сумын хүн эмнэлэг | **Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**<br>• Засгийн газар<br>• Хандивлагчид |
| **Зэхэц, урьдал нөхцлүүд:**<br>• Барилгын засварын зураг, төсөв хийх<br>• Шинээр суурилуулах тоног төхөөрөмжийн тодорхойлолт гаргах | **Эрсдэлтэй хүчин зүйлс:**<br>• Улсын төсөвт тусгагдахгүй байх |

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** 100.0

- Эмнэлгийн барилгын өргөтгөл – 50.0
- Хүүхдийн, халдварт, нөхөн сэргээх шинэ тасгууд тусад нь тохижуулах, ажиллуулах – 12.0
- Эхийн амаржих байрыг тусад нь тохижуулах – 3.0
- Эмнэлгийн үзлэг, эмчилгээ, урьдчилан сэргийлэх багаж төхөөрөмжийг шинэчлэх – 10.0
- Багууд дахь эмнэлгийн явуулын үйлчилгээний багаж төхөөрөмжийг шинэчлэх – 6.0
- Түргэн тусламжийн машин – 10.0
- Багийн эмч нарын унаа – 6.2
- Зөөлөн эдлэл солих – 2.8

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2007– 2009 | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа үр дүнг шууд тогтвортой ашиглаж эхлэнэ. |
|---|---|

| №16 | **Төсөл:** ЗоЗ:Зт2:Хө1:Т1: ЗДТГ-ын дэргэд сургалтын байр гаргаж тохижуулах | **Хөтөлбөр:** ЗоЗ:Зт2:Хө1: Нутгийн иргэдийн мэргэжлийн чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** ДЕЛТА төслийн хүрээнд явуулсан бизнес орчны судалгаагаар мэргэшсэн ба дадлага эзэмшсэн ажиллах хүч дутагдалтай, сумын ЗДТГ-аас сургалт зохион байгуулах арга хэмжээг өөрийн харъяалалдаа хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан билээ. Аймгийн төв, бусад газар зохион байгуулагдаж байгаа сургалтад хүмүүсээ оролцуулах боломжтой ч сумын эдийн засаг-нийгмийн өвөрмөц байдал, хэрэгцээнд тэр бүр тохирдоггүй, зардал өндөр. Түүнчлэн орон нутгийн бизнесийг хөгжүүлэхэд сумын мэргэжлийн ба хүн хүчний чадавхийг бүрэн дүүрэн ашиглах, сумын байгууллагууд төрөл бүрийн сургалт, үзүүлэн таниулах, сурталчлах арга хэмжээ зохион байгуулахад зориулалтын, хамгийн гол нь хэдийд ч олдоцтой тохижуулсан байр дутагдалтай байна. ЗДТГ-аас үзүүлэх төрийн үйлчилгээний хүрээнд сургалтын байраар хангаж дэмжлэг үзүүлэх, үүний тулд нутгийн захиргааны барилгын зарим өрөөг засах, тохижуулах ажилд дэмжлэг авахаар энэхүү төслийг санал болгож байна.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Мэргэжлийн, дадлагажуулах, давтан сургалт явуулах зориулалтын тохижуулсан сургалтын байртай болно.<br>• Сумын иргэдийн ажил эрхлэх чадвар дээшилнэ<br>• Сургалтын байраар дамжуулан сумын эдийн засгийн хөгжилд иргэдийн оролцоог дээшлүүлэх | • Сумын төрийн ба хувийн хэвшлийн байгууллагууд<br>• Нийт иргэд |
| **Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**<br>• ЗДТГ | **Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**<br>• ЗДТГ<br>• Хандивлагчид<br>• Иргэд, байгууллагууд |
| **Зэхэц, урьдал нөхцлүүд:**<br>• Засвар хийх байрны зураг, төсөв хийх<br>• Шинээр суурилуулах тоног төхөөрөмжийн тодорхойлолт гаргах | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** 10.0

- Сургалтын байрны зориулалтаар өрөө засварлах, шинээр тохижуулах – 6.0
- Үзүүлэн, сурталчилгааны ба дадлагажуулалтын зориулалттай зүйлс олж бэлтгэх, суурилуулах – 2.0
- Сургалтын хөтөлбөр, гарын авлага, тараах материал бэлтгэх, хэвлүүлэх – 2.0

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2007-2008 онд | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа тогтвортой ажиллана. |
|---|---|

<table>
<tr><td>№17</td><td>Төсөл: Зо3:Зт2:Хө1:Т2: Мэргэжүүлэх болон давтан сургах сургалтын эрэлтийн судалгаа явуулах</td><td>Хөтөлбөр: Зо3:Зт2:Хө1: Нутгийн иргэдийн мэргэжлийн чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх</td></tr>
<tr><td colspan="3">Төслийн товч тодорхойлолт: Одоогоор үйл ажиллагаа явуулж байгаа бизнесээ өргөжүүлэх, шинээр бизнес эхлэхэд тохиолдож буй нэг бэрхшээл бол суманд мэргэжилтэй, туршлагатай ажиллах хүчин дутагдалтай байгаа явдал юм. ЗДТГ–ын боломжийг ашиглан сургалтын байраар хангах замаар сургалт, давтан сургах арга хэмжээг судалгааны үндсэн дээр төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай юм. Төслийн зорилго нь суманд явуулах (Зо3:Зт2: Хө1:Т1: ЗДТГ–ын дэргэд сургалтын байр гаргаж тохижуулах төсөлтэй уялдуулах) сургалтын гол чиглэлийг тогтоож, сумын ЭЗХ–ийн стратегийг хэрэгжүүлэхэд иргэд, байгууллагын идэвхтэй оролцоог хангахад чиглэнэ. Уг судалгааг явуулахад санхүүгийн ба мэргэжлийн туслалцаа шаардлагатай бөгөөд сумын эдийн засаг–нийгмийн хөгжлийн одоогийн байдал, эдийн засгийн хөгжлийн стратегийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, бизнесийг дэмжих чиглэлийн дагуу сургалт, давтан сургалтын хөтөлбөрийн үндэслэл болон сургагч бэлтгэх, гарын авлага бэлтгэх чиглэлийг тодорхойлно.</td></tr>
<tr><td colspan="2">Хүлээгдэж буй үр дүн:<br>• Сургалт, давтан сургалтын эрэлт тодорхойлогдоно<br>• Эдийн засгийн хөгжлийн стратегийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, бизнесийг дэмжих чиглэлийн дагуу сургалт, давтан сургалтын хөтөлбөрийн үндэслэл боловсрогдоно</td><td>Зорилтот бүлэг:<br>• Сумын нийт иргэд<br>• Бизнес эрхлэгчид</td></tr>
<tr><td colspan="2">Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:<br>• Засаг даргын тамгын газар<br>• Бизнес эрхлэгчид</td><td>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:<br>• ЗДТГ<br>• Хандивлагчид<br>• Мэргэжлийн байгууллагууд</td></tr>
<tr><td colspan="2">Зэхэц, урьдал нөхцлүүд: Шаардлагагүй</td><td>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</td></tr>
<tr><td colspan="3">Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг: 3.0</td></tr>
<tr><td colspan="3">Холбоо барих байгууллага, хүн: Тариалан сумын ЗДТГ</td></tr>
<tr><td colspan="2">Хэрэгжүүлэх хугацаа: 2008 онд 3 сар</td><td>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төсөл хэрэгжсэний дараа үр дүнг тогтвортой ашиглана.</td></tr>
</table>

| №18 | **Төсөл:** ЗоЗ:ЗтЗ:Хө1:Т1: Цагдаагийн тасагтай болж, үйлчилгээний хүрээг өргөтгөх | **Хөтөлбөр:** ЗоЗ:ЗтЗ:Хө1: Малын хулгайг багасгах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сүүлийн жилүүдэд малын хулгай ихсэхийн зэрэгцээ алтны хоёр уурхай, нүүрсний уурхай ашиглалтад орж албан ба албан бусаар олон айл өрх, хүмүүс газар бүрээс цугларч, янз бүрийн хэрэг зөрчил гарах нь нэмэгдэх төлөвтэй боллоо. Нутгийнхны сэтгэлийг хамгийн ихээр зовоосоор ирсэн малын хулгайг багасгах, таслан зогсооход чиглэгдсэн малын хөдөлгөөнийг хянах дохиоллын систем нэвтрүүлэх, малчдын хүчийг зөв зохион байгуулж мал нутгаас гаргах, дамжуулах гол гарцыг хяналтад авах зэрэг шинэ арга хэмжээг туршихад цагдаагийн хүчийг ашиглах шаардлага улам нэмэгдсээр байна. Иймд цагдаагийн хэсгийг тасаг болгон өргөтгөн зохион байгуулах, үүний тулд ажлын тохиромжтой байр засварлаж бэлтгэх, тохижуулах шаардлагатай арга хэмжээ авснаар сумын хэмжээнд эрүүгийн нөхцөл байдлыг бууруулах, гэмт хэргийн гаралтыг багасгах боломж бүрдэнэ гэсэн үндэслэлээр энэхүү төслийг хэрэгжүүлэх саналыг дэвшүүлж байна.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Нөхцөл шалтгаантай нь тэмцэх замаар гэмт хэргийг бууруулах боломж урьдынхаас нэмэгдэнэ
- Цагдаагийн байгууллагын хүчний хангамж, ажиллах нөхцөл сайжирч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шинэ арга туршин нэвтрүүлэх чадвар нь дээшилнэ
- Иргэд–цагдаагийн тасгийн ажлын уялдаа холбоо улам бэхжиж малын хулгайг үлэмж бууруулна.

**Зорилтот бүлэг:**
- Сумын нийт иргэд
- ЗДТГ
- Цагдаагийн ажилтнууд

**Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**
- ЗДТГ
- Аймгийн цагдаагийн хэлтэс

**Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**
- ЗДТГ
- Хандивлагчид /Австралийн засгийн газар/
- Мэргэжлийн байгууллагууд

**Зэхэц, урьдал нөхцлүүд:**
- Ажлын байр засварлах/шинээр барих байршлыг тогтоох
- Шинээр ажилд орох ажилтны орон байр, гэр бүлийнхний ажлын байрны асуудлыг шийдвэрлэх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** 30.0

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

- Цагдаагийн хэсгийн байрыг тасгийн зориулалттай болгож өргөтгөх – 15.0
- Ажиллах нөхцлийг сайжруулах – 2.0
- Унаатай болгох – 12.0
- Үйл ажиллагааны эхлэлийн зардал – 1.0

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2010–2011

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа тогтвортой үргэлжилнэ.

| №19 | **Төсөл:** ЗоЗ:ЗтЗ:Хө1:Т2: Малчдыг хөдөлгөөнт холбооны сүлжээнд хамруулах | **Хөтөлбөр:** ЗоЗ:ЗтЗ:Хө1: Малын хулгайг багасгах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сумын малчид жилийн 8 сар орчмыг Хархираа–Түргэн, Намирын нуруунд өнгөрөөдөг, биеэр ирэх, хүнээр хэл дамжуулахаас өөрөөр сум, багтай холбоо барих арга, хэрэгсэл байхгүй. Үүрэн телефоны “Мобиком”, “Скайтел” сүлжээнд холбогдсон боловч сумын төвийн баруун өндөр уулсад халхлагддагаас үйлчилгээний хүрээ нь уул багатай тэгш газрыг бодвол нэн хязгаарлагдмал, төвөггүй шийдвэрлэж болох шалтгааны улмаас малчдын эрэлтийг хангаж чадахгүй байна. Малчдыг хөдөлгөөнт холбоонд хамруулах асуудлыг хоёр чиглэлээр шийдвэрлэх боломж бий. (i). сумаас 40 орчим км–т, малчдын өвөл–хавар (сумаас холдсон, холбоо барихад бэрхшээлтэй, хамгийн хүнд улирал)–ын бэлчээрийн хүрээлэл дунд хамгийн ойрхон байгаа Хар тарвагатайн уурхайн тосгонд антенна тавьбал энэ асуудлыг үндсэнд нь шийдвэрлэнэ. (ii). Түүнчлэн баг, тосгонд, айл өрх бөөндүү газраар сансрын холбооны суурин антенна байрлуулж нэг цэгээс холбоо барих боломжоор хангах зэрэг болно.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Холбооны үйлчилгээний хүрээ өргөжинө.
- Малчид холбооны орчин үеийн систем ашиглах боломжтой болно.
- Сумын захиргаа, баг, төрийн үйлчилгээний ба хувийн хэвшлийн байгууллагуудаас цаг үеийн ба бусад төрөл бүрийн мэдээллийг цаг алдалгүй, шуурхай, үнэн зөв дамжуулах, хүлээн авах боломж

**Зорилтот бүлэг:**
- Сумын нийт иргэд

**Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**
- ЗДТГ
- Холбооны байгууллага

**Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**
- Хандивлагчид
- Хувийн хэвшил

**Зэхэц, урьдал нөхцлүүд:**
- Малчдад мэдээлэл хүргэж, үйлчилгээ авах бэлтгэлийг хангуулах
- Антенна байрлуулах газрыг олон нийтийн оролцоотойгоор товлох
- Ажиллуулах хүнээ сургаж бэлтгэх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:**
- Засвар үйлчилгээний асуудал

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** 40.0

- Хөдөлгөөнт холбооны антенна Хартарвагатайд байрлуулах – 28.0
- Сансрын холбооны антенна шинээр тавих – 7.0
- Ашиглалтын өмнөх ба ажиллагааны сургалт явуулах – 1.6
- Малчдад сурталчлах, зааж сургах түр сургалт зохион байгуулах – 2.4
- Ашиглалтын заавар бэлтгэж хэвлэн тараах – 1.0

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2008 оноос 24 сар

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа үр дүнг үргэлжлүүлэн тогтвортой ашиглана.

| №20 | **Төсөл:** ЗоЗ:ЗтЗ:Хө1:Т3: Малын хөдөлгөөнийг хянах дохиоллын систем нэвтрүүлэх | **Хөтөлбөр:** ЗоЗ:ЗтЗ:Хө1: Малын хулгайг багасгах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сүүлийн 10 жилд Тариалан суманд малын хулгай нэмэгдсээр ирсэн, цаашид нэмэгдэх хамгийн өндөр хандлага бүхий сумын тоонд ордог. Сумын баруун хойноос зүүн өмнө тал хүртлээ 8 сумтай нутаг дэвсгэрээрээ болон жилийн 4 улиралд холын нүүдлийн зам, даваагаар холбогддог учраас хүн, мал, машин техникийн хөдөлгөөн хамгийн ихтэй сум юм. Хувиараа алт олборлогчид, нүүрс малтагчид гээд газар газраас ирсэн хүмүүс нааш цааш холхиж явдаг. Хүн, малын энэ бүх хөдөлгөөн нь малын хулгай байнга гарах, тэгэхдээ хээрээс сүргээр нь авдаг байснаа сүүлийн үед цөөнөөр нь сэм хулгайлдаг, хотноос, бэлчээрээс хүч, зэвсэг хэрэглэн дээрэмдэх ч явдал гарсан тул малчид, хүмүүс хүчин ихээхэн мөхөсдөж байна. Иймд малын хөдөлгөөнийг сансраас хянах дохиоллыг сумандаа турших, цаашдаа өргөн хэрэглэх боломжийг тогтоох зорилгын дор төсөл санаачлах шаардлагыг томъёолж байна.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Дохиоллын системийн тусламжтайгаар авсан мэдээллийг малын хөдөлгөөнийг хянахад ашиглах боломжийг тогтооно
- Малын хулгай багасч, мал эрэхэд гарах үргүй зардал, цагийг бууруулна

**Зорилтот бүлэг:**
- Сумын нийт иргэд

**Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**
- ЗДТГ
- Цагдаагийн тасаг

**Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**
- Хандивлагчид
- ЗДТГ
- Цагдаагийн тасаг

**Зэхэц, урьдал нөхцлүүд:**
- Дохиоллын системийн талаар мэдээлэл цуглуулах

**Эрсдэлтэй хүчин зүйлс:**
- Малд дохиоллын систем хэрэглэсэн туршлага Монголд байхгүй
- Тусгай бэлтгэгдсэн хүмүүсийг байнга ажиллуулах учир зардал өндөр байх

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** **50.0**

- Дохиоллын систем иж бүрнээр олж нийлүүлэх – 40.0
- Дохиоллын системийг багт ажиллуулах хүмүүсийг сургах, мэргэшүүлэх – 2.9
- Сургалтын гарын авлага ба ажлын зааварчлага боловсруулах, хэвлүүлэх – 1.5
- Малд тавьж турших, үр дүнг тооцох – 5.0
- Малын хөдөлгөөний талаар тогтмол мэдээлэл бэлтгэх, нийтэд тараах – 2.6

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ, цагдаагийн тасаг

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2009–2015

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа малын хлгай буурч, иргэдийн амьдрал дээшдэснээр үр дүн тогтвортой үргэлжилнэ.

| №21 | **Төсөл:** ЗоЗ:Зт4:Хө1:Т1: ЗДТГазрыг түшиглүүлэн чийрэгжүүлэх танхим байгуулах | **Хөтөлбөр:** ЗоЗ:Зт4:Хө1: Биеийн тамир, спортын хөгжлийг дэмжих |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Иргэдийн дунд чөлөөт цагаа өөрсдийн эрүүл мэндийг сайжруулахад зарцуулж зөв боловсон өнгөрөөх боломж хангагдаагүй учраас чийрэгжүүлэлт, эрүүл амьдрах ёсыг төлөвшүүлэх талаар мэдэгдэм ахиц өөрчлөлт гарахгүй явж ирсэнд дүгнэлт хийж нийтийн биеийн тамирыг дэлгэрүүлэх санаачлагыг ЗДТГ–аас эхлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна. Чийрэгжүүлэх танхимын зориулалттай барилга барих, орчин үеийн шаардагдах тоног төхөөрөмжөөр хангах, мэргэжлийн багш, дасгалжуулагч бэлтгэх, олон нийтийг нийтийн биеийн тамирын арга хэмжээнд хамруулах сургалт сурталчилгаа явуулах зэрэг арга хэмжээнүүд уг төслийн бүрэлдэхүүнд багтаж байгаа болно. Төслийг шат шатаар нь хэсэгчлэн хэрэгжүүлэх боломжтой.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Иргэдэд үйлчлэх чийрэгжүүлэх танхимтай болох
- Иргэдийн эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх асуудлаар ахиц өөрчлөлт гаргах
- Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний байдал, чанар сайжран шуурхай болно.

**Зорилтот бүлэг:**
- Сумын нийт иргэд
- Лицей дунд сургууль

**Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**
- Засгийн газар
- Хандивлагчид
- Засаг даргын тамгын газар

**Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**
- Засгийн газар
- Хандивлагчид

**Зэхэц, урьдал нөхцлүүд:** Шаардагдахгүй

**Эрсдэлтэй хүчин зүйлс:**
- Санхүүжүүлэгч олдохгүй байх
- Үр ашиг багатай байх

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** **100.0**

- Чийрэгжүүлэх танхмын зориулалттөй барилга барих – 75.0
- Шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгсэл худалдан авах, байрлуулах – 8.0
- Бага хүчин чадлын сауна, усан банна байгуулах – 10.0
- Олон нийтэд зориулсан чийрэгжүүлэлтийн арга хэмжээ зохион байгуулах хэрэгслээр хангах – 6.0
- Чийрэгжүүлэлтийн талаар гарын авлага, лавлах, үзүүлэн таниулах материал бэлтгэх, хэвлэх – 1.0

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2009 – 2010 онд

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа тогтвортой үргэлжилнэ.

| №22 | **Төсөл:** ЗоЗ:Зт4:Хө1:Т2: Нийтийн биеийн тамир, сонирхогчдын спорт хөгжүүлэх, дэмжих сан бий болгох | **Хөтөлбөр:** ЗоЗ:Зт4:Хө1: Биеийн тамир, спортын хөгжлийг дэмжих |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, олон нийтийг өргөн хамруулах, сонирхогчдын спортын сум, сум дундын ба аймгийн хэмжээний тэмцээнд баг бүрдүүлж оролцох, амжилтын төлөө өрсөлдөх явдал манай суманд хоцрогдонгуй явж ирсэн, энэ байдлаар цаашдаа дорвитой ахиц өөрчлөлт гарах төлөв бүдэгдүү байна. Сүүлийн жилүүдийн байдлаар тус сумаас аймаг, улсын ямар нэг тэмцээн, арга хэмжээнээс медаль хүртсэн, шагналт байранд олноор шалгарсан тохиолдол гараагүй. Иймд янз бүрийн эх үүсвэрийн оролцоотой сан бүрдүүлэх, олон нийтийн хяналтын дор ажиллуулах нь биеийн тамир, спортыг бүх нийтийн үйл болгон хөгжүүлэх, дэмжих, ялангуяа энэ хөдөлгөөнийг хүүхэд залуучуудын дунд идэвхтэй өрнүүлэх талаар хэрэгжүүлж болох хамгийн үр нөлөө бүхий арга хэмжээ мөн. Тоног төхөөрөмж, хэрэглэлээр хангах, бэлтгэл сургуулилтыг ивээн тэтгэх, амжилтыг урамшуулах зэрэг олон зориулалтаар ашиглагдах сан бий болгох нь энэ төслийн зорилго болно.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Нийтийн биеийн тамир, сонирхогчдын спортын тоноглол, хэрэгслийг сайжруулна
- Биеийн тамир, спортын арга хэмжээг сумандаа хөгжүүлэх эх үүсвэртэй болно.
- Биеийн тамир, спортоор хичээллэх, төрөл бүрийн арга хэмжээний чанар, хамрагдагсдын тоо нэмэгдэнэ
- Тамирчдын амжилтыг аймаг, үндэсний хэмжээнд ахиулах боломж бүрдэнэ

**Зорилтот бүлэг:**
- ЗДТГ
- Сумын нийт иргэд

**Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**
- ЗДТГ

**Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**
- ЗДТГ
- Хандивлагчид
- Хувийн хэвшил

**Зэхэц, урьдал нөхцлүүд:**
- Спорт, биеийн тамирын байр бэлтгэх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** 5.0

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2008–2010 онд

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа үр дүнг тогтвортой ашиглана

<table>
<tr><td>№23</td><td>Төсөл: Зо4:Зт1:Хө1:Т1: Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулах</td><td colspan="2">Хөтөлбөр: Зо4:Зт1:Хө1: Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих</td></tr>
<tr><td colspan="4">Төслийн товч тодорхойлолт: Байгаль–экологийн олон хүчин зүйлсийн сөрөг нөлөөллийг бууруулах ба зах зээлийн эрэлтийг хангах үүднээс МАА–г эрчимжүүлэн хөгжүүлэх төр, засгийн бодлогын тэргүүлэх чиглэлийг орон нутагт хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тариалан сум байгалийн, ялангуяа тэжээл бэлтгэх, үйлдвэрлэх арвин нөөцөө зохистой ашиглан МАА–г эрчимтэй аргаар эрхлэх туршлагаар нэн дутмаг учраас дунд хугацааны хөтөлбөр боловсруулах төсөл хэрэгжүүлж, сумын хэмжээнд баримтлах бодлого, үйл ажиллагаагаа нарийвчлан тодорхойлох нь зүйтэй юм.</td></tr>
<tr><td colspan="2">Хүлээгдэж буй үр дүн:<br>• МАА–г эрчимжүүлэх чиглэлээр сумаас баримтлах бодлого тодорхойлогдоно.<br>• Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулна<br>• МАА–г газар тариалантай хорших чиглэлд ахиц өөрчлөлт гарна</td><td colspan="2">Зорилтот бүлэг:<br>• ЗДТГ<br>• Малчид, тариаланчид</td></tr>
<tr><td colspan="2">Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:<br>• ЗДТГ</td><td colspan="2">Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:<br>• ЗДТГ<br>• Хандивлагчид<br>• Мэргэжлийн байгууллагууд</td></tr>
<tr><td colspan="2">Зэхэц, урьдал нөхцлүүд: Шаардлагагүй</td><td colspan="2">Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</td></tr>
<tr><td colspan="4">Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг: 1.0</td></tr>
<tr><td colspan="4">Холбоо барих байгууллага, хүн: Тариалан сумын ЗДТГ</td></tr>
<tr><td colspan="3">Хэрэгжүүлэх хугацаа: 2008 онд</td><td>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төсөл хэрэгжсэний дараа үр дүнг тогтвортой үргэлжлүүлэн ашиглана.</td></tr>
</table>

| №24 | **Төсөл:** Зо4:Зт1:Хө1:Т2: Мал эмнэлэг, үржлийн албыг өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх үндэслэл санал боловсруулах | **Хөтөлбөр:** Зо4:Зт1:Хө1: Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх, зах зээлд нийлүүлж буй түүхий эд, бүтээгдэхүүнд тавих чанар, аюулгүй байдлын хяналтыг хүчтэй болгох, үүний тулд мал үржил, эрүүл мэндийн үйлчилгээг чанаржуулах, хүртээмжтэй болгох явдал нэн тэргүүний зорилт болж хэрэгжих ёстой. Малын үүлдэрлэг байдал, ашиг шимт чанарыг дээшлүүлж үржлийн бааз бий болгож, мал сүргийн өвчлөлийг мал эмнэлгийн үр ашигтай үйлчилгээгээр бууруулахын тулд үйлчилгээ эрхэлж буй байгууллагын үйл ажиллагааны хүрээг өргөжүүлэх, тоног төхөөрөмжийг шинэчлэх, ажиллагсдыг чадваржуулах талаар сумын хэмжээнд хэрэгжүүлэх шинэчлэлийн арга хэмжээний санал боловсруулах, ЗДТГ-ын үржлийн албыг шаардагдах тоног төхөөрөмжөөр хангах хэрэгтэй байна.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх чиглэлээр малын эрүүл мэнд, үржлийн ажлыг шинэчлэх үндэслэл боловсрогдоно
- ЗДТГ-ын үржлийн алба шаардагдах тоног төхөөрөмжтэй болох

**Зорилтот бүлэг:**
- ЗДТГ
- Сумын мал эмнэлэг үржлийн алба
- Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид

**Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**
- ЗДТГ
- Сумын мал эмнэлэг үржлийн алба

**Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**
- ЗДТГ
- Хандивлагчид
- Увс аймгийн ХХААГ

**Зэхэц, урьдал нөхцлүүд:**
- Мал аж ахуйг эрчимжүүлэх бодлогын үндэслэл тодорхойлогдсон байх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** 30.0

- Үржлийн албанд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах – 10.0
- Шилмэл мал бойжуулах ба эрчимжсэн мал аж ахуйн технологийн сургалтын танхим тохижуулах – 5.0
- Зохиомол хээлтүүлгийн явуулын 2-3 цэг шинээр тохижуулах – 23.0
- Албаны болон зохиомол хээлтүүлгийн цэгүүдийн үйл ажиллагааны эхлэлийн зардал – 1.5
- Унаажуулах – 8.5
- Малчдад зориулсан сургалтын хөтөлбөр, сургалтын материал, гарын авлага бэлтгэх, хэвлэн олшруулах – 2.0

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ, мал эмнэлэг, үржлийн алба

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2008-2010 онд

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа үр дүнг тогтвортой хэрэгжүүлнэ

| №25 | **Төсөл:** Зо4:Зт1:Хө1:Т3: Малын үүлдэр угсааг сайжруулахад зуучлах үйлчилгээ нэвтрүүлэх | **Хөтөлбөр:** Зо4:Зт1:Хө2: Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Эрчимжсэн МАА эрхлэхэд өндөр ашиг шимт үүлдэр, нутгийн шилмэл омгийн малыг сайжруулагчаар ашиглах шаардлагатай. Үүний тулд “Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр”–ийн дагуу өндөр ашиг шимт үүлдэр, нутгийн шилмэл омгийн мал үржүүлж буй бусад аймаг, сумдын аж ахуйн нэгж, иргэдтэй холбоо тогтоох, орон нутгийн нөхцөлд зохицох чадвартай, ашиг шимээр шалгагдсан үржлийн мал олж нийлүүлэх замаар малчид, аж ахужин нэгжүүдэд нэгдсэн журмаар дэмжлэг үзүүлэх ажлыг сумын ЗДТГ, ХХАА–н түшмэл хариуцан гүйцэтгэх нь хамгийн үр өгөөжтэй хэлбэр болж чадна. Малчдаас авсан хүсэлт, захиалгын үндсэн дээр үржлийн мал олж нийлүүлэхийн тулд мал үржлийн ажилд шаардлагатай зарим багаж, тоног төхөөрөмжөөр хангахад хандивлагчдаас тусламж авах, үржлийн сайн чанарын мал нийлүүлэх сумын нөөц сан бий болгох шаардлагатай.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Тариалан суманд эрчимжсэн МАА хөгжүүлэх чиглэлийн дагуу үржлийн мал нийлүүлэх зуучлах боломж нэмэгдэнэ
- МАА–н үржлийн ажилд төрийн зүгээс тавих хяналтыг орон нутагт хэрэгжүүлэх аргачлал, загварчлалыг томъёолно.
- Малчдын дунд хээлтүүлэгч мал солилцох, үржлийн мал бойжуулж борлуулах өрх, аж ахуйн нэгж бий болоход түлхэц үзүүлнэ.

**Зорилтот бүлэг:**
- ЗДТГ
- Сумын нийт иргэд

**Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**
- ЗДТГ

**Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**
- Засгийн газар
- ЗДТГ
- Хандивлагчид

**Зэхэц, урьдал нөхцлүүд:**
- “Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр” боловсрогдсон байх
- Зуучлах үйлчилгээний талаар малчид, аж ахуйн нэгжүүдтэй урьдчилан хэлэлцсэн, тохиролцсон байх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:**
Байхгүй

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** 30.0

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

- Нутгийн байгаль–цаг уур, маллагааны нөхцөл, малдчын эрэлтэд зохицсон өндөр ашиг шимтэй мал бүхий сарлаг, хонь, үхрийн шилмэл сууръ байгуулах – 12.5
- Эрчимжсэн маллагаа бүхий малд зориулсан тэжээл бэлтгэх загвар цех, тариалангийн талбайтай болгох – 9.0
- Жижиг оврын техникээр хангах – 4.5
- Үр бордоо, бусад материал авах, үйл ажиллагаа эхлэхэд зориулсан эхлэлийн зардал – 2.5
- Сургалтын ба мэдээлэл сурталчилгааны техник, тоног төхөөрөмж – 1.5

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2007–2012онд 5 жил

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа үр дүнг тогтворжуулах арга хэмжээ хэрэгжүүлнэ.

| №26 | **Төсөл:** Зо4:Зт2:Хө1:Т1: Хүнсний захын байр бий болгох | **Хөтөлбөр:** Зо4:Зт2:Хө1: Худалдааны нөхцөл, ахуйн үйлчилгээг сайжруулахад дэмжлэг үзүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Хүнсний бүтээгдэхүүнийг ариун цэврийн стандарт, шаардлагыг хангасан нөхцөлд борлуулах боломж тус суманд нэн хоцрогдонгуй байгаа нь зах байгуулж ажиллуулахад шаардагдах хөрөнгө оруулах томоохон компани, аж ахуйн нэгж байхгүй учраас байр дутагдалтай байгаатай холбоотой. Энэ байдалд дүгнэлт хийж, орон нутгийн өмчид бүртгэлтэй барилгыг хүнсний захын зориулалтаар засварлан, цахилгаан, ус, халаалтын шугам, дотоод тоноглолыг шинэчилж дэмжлэг үзүүлэх боломжтой гэж ЗДТГ үзэж байгаа. Энэ төслийг хэрэгжүүлснээр дулааны улиралд мах, сүү ил худалддаг явдлыг зогсоохын зэрэгцээ ойролцоо байгаа малчид бүтээгдэхүүнээ өөрсдөө борлуулах боломжийг үлэмж өргөжүүлнэ.

| | |
|---|---|
| **Хүлээгдэж буй үр дүн:**<br>• Хүнсний зах шинээр нээгдэнэ<br>• Хүнсний бүтээгдэхүүний чанар, ариун цэвэр сайжирна<br>• Хүнсний бүтээгдэхүүний үнэ, борлуулалт тогтмолжиж, олдоц одоогийнхоос сайжирна | **Зорилтот бүлэг:**<br>• Хувийн хэвшил<br>• Сумын нийт малчид, иргэд |
| **Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**<br>• ЗДТГ<br>• Хувийн хэвшил<br>• Сумын нийт малчид, иргэд | **Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**<br>• Засгийн газар<br>• ЗДТГ<br>• Хандивлагчид |
| **Зэхэц, урьдал нөхцлүүд:**<br>• Барилгын засварын зураг, төсөв хийх<br>• Шинээр суурилуулах тоног төхөөрөмжийн тодорхойлолт гаргах | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** 13.0

- Барилгын гадаад ба дотоод засвар – 6.0
- Ус, халаалт, гэрэлтүүлгийн тоног төхөөрамж тавих, төв шугамд холбох – 2.0
- Лангуу, бага оврын склад – 2.0
- Угаалга, цэвэрлгээ, ариун цэвэр, ариутгалын төхөөрөмж суурилуулах – 1.5
- Гадаад орчны тохижилт – 1.5

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

| | |
|---|---|
| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2008 оноос 12 сар | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа захыг тогтвортой ажиллуулна |

| №27 | **Төсөл:** Зо4:Зт2:Хө1:Т2: Худалдаа, ахуйн үйлчилгээний нэгдсэн төвийн зориулалттай барилга | **Хөтөлбөр:** Зо4:Зт2:Хө1: Худалдааны нөхцөл, ахуйн үйлчилгээг сайжруулахад дэмжлэг үзүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сумын хөдөлмөрчдөд нийтийн үйлчилгээ (үсчин, гутал засвар, халуун ус, жижиг засвар гэх мэт)–г тогтмолжуулж, хүртээмжийг сайжруулах асуудал тулгамдсан хэвээр байна. Ялангуяа үйлчилгээг нэг дор төвлөрүүлж хэрэглэгчдэд төвөг багатайгаар хүргэх, орон нутгийн хяналтыг зохих түвшинд тавьж ажиллахад дөхөм үзүүлэхгүйгээр нийтийн үйлчилгээг сайжруулахад бэрхшээлтэй байдлыг харгалзан ЗДТГ–ын зүгээс байраар хангах асуудлыг энэ төслийн хүрээнд хэрэгжүүлнэ. Энэ төслийг үйлчилгээний чиглэлээр жижиг бизнес эрхлэх боломжийг өргөжүүлэхийн зэрэгцээ үйлчилгээг цогцолборжуулах болно. Жижиг бизнес эрхлэх хүмүүсийг хамруулснаар сургалт, дадлагажуулалт, давтан сургах арга хэмжээ хэрэгжүүлэх төслийн хэрэгжилт, үр дүнг тогтмолжуулахад зохих хувь нэмэр болно.

**Хүлээгдэж буй үр дүн:**

- Үйлчилгээний нэгдсэн төв шинээр нээгдэнэ
- Үйлчилгээний чиглэлтэй жижиг бизнесийг дэмжлэг үзүүлнэ
- Үйлчилгээ тогтмолжиж чанар, ариун цэвэр, хүртээмж сайжирна

**Зорилтот бүлэг:**

- Сумын нийт иргэд
- Бизнес эрхлэгчид

**Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:** ЗДТГ

**Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**

- Засгийн газар
- Хувийн хэвшил
- Хандивлагчид

**Зэхэц, урьдал нөхцлүүд:**

- Барилгын зураг, төсөв хийх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** **200.0**

- Худалдаа, ахуйн үйлчилгээний нэгдсэн төвийн зориулалттай барилга барих – 112.0
- Дотоод тохижилт – 5.0
- Ус, халаалт, гэрэлтүүлэг, сэрүүцүүлэх тоног төхөөрамж тавих, төв шугамд холбох – 25.0
- Лангуу суурилуулах, склад байгуулах – 20.0
- Угаалга, цэвэрлгээ, ариун цэвэр, ариутгалын төхөөрөмж суурилуулах – 35.0
- Гадаад орчны тохижилт – 3.0

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2011 оноос 24 сар

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа үр дүнг тогтвортой ашиглана

| №28 | **Төсөл:** Зо5:Зт1:Хө1:Т1: Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах | **Хөтөлбөр:** Зо5:Зт1:Хө1: Төрийн болон захиргааны үйлчилгээг сайжруулах боломж бүрдүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сумын аж ахуйн нэгжүүд, уугуул иргэдээс гадна бусад газраас хүмүүс, аж ахуйн нэгжүүд тус сумын нутаг дэвсгэрт ХАА, уул уурхай, аялал жуулчлал, байгаль хамгаалал зэрэг газар, түүний нөөцийг ашиглахтай холбоотой үйл ажиллагаа явуулах хүсэлт байнга гарч, цаашид тогтвортой нэмэгдэх төлөвтэй байна. Увс аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний холбогдох хэсгийг үндэслэн сумын газрын нөөцийг зохистой ашиглах ерөнхий төлөвлөгөө боловсруулах шаардлага тулгамдаж эхэллээ. Сумын иргэдэд газар өмчлүүлэх, тариалангийн газрыг урт хугацааны гэрээгээр ашиглуулах, бэлчээрийн хамтын менежмент нэвтрүүлэх (төсөл 4), Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх (төсөл 22), сумын байгаль орчны байдлын үнэлгээ хийх, зөвлөмж боловсруулах (төсөл 1) төслийн үр дүнг ашиглах, харилцан зохицуулсан арга хэмжээ хэрэгжүүлэхэд энэхүү төлөвлөгөө суурь баримт бичиг болж өгөх юм. Төлөвлөгөөтэй болсноор бизнес хөгжих орчныг сайжруулах талаар төрийн зүгээс үзүүлэх үйлчилгээ, дэмжлэгийг сайжруулахад чухал алхам хийгдэнэ.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй болно.
- Газар ашиглалтыг эдийн засгийн стратегийн бусад төслүүдтэй холбох, уялдуулах боломж сайжирна

**Зорилтот бүлэг:**
- ЗДТГ

**Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**
- ЗДТГ

**Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**
- Хандивлагчид
- Аймгийн газрын алба

**Зэхэц, урьдал нөхцлүүд:**
- Эдийн засгийн хөгжлийн стратегийн холбогдох төслүүд хэрэгжих боломжтой байх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:**
- Төсвийн санхүүжилт олдохгүй байх

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** 12.0

- Газрын өмчлөл, ашиглалт, эзэмшлийн бүртгэл гаргаж, одоогийн байдлыг тогтоох – 3.4
- Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах – 0.7
- Сумын газар зохион байгуулалтын зураг шинэчлэх, хэвлүүлэх – 4.5
- Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, шинэчлэгдсэн зураглалтай холбогдох асуудлаар сургалт, сурталчилгаа явуулах – 0.6
- Олон нийтэд зориулсан сургалтын материал, гарын авлага, сурталчилгааны материал бэлтгэх, хэвлүүлэх – 0.8

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2007–2008 онд 6 сар

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа тогтвортой мөрдөгдөнө.

| №29 | **Төсөл:** 3о5:3т1:Хө1:Т2: Сум, багийн төр, захиргааны байрын засвар, өргөтгөл, тохижилт | **Хөтөлбөр:** 3о5:3т1:Хө1: Төрийн болон захиргааны үйлчилгээг сайжруулах боломж бүрдүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Эдүгээ сумын ИТХ-ийн тэргүүлэгчид, ЗДТГ байрлах үйл ажиллагаа явуулж буй барилгад олон жил дотоод ба гадаад засвар хийгдээгүй, халаалт, цахилгааны шугам шинэчлээгүй олон жил өнгөрч байна. Мөн багуудын төв ч төрийн үйлчилгээ явуулах шаардлагыг хангахгүй байгаа билээ. Эдийн засгийн стратегийн хүрээнд нэг цэгийн үйлчилгээ нэвтрүүлэх, сумын төвийн халаалт, цахилгааны сүлжээг шинэчлэх, гэрэлтүүлгийг сайжруулах зэрэг хэд хэдэн төсөл хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд энэ ажлын хүрээнд сум, багийн орон нутгийн төр, захиргааны байрын засвар, өргөтгөл, тохижуулах ажлыг зэрэгцүүлэн гүйцэтгэх нь үр дүнтэй болно гэж үзэж байна. Нутгийн захиргааны байрын нөхцлийг сайжруулснаар төрийн үйлчилгээний чанар, үр өгөөж, хүртээмжийг дээшлүүлнэ.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Төрийн албаны имидж, төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл сайжрах<br>• Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний нөхцөл дээшлэх<br>• Төрийн үйлчилгээний шинэ хэлбэрүүд нэвтрүүлэх боломж нэмэгдэх | • ЗДТГ<br>• Сумын иргэд |
| **Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**<br>• ЗДТГ<br>• Багууд | **Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**<br>• Засгийн газар<br>• Хандивлагчид |
| **Зэхэц, урьдал нөхцлүүд:**<br>• Шинэ барилга, барилгын засварын зураг, төсөв хийх<br>• Улсын төсвөөс гаргах хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлсэн байх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:**<br>• Улсын төсөвт хөрөнгө тусгагдахгүй байх |

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** **130.0**

- Сумын ИТХ, ЗДТГ-ын барилгын өргөтгөл – 100.0
- Сумын ИТХ, ЗДТГ-ын ажлын байрны нөхцлийг сайжруулах – 19.0
- Хөдөөгийн 4 багийн албан конторын засвар, тохижилт – 9.0
- Гадаад орчны тохижилт – 2.0

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2007-2011 онд | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа үр дүн байнгын тогтвортой ашиглагдана. |
|---|---|

| №30 | **Төсөл:** Зо5:Зт1:Хө1:Т3: Сумын төвийн гудамж, хорооллын гэрэлтүүлэг, хаягжуулалт, зам, замын тэмдгийг сайжруулах | **Хөтөлбөр:** Зо5:Зт1:Хө1: Төрийн болон захиргааны үйлчилгээг сайжруулах боломж бүрдүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сумын албан ба бизнесийн байгууллага, орон сууц, гэр хорооллын гудамжийг хаягжуулах явдал зөвхөн төвийн өнгө үзэмжийг сайжруулна гэж үздэг нь өрөөсгөл юм. Эдийн засгийн хөгжлийн шинэ стратегийн хүрээнд газар ашиглалт, үйлчилгээний шинэ нэгдсэн цогцолбор, хүнсний зах байгуулах, үйлдвэр үйлчилгээний ЖДҮ байгуулахад дэмжлэг үзүүлэх олон арга хэмжээ хэрэгжүүлэхэд анхнаасаа зохион байгуулалттай хандах, эмх цэгцийг сайжруулахад хаягжилт онцгой ач холбогдолтой юм. Сумын төвийн объектуудын байршлыг буулгасан хар зураглал гаргах, төвийн хөгжлийн хэтийн төлөвлөгөөний үндэслэлийн дагуу гудамж гаргах, хаягжуулах ажил хийгдэхээс гадна автозамыг тэмдэгжүүлнэ. Сумын төвийн гудамж, гэр хорооллыг хаягжуулж, замын тэмдэгтэй болсноор төвийн барилгажсан ба суурьшсан хэсгийг цаашид өргөтгөх, тохижуулах арга хэмжээг хаягаар төлөвлөх, хэрэгжүүлэх боломж бүрдэхээс гадна автомашины хөдөлгөөнийг хязгаарлаж, сумын төвийн хөрсний элэгдэл, тоосжилтыг бууруулж, орчны байгалийн нөхөн сэргэлтийг дэмжинэ. Хөрөнгө санхүүгийн олдоц, хэмжээ зэргээс хамааруулан энэхүү төслийг гэрэлтүүлэг, хаягжуулалт, замын тэмдэг, тэмдэглээг шинэчлэх гэх мэтээр хэсэгчлэн хэрэгжүүлэх боломжтой.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Төвийн өнгө үзэмж сайжирна<br>• Замын тэмдэг, тэмдэглэгээгээр сумын төвийн дотор болон орчимд автомашины хөдөлгөөний чиглэлийг зохицуулна<br>• Сумын төвийн барилгажсан ба суурьшмал хэсгийн хөрсний элэгдэл буурч, нөхөн сэргээх, зүлэгжүүлэх, цэцэрлэгжүүлэлтийн ажлын үр өгөөж дээшлэх боломж бүрдэнэ. | • ЗДТГ<br>• Сумын төвийн иргэд |
| **Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**<br>• ЗДТГ | **Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**<br>• Хандивлагчид |
| **Зэхэц, урьдал нөхцлүүд:**<br>• Зураг, төсөв хийх<br>• Улсын төсвөөс гаргах хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлсэн байх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** **25.0**

- Сумын төвийн барилгажсан хэсгийн тойм зураг хийх – 3.5
- Сумын төвийн гудамж, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийг шинэчлэх – 12.5
- Сумын төвийн гудамж, орон сууц, гэр хорооллын хаягжуулалт – 3.0
- Автозамын тэмдэг, тэмдэглэгээ шинээр хийх – 3.5
- Автозамын хамгаалалт барих – 1.5

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 24 сар | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа үр дүн байнга тогтвортой ашиглагдана. |
|---|---|

<table>
<tr><td>№31</td><td>Төсөл: Зо5:Зт1:Хө1:Т4: Төрийн албанд ажиллагсдын орон сууцны хангамжийг сайжруулах</td><td>Хөтөлбөр: Зо5:Зт1:Хө1: Төрийн болон захиргааны үйлчилгээг сайжруулах боломж бүрдүүлэх</td></tr>
<tr><td colspan="3">Төслийн товч тодорхойлолт: Төрийн албан хаагчдын тогтвортой ажиллах баталгаа бий болгох үүднээс тохилог орон сууцаар хангах асуудлыг тэргүүн ээлжинд авч үзэх шаардлагатай юм. “40000 орон сууц” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 32 айлын орон сууц барьж ашиглалтад оруулахад төслийг чиглүүлнэ.</td></tr>
<tr><td colspan="2">Хүлээгдэж буй үр дүн:<br>• Төрийн албан хаагчдын орон сууны хангамж сайжирч, амьжиргааны түвшин дээшлэх<br>• Тогтвортой үр бүтээлтэй ажиллах баталгаагаар хангагдах нөхцөл сайжрах</td><td>Зорилтот бүлэг:<br>• ЗДТГ<br>• Төрийн албан хаагчид</td></tr>
<tr><td colspan="2">Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:<br>• ЗДТГ</td><td>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:<br>• Засгийн газар</td></tr>
<tr><td colspan="2">Зэхэц, урьдал нөхцлүүд:<br>• Газрын асуудлыг шийдвэрлэх<br>• Байр худалдан авах хөрөнгө (зээл)-ийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байх<br>• Дэд бүтэцтэй холбох зураглал хийгдсэн байх</td><td>Эрсдэлтэй хүчин зүйлс:<br>• Улсын төсөв хүрэлцэхгүй байх</td></tr>
<tr><td colspan="3">Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг: 240.0</td></tr>
<tr><td colspan="3">Холбоо барих байгууллага, хүн: Тариалан сумын ЗДТГ</td></tr>
<tr><td colspan="2">Хэрэгжүүлэх хугацаа: 2009-2015 онд 6 жил</td><td>Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төсөл хэрэгжсэний дараа байнга тогтвортой ашиглагдана.</td></tr>
</table>

| №32 | **Төсөл:** Зо5:Зт1:Хө1:Т5: Нэг цэгийн үйлчилгээ нэвтрүүлэх | **Хөтөлбөр:** Зо5:Зт1:Хө1: Төрийн болон захиргааны үйлчилгээг сайжруулах боломж бүрдүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Төрийн үйлчилгээг шуурхай болгон, элдэв хүнд суртлыг арилгах арга зам бол иргэд, бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүд, сонирхсон хүмүүст үйлчлэх "Нэг цэгийн үйлчилгээ"-г шинээр нээж ажиллуулах явдал мөн болохыг туршлага нотолж байна. Бизнестэй холбоотой мэдээлэл, үйлчилгээ үзүүлэх, зөвлөх үйл ажиллагаа эрхлэх нь тус цэгийн үйл ажиллагаа байх болно. Төслөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны бүрэлдэхүүнд иргэдэд үйлчилдэг албан хаагчдыг нэг дор төвлөрүүлэх, компьютержуулах, нэгдсэн программ хангамжаар үйлчлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, дамжуулах үйлчилгээ зэрэг арга хэмжээ багтана. Бүх төрлийн үйлчилгээг нэг дороос авах таатай боломж бүрдэн, төрийн үйлчилгээний хөнгөн шуурхай байдлыг дээшлүүлэх боломж бүрдэх юм.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Төрийн үйлчилгээний чанар, хөнгөн шуурхай байдал дээшилнэ
- Бизнест холбогдолтой үйлчилгээ нэг газар төвлөрнө
- Хүнд суртал багасч ил тод байдал дээшилнэ
- Авилгал, хээл хахуульд өртөх явдал арилна

**Зорилтот бүлэг:**
- Нийт иргэд
- Бизнес эрхлэгчид
- ЗДТГ

Төсөлд хамргдах бүлэг, оролцогчид:
- ИТХ
- ЗДТГ

**Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**
- ЗДТГ
- Хандивлагчид
- Бизнес эрхлэгчид

**Зэхэц, урьдал нөхцлүүд:**
- Ажил явуулах байрын асуудлыг шийдвэрлэх
- Суурилуулах техник тоног төхөөрөмжтэй холбоотой мэдээлэл цуглуулах

**Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** **8.0**

- Нэг цэгийн үйлчилгээний зориулалтаар өрөө засварлаж өргөтгөх – 5.0
- Дулаан, гэрэлтүүлэг, халаалтын төхөөрөмжийг шинэчлэх – 1.0
- Дотоод тохижилтыг үйлчилгээний цэгийн маягаар шинэчлэх – 1.0
- Шаардлагатай зарим тоног төхөөрөмж, дотоод сүлжээ шинээр тавих – 1.0

**Холбоо барих байгууллага, хүн:** Засаг дарга С.Цолмон
Засаг даргын орлогч дарга Д.Гомбосүрэн

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2007-2008 онд

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэн дууссанаас хойш тогтвортой ажиллана.

| №33 | **Төсөл:** Зо5:Зт2:Хө1:Т1: Сумын төвийг дулааны нэгдсэн сүлжээнд хамруулах | **Хөтөлбөр:** Зо5:Зт2:Хө1: Сумын төвийн эрчим хүч, дулааны хангамжийг сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сумын төвийн дулааны шугам сүлжээнд хамрагдаагүйгээс байгууллагын хэвийн ажиллагаа, иргэдийн амьдралд таагүй нөлөө үзүүлдэг. Түүнчлэн одоогийн уурын зуухнууд ачааллаа даахгүйд хүрснээс сүлжээг цааш өргөтгөж, шинээр байгуулагдаж буй объектуудыг холбох боломжгүй болоод байна. Сумын төвийн дулааны шугам сүлжээг шинэчилж, төлөвлөгөөтэй өргөжүүлэх, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх боломжтой болгох, улмаар найдвартай ажиллагааг нь сайжруулахад төслийн зорилго оршино.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Дулааны шугам сүлжээний засвар үйлчилгээний зардал багасах<br>• Байгууллага, иргэд дулааны найдвартай эх үүсвэрээр хангагдах<br>• Дулааны төвлөрсөн шугамд шинэ барилга, объектийг холбох боломж нээгдэх | • ЗДТГ<br>• Сумын албан байгууллага, аж ахуйн нэгжүүд<br>• Сумын төвийн иргэд |
| **Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**<br>• ЗДТГ<br>• Мэргэжлийн байгууллагууд | **Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**<br>• Засгийн газар<br>• Хандивлагчид |
| **Зэхэц, урьдал нөхцлүүд:**<br>• Сумын төвийн дулааны шугам сүлжээний засварын зураг төсөв гаргах<br>• Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах | **Эрсдэлтэй хүчин зүйлс:**<br>• Санхүүжилтийн асуудал улсын төсөвт тусгагдахгүй байх |

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг:** **300.0**

- Сумын төвлөрсөн халаалтын нам даралтын зуух шинээр суурилуулах – 50.0
- Сумын төвийн албан ба бизнесийн байгууллагуудыг холбосон дулааны шугамын шинэчлэл – 250.0

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2010–2013 онд | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төслийн дараа үр дүн тогтвортой байна. |
|---|---|

| №34 | **Төсөл:** Зо5:Зт2:Хө1:Т2: Сумын төвийн цахилгааны шугам сүлжээний шинэчлэл | **Хөтөлбөр:** Зо5:Зт2:Хө1: Сумын төвийн эрчим хүч, дулааны хангамжийг сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сумын төвийн цахилгааны шугам сүлжээнд олон жил засвар үйлчилгээ хийгээгүйгээс шугамын утас, дамжуулах байгууламжууд муудаж, цахилгааны алдагдал, доголдол гарах, хүчдэл тогтворгүйтэх, гал түймэр үүсэх аюултай болжээ. Энэ нь аж ахуйн нэгж байгууллагын хэвийн ажиллагаа, иргэдийн амьдралд таагүй нөлөөлж, сүлжээг цааш өргөтгөх боломжгүй болгож байна. Сумын төвийн цахилгааны шугам сүлжээний найдвартай ажиллагааг бүрдүүлэхэд энэхүү төслийн зорилго оршино. Уг төслөөр хэрэгжүүлэх арга хэмжээнд сумын төвийн цахилгааны сүлжээг шинэчлэн засварлах, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлууд хамрагдах юм.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Цахилгааны шугам сүлжээний засвар үйлчилгээний зардал багасах
- Байгууллага, иргэдийг цахилгааны найдвартай эх үүсвэрээр хангах
- Цахилгааны шугам сүлжээг өргөтгөх боломж бүрдүүлэх

**Зорилтот бүлэг:**
- Сумын нийт иргэд
- Бизнес эрхлэгчид

**Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:**
- Засгийн газар
- ЗДТГ
- Эрчим хүчний байгууллага

**Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:**
- Засгийн газар
- Хандивлагчид

**Зэхэц, урьдал нөхцлүүд:**
- Сумын төвийн цахилгааны шугам сүлжээний засварын зураг төсөв гаргах
- Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах

**Эрсдэлтэй хүчин зүйлс:**
- Санхүүжилтийн асуудал улсын төсөвт тусгагдахгүй байх

**Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг: 50.0**

- Сумын төвийн өндөр хүчдэлийн шугам сүлжээний засвар – 10.0
- Шинээр трансформатор тавих – 30.0
- Гэр хорооллын шон солих – 6.0
- Шон хоорондын зайг нь ойртуулах – 4.0

**Холбоо барих байгууллага, хүн:** Тариалан сумын ЗДТГ

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2009–2010 онд нэг жил

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төслийн дараа үр дүн тогтвортой байна.

<table>
<tr><td>№35</td><td>Төсөл: Зо3:Зт3:Хө1:Т3: Сумын төвийн гэрэлтүүлгийг сайжруулах</td><td colspan="2">Хөтөлбөр: Зо5:Зт2:Хө1: Сумын төвийн эрчим хүч, дулааны хангамжийг сайжруулах</td></tr>
<tr><td colspan="4">Төслийн товч тодорхойлолт: ДЕЛТА төслийн дэмжлэгтэйгээр боловсруулсан “Сумын эдийн засгийн хөгжлийн стратеги” баримт бичигт тусгагдсан төслүүдийг хэрэгжүүлснээр сумын төвийн өнгө төрх урьдынхаас эрс өөрчлөгдөн шинэчлэгдэх болович сумын төвийнхээ гол гудамжны гэрэлтүүлгийг орчин цагийн тосгоны хэмжээнд шинэчилбэл бусад ажлын үр дүнтэй илүү нийцэх билээ. Албан байгууллага, бизнесийн нэгжүүд, орон сууцны гудамж болон гэр хороолол гэрэл тавих замаар сумын төвийн гэрэлтүүлгийг бүхэлд нь сайжруулах, үүний тулд эрчим хүч түгээх шугамыг шинэчлэх, гэрлийн суурь суулгах, шинээр шугам нэмж татах зэрэг нэлээд ажил хийгдэнэ. Энэ төслийг сумын төвийг хаягжуулах, замын тэмдэгжүүлэх төсөлтэй уялдуулж хэрэгжүүлэх шаардлагатай</td></tr>
<tr><td colspan="3">Хүлээгдэж буй үр дүн:<br>• Сумын төвийн гэрэлтүүлэг сайжирна<br>• Эрчим хүч түгээх сүлжээний найдвартай ажиллагаа сайжрах</td><td>Зорилтот бүлэг:<br>• ЗДТГ<br>• Албан байгууллага, аж ахуйн нэгжүүд<br>• Сумын төвийн иргэд</td></tr>
<tr><td colspan="3">Төсөлд хамрагдах бүлэг, оролцогчид:<br>• ЗДТГ<br>• Албан байгууллага, аж ахуйн нэгжүүд<br>• Эрчим хүчний байгууллага</td><td>Төсөлд хувь нэмэр оруулах боломжит этгээд:<br>• Засгийн газар<br>• Хандивлагчид</td></tr>
<tr><td colspan="3">Зэхэц, урьдал нөхцлүүд:<br>• Гэрэлтүүлэг сайжруулах ажлын зураг, төсөв зохиох<br>• Санхүүгийн, эд материалын ба хүн хүчний талаар сумаас оруулах нэмрийг тогтоосон байх</td><td>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</td></tr>
<tr><td colspan="4">Шаардагдах санхүүжилт, дүн, сая төгрөг: 30.0</td></tr>
<tr><td colspan="4">• Сумын төвийн гэрэлтүүлгийн зураглал, төлөвлөгөө боловсруулах – 1.5<br>• Гол гудамж, үзвэр үйлчилгээний газрын орчимд сайжруулсан гэрэлтүүлэг тавих – 22.5<br>• Барилгажсан хэсэг ба гэр хорооллын хооронд шөнийн гэрэлтүүлэг тавих – 6.0</td></tr>
<tr><td colspan="4">Холбоо барих байгууллага, хүн: Тариалан сумын ЗДТГ</td></tr>
<tr><td colspan="2">Хэрэгжүүлэх хугацаа: 2008 оноос нэг жил</td><td colspan="2">Төслийн үр дүнгийн тогтворжилт: Төсөл хэрэгжсэний дараа тогтвортой үргэлжилнэ.</td></tr>
</table>